



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДАГЫН АЛБА

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2023 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улаанбаатар хот
2024 он



Бэлтгэсэн: Статистикийн сангийн эрхлэгч, цагдаагийн хошууч С.Энхбаатар
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Э.Батгэрэл
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Уянга
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Хулангоо
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Н.Атарчимэг
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Балжин
Мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Тамир
Мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч М.Ганзул

Хянасан: Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дарга,
цагдаагийн хурандаа П.Батбаатар
Статистик, мэдээллийн хэлтсийн дарга,
цагдаагийн дэд хурандаа Д.Жанчивдорж

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хуулбарлах, хэвлэн олшруулахыг хориглоно.



ӨМНӨТГӨЛ

Тус албанаас цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын статистик мэдээ, мэдээллийг нэгтэн боловсруулж, цуврал байдлаар эмхэтгэл болгон жил бүр эрхлэн гаргадаг билээ.

Цагдаагийн байгууллагаас мэдээллийн санг бодит мэдээллээр тухай бүр бүрдүүлэх, ашиглах түүнд шинжлэх ухааны үндэслэлтэй дүн шинжилгээ, судалгаа хийж үйл ажиллагаандаа ашиглах нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг амжилттай зохион байгуулах, улмаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын гол үндэс юм.

Энэ удаагийн цуврал эмхэтгэлийг цагдаагийн байгууллагын цахим хуудас /<https://police.gov.mn>/-д байршуулж, сүүлийн 5 жилийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын эмхэтгэлийн хамтаар байршуулж, хэрэглэгчдэд нээлттэй нэвтрэх боломжийг бүрдүүлэн цахим ном хэлбэрээр олны хүртээл болгож байгаагаараа онцлог юм.

Ингэснээр гэмт хэрэг, зөрчил, гэмт явдлын төлөв, шалтгаан нөхцөлийг бодитоор үнэлж тогтоох, нийт нутаг дэвсгэрийн болон тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил, түүний илрүүлэлт, онцлог, хохирогч болон холбогдогч, учирсан хохирол зэргийг харьцуулан судлах боломжийг эрдэмтэн судлаач, хууль эрх зүйн чиглэлээр суралцаж буй оюутан болон бодлого боловсруулах, шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, алба хаагчдад нэн хэрэгцээтэй мэдээллийн бодит эх сурвалж болно гэдэгт итгэлтэй байна.

Мөн тус албанаас Монгол Улсын хэмжээнд өнгөрсөн 13 жилд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн статистик мэдээлэл, хүн амын тоо, шилжилт хөдөлгөөн, боловсрол, эрүүл мэнд, хатуу болон зөөлөн дэд бүтэц, дотоодын нийт бүтээгдэхүүн, нийгэм, эдийн засаг, инфляц, гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ, валютын ханш, ажилгүйдэл, ядуурлын түвшин, согтууруулах ундааны хэрэглээ зэрэг 120 гаруй хувьсагчид тулгуурлан 2040 он хүртэлх хугацаанд жилд үйлдэгдэж болзошгүй гэмт хэргийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор Системийн динамик загварчлалд оруулан түршилт (симуляц) хийлээ.

Дээрх аргачлалаар 2023-2040 оны хооронд Монгол Улсад үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг жилд дунджаар 3.6 хувиар өсөж болзошгүй төлөвтэй байна. Иймд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажилд нь бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэн бүрийн оролцоо чухал бөгөөд цагдаагийн байгууллага зөвхөн нэг хэсэг нь гэдгийг онцлон дурдмаар байна.

Энэхүү эмхэтгэлийг бэлтгэхэд гэмт хэрэг, зөрчлийн талаарх анхан шатны бодит мэдээ, мэдээллийг цаг алдалгүй бүрдүүлж байдаг цагдаагийн байгууллагын мэдээлэл судалгааны ажил хариуцсан алба хаагч болон Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас баримталж буй бодлого, үйл ажиллагааг байнга дэмжин ажиллаж байдаг нийт алба хаагч, хамтран ажиллагч байгууллага, хамт олонд талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ,
ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

П.БАТБААТАР



ГАРЧИГ

ГАРЧИГ	4
НЭГ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	5
ХОЁР. НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	14
ГУРАВ. ОРОН НУТАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ	64
ДӨРӨВ. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ	175
4.1 Хүнийг алах гэмт хэрэг	175
4.2 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	178
4.3 Хүчиндэх гэмт хэрэг	181
4.4 Хулгайлах гэмт хэрэг	184
4.5 Хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг	187
4.6 Халаасны хулгайн гэмт хэрэг	190
4.7 Мал хулгайлах гэмт хэрэг	193
4.8 Дээрэмдэх гэмт хэрэг	196
4.9 Залилах гэмт хэрэг	199
4.10 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг	202
4.11 Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	204
4.12 Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг	207
4.13 Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг	210
4.14 Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг	214
ТАВ. ГЭМТ ХЭРГИЙН ОНЦЛОГ, НӨХЦӨЛ БАЙДАЛ	217
5.1 Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг	217
5.2 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил	220
5.3 Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг	224
5.4 Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг	228
5.5 Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг	232
ЗУРГАА. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮНИЙ ОНЦЛОГ	236
6.1 Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг	236
6.2 Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэрэг	239
6.3 Гадаадын иргэнээс үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил	242



НЭГ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Хүлээн авч шалгасан гомдол, мэдээлэл.

Цагдаагийн байгууллага 2023 онд иргэн, аж ахуйн нэгжээс 668.829 дуудлага мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 309.060 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс 512 буюу 0.2 хувиар буурч, гэмт хэргийн шинжтэй 101.719 (32.9%), зөрчлийн шинжтэй 199.441 (64.5%) гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байна.



Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 7900 буюу 2.6 хувь нь шийдвэрлэгдээгүй байна.

Хоёр. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

2.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

-Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 35574, Улаанбаатар хотод 24978 (70.2%), орон нутагт 10576 (29.7%), бусад газар (хилийн чанадад) үйлдэгдсэн 20 (0.1%) гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад:

- Улсын хэмжээнд нийт 234 хэрэг буюу 0.7%,
- Нийслэлийн хэмжээнд 668 хэрэг буюу 2.7%,
- Бусад газар (хилийн чанадад)-т 9 хэрэг буюу 81.8%-иар тус тус өсч,
- Орон нутгийн хэмжээнд 443 хэрэг буюу 4.0%-аар буурсан байна.

Нийт бүртгэгдсэн хэргийн 31589 буюу 88.8 хувь нь хөнгөн, 3985 буюу 11.2 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 961 буюу 3.1 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 727 буюу 15.4 хувиар буурсан байна.

УЛСЫН ХЭМЖЭЭНД

35574 +0.7%

НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД


24978 +2.7%

ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД


10576 -4.0%



Сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг.




2.2. 2023 онд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Орон нутагт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 761 буюу 7.2 хувийг Орхон аймагт, 726 буюу 6.9 хувийг Сэлэнгэ аймагт, 725 буюу 6.9 хувийг Өмнөговь аймагт, нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 6130 буюу 24.5 хувийг Баянзүрх дүүрэгт, 4456 буюу 17.8 хувийг Баянгол дүүрэгт, 3974 буюу 15.9 хувийг Хан-Уул дүүрэгт тус тус бүртгэгдсэн нь хамгийн их байна.



2.3. Сүүлийн 12 сард бүртгэгдсэн гэмт хэрэг (сараар).




2.4. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	532	573	7.7	1.6
	Үүнээс: Хүнийг алах	199	199	0.0	0.6
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	9325	8531	-8.5	24.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	98	126	28.6	0.4
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	678	728	7.4	2.0
	Үүнээс: Хүчиндэх	550	564	2.5	1.6
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	238	357	50.0	1.0
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	4	1	-75.0	0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	35	39	11.4	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	54	68	25.9	0.2
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	21493	21686	0.9	61.0
	Хулгайлах	6077	5401	-11.1	15.2
	Дээрэмдэх	485	392	-19.2	1.1
	Залилах	11839	12985	9.7	36.5
	Малын хулгай	778	643	-17.4	1.8
9	Эдийн засгийн гэмт хэрэг	162	200	23.5	0.6
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	2	-	0.0
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	359	686	91.1	1.9
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	94	125	33.0	0.4
13	Авлигын гэмт хэрэг	13	13	0.0	0.03
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	296	400	35.1	1.1
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	559	472	-15.6	1.3
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	9	12	33.3	0.03
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	259	388	49.8	1.1
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1220	1280	4.9	3.6
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	1214	1279	5.4	3.6
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	10	13	30.0	0.03
20	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-





2.5. Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл.



- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (61.0%)
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (24.0%)
- Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (3.6%)
- Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (2.5%)
- Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (1.6%) Бусад (8.2%)

Өмчлөх эрхийн эсрэг, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 85.0 хувийг эзэлж байна.

2.6. Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.





Үзүүлэлт	2022 он	2023 он	Зөрүү		Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
			Тоо	Хувь	
Цаг					
06:00-14:00	10696	11649	953	8.9	32.7
14:00-19:00	11023	11344	321	2.9	31.9
19:00-22:00	5029	4576	-453	-9.0	12.9
22:00-06:00	8592	8005	-587	-6.8	22.5
Гараг					
Даваа	5335	5499	164	3.1	15.5
Мягмар	5360	5518	158	2.9	15.5
Лхагва	5231	5369	138	2.6	15.1
Пүрэв	5079	5121	42	0.8	14.4
Баасан	5577	5349	-228	-4.1	15.0
Бямба	4407	4415	8	0.2	12.4
Ням	4351	4303	-48	-1.1	12.1
Газар					
Гэр, орон сууц	12449	11127	-1322	-10.6	31.3
Бусад газар	7129	8989	1860	26.1	25.3
Гудамж талбай	6949	6552	-397	-5.7	18.4
Олон нийтийн газар	3634	3333	-301	-8.3	9.4
Аж ахуйн нэгж	3109	3610	501	16.1	10.1
Авто зам	1192	1247	55	4.6	3.5
Төрийн байгууллага	525	360	-165	-31.4	1.0
Төрийн бус байгууллага	188	208	20	10.6	0.6
Нийтийн тээвэр	165	148	-17	-10.3	0.4

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 11649 буюу 32.7 хувь нь 06:00-14:00, 11344 буюу 31.9 хувь нь 14:00-19:00, 5518 буюу 15.5 хувь нь мягмар, 5499 буюу 15.5 хувь нь даваа гарагт, 11127 буюу 31.3 хувь нь гэр, орон сууцанд, 6552 буюу 18.4 хувь нь гудамж, талбайд тус тус бүртгэгдсэн байгаа нь хамгийн их байна.

Өмнөх оноос 06:00-14:00 цагт бүртгэгдсэн гэмт хэрэг 8.9 хувиар, 14:00-19:00 цагт бүртгэгдсэн гэмт хэрэг 2.9 хувиар, мягмар гарагт бүртгэгдсэн гэмт хэрэг 2.9 хувиар, даваа гарагт бүртгэгдсэн гэмт хэрэг 3.1 хувиар тус тус өссөн бол гэр, орон сууцанд бүртгэгдсэн гэмт хэрэг 10.6 хувиар, гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 5.7 хувиар тус тус буурсан байна.

2.7. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 4979 буюу 14.0 хувь нь согтуугаар, 5990 буюу 16.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 1479 буюу 4.2 хувь нь бүлэглэн, 1270 буюу 3.6 хувь нь хүүхэд оролцож, 1415 буюу 4.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 9270 буюу 26.1 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.





Гурав. Гэмт хэргийн илрүүлэлт.


3.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Улсын хэмжээнд 57.1 хувь, нийслэлд 55.6 хувь, орон нутагт 61.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 2.9 нэгжээр, нийслэлд 3.6 нэгжээр, орон нутагт 1.2 нэгжээр тус тус өссөн байна.

3.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 31474 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 1574 хэрэг буюу 5.3, үүнээс 17976 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 1767 буюу 10.9 хувиар тус тус өссөн.

3.3. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдэгдээгүй 13498 гэмт хэрэг.




Дөрөв. Гэмт хэрэгт холбогдогч.

4.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 24134 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 469 буюу 2.0 хувиар өссөн.

Холбогдогчдын 5021 буюу 20.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оноос 551 буюу 12.3 хувиар, 1594 буюу 6.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 54 буюу 3.5 хувиар тус тус өсч, 19113 буюу 79.2 хувийг эрэгтэй хүн эзэлж байгаа нь 82 буюу 0.4 хувиар буурсан байна.





4.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс.



Нийт гэмт хэрэгт холбогдогчдын 25.9 хувь нь 18-24 насны, 18.9 хувь нь 25-29 насны залуучууд байгаа бол 53.6 хувь нь ажилгүй, 3921 буюу 16.3 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна. Гадаадын 41 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 12 буюу 22.6 хувиар буурсан байна.

Тав. Гэмт хэргийн хохирогч, хохирлын хэмжээ.

5.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 35292 хүн, 106 хуулийн этгээд хохирч, үүнээс 848 хүн нас барж, 9681 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал нийт хохирогч 72 буюу 0.2, хуулийн этгээд 19 буюу 21.8 хувиар, нас барсан хүн 82 буюу 10.7 хувиар тус тус өсч, гэмтсэн хүн 629 буюу 6.1 хувиар буурсан байна.



5.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 449.1 тэрбум төгрөгийн хохирлын 211.5 тэрбум төгрөг буюу 47.1 хувийг нөхөн төлүүлж, 6.9 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 101.2 тэрбум төгрөг буюу 29.1 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 28.2 тэрбум төгрөг буюу 15.4 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 1.2 тэрбум төгрөг буюу 22.1 хувиар тус тус өссөн байна.




Зургаа. Зөрчил.

6.1. Нийт бүртгэгдсэн зөрчил.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 3.214.414 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 509.623 буюу 18.8 хувиар, 3.209.611 зөрчлийг шийдвэрлэсэн нь 507.838 буюу 18.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

6.2 Бүртгэгдсэн зөрчлийн ангилал.



6.3. Шийдвэрлэлт.

Зөрчил гаргасан 3.090.753 иргэн, 66.608 хуулийн этгээдийг 95.8 тэрбум төгрөгөөр торгох, 18.558 хүнийг баривчлуулах, 33.692 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус оногдуулсан байна.

Торгосон хүн	2022 он	2023 он	Зөрүү
	2.561.390	3.090.753	+20.7%
Хуулийн этгээд	75.401	66.608	-11.7%
Торгуулийн хэмжээ /тэрбум төгрөг/	92.0	95.8	+4.1%
Баривчлуулсан	18.931	18.558	-2.0%
Торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан	46.051	33.692	-26.8%



6.4. Соггууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх үйл ажиллагаа.

14156 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 49723 буюу 77.8 хувиар буурсан. Эрүүлжүүлэгдсэн хүний 9890 буюу 69.9 хувь нь Улаанбаатар хотод, 4266 буюу 30.1 хувь нь орон нутагт эрүүлжүүлэгдсэн бөгөөд нийт 32422 хүнийг саатуулсан.

6.5. Сүүлийн 10 жилд эрүүлжүүлэгдсэн хүний тоо.



Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 13033 буюу 92.1 хувь нь эрэгтэй, 1123 буюу 7.9 хувь нь эмэгтэй, 22 буюу 0.2 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байна.

Архины албадан эмчилгээнд 324 хүн, сайн дурын эмчилгээнд 522 хүнийг хамруулсан байна.

---oooOooo---



ХОЁР. НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн хэмжээнд 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 217.793 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 79195 буюу 36.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 138.598 буюу 63.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх онтой харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 2870 буюу 1.3 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 8434 буюу 5.7 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 5564 буюу 7.6 хувиар өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 15518 буюу 19.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 59329 буюу 74.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 437 буюу 0.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 72017 буюу 52.0 хувийг зөрчлийн хэрэг нээж, 64866 буюу 46.8 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 151 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 24.978 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 668 буюу 2.7 хувиар өсч, улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 70.2 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 15.497, сард 1291, хоногт 43, цагт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сүүлийн 20 жилээр:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.



Д/д	Дүүрэг	2022 он	2023 он	Өсөлт, бүүралт	
				Тоо	Хувь
1	Баянгол	4523	4456	-67	-1.5
2	Баянзүрх	6293	6130	-163	-2.6
3	Сүхбаатар	3626	3832	206	5.7
4	Сонгинохайрхан	3290	3385	95	2.9
5	Хан-Уул	3179	3974	795	25.0
6	Чингэлтэй	2848	2666	-182	-6.4
7	Багануур	201	188	-13	-6.5
8	Багахангай	21	20	-1	-4.8
9	Налайх	329	327	-2	-0.6



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 22846 буюу 91.5 хувь нь хөнгөн, 2132 буюу 8.5 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 1120 буюу 5.2 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 452 буюу 17.5 хувиар буурсан байна.

1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.



Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	315	379	20.3	1.5
	Үүнээс: Хүнийг алах	103	121	17.5	0.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5787	5207	-10.0	20.8
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	40	59	47.5	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	344	364	5.8	1.5
	Үүнээс: Хүчиндэх	285	287	0.7	1.1
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	193	275	42.5	1.2
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	3	-	-	0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	26	24	-7.7	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	46	47	2.2	0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	16087	16736	4.0	67.0
8	Үүнээс: Хулгайлах	4179	3618	-13.4	14.5
	Дээрэмдэх	396	310	-21.7	1.2
	Залилах	9810	11220	14.4	44.9
	Мал хулгайлах	36	38	5.6	0.2
9	Эдийн засгийн гэмт хэрэг	131	142	8.4	0.6
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	2	-	0.0
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	297	483	62.6	1.9
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	58	97	67.2	0.4
13	Авлигын эсрэг гэмт хэрэг		2		0.0
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	145	201	38.6	0.8
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	45	77	71.1	0.3
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	5	7	40.0	0.0
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	231	350	51.5	1.4
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	595	581	-2.4	2.3
18	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	593	581	-2.0	2.3
	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	2	4	2.0 дах	0.0

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 3805 буюу 15.2 хувь нь даваа гарагт, 3854 буюу 15.4 хувь нь мягмар гарагт, 3825 буюу 15.3 хувь нь лхагва гарагт, 3589 буюу 14.4 хувь нь пүрэв гарагт, 3839 буюу 15.4 хувь нь баасан гарагт, 3095 буюу 12.4 хувь нь бямба гарагт, 2971 буюу 11.9 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 9106 буюу 36.5 хувь нь 06:00-14:00, 8208 буюу 32.9 хувь нь 14:00-19:00, 2918 буюу 11.7 хувь нь 19:00-22:00, 4746 буюу 19.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



Бүртгэгдсэн гэмт хэрийг байршил газраар нь авч үзвэл нийт гэмт хэргийн 7638 буюу 30.6 хувь нь гэр орон сууцанд, 5431 буюу 20.7 хувь нь гудамж талбайд, 2577 буюу 10.3 хувь нь олон нийтийн газарт, 119 буюу 0.5 хувь нь нийтийн тээвэрт, 164 буюу 0.7 хувь нь төрийн байгууллагад, 133 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 3079 буюу 12.3 хувь нь аж ахуйн нэгжид, 605 буюу 2.4 хувь нь авто замд, 5232 буюу 22.0 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 2165 буюу 8.7 хувь нь согтуугаар, 4817 буюу 19.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 844 буюу 3.4 хувь нь бүлэглэн, 791 буюу 3.2 хувь нь хүүхэд оролцож, 738 буюу 3.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 7823 буюу 31.3 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

Д/д	Дүүрэг	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн	Цахим орчинд
1	Баянгол	226	61	1070	43	139		1501
2	Баянзүрх	515	307	1627	171	141	1	2597
3	Сүхбаатар	369	110	500	94	162	3	775
4	Сонгинохайрхан	332	177	484	247	168		559
5	Хан-Уул	264	54	497	68	140	1	1237
6	Чингэлтэй	282	62	510	69	69	1	1022
7	Багануур	73	5	20	16	8		29
8	Багахангай	8	1	5	1			3
9	Налайх	96	14	104	29	17		100
	Нийт	2165	791	4817	738	844	6	7823



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 10025 буюу 40.1 хувь нь далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 55.6 хувьтай байгаа нь өмнөх оноос 3.6 нэгжээр өссөн.

Улсын хэмжээний гэмт хэргийн илрүүлэлттэй харьцуулахад 1.5 нэгжээр бага байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 23540 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 1581 хэрэг буюу 7.2 хувиар, үүнээс 13093 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 1680 буюу 14.7 хувиар тус тус өссөн байна.




Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 15614 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 798 буюу 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Холбогдогчдын 3991 буюу 25.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оноос 612 буюу 18.1 хувиар, 11623 буюу 74.4 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 186 буюу 1.6 хувиар тус тус өссөн байна. Харин 910 буюу 5.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оноос 67 буюу 6.9 хувиар буурсан байна.

3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.






Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 24626 иргэн, 64 хуулийн этгээд хохирч, үүнээс 394 хүн нас барж, 5624 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 727 буюу 3.0 хувиар, нас барсан хүн 62 буюу 18.7 хувиар тус тус өсч, гэмтсэн хүн 504 буюу 8.2 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 374.2 тэрбум төгрөгийн хохирлын 43.6 хувийг нөхөн төлүүлж, 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 90.1 тэрбум төгрөг буюу 31.8 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 5.4 тэрбум төгрөг буюу 3.4 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 3.1 тэрбум төгрөг буюу 3.6 дахин тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн хэмжээнд нийт 2.348.813 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 272.983 буюу 13.2 хувиар, 2.345.396 зөрчлийг шийдвэрлэсэн нь 271.345 буюу 13.1 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 2.146.107 буюу 91.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 81148 буюу 3.5 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 6197 буюу 0.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1020 буюу 0.04 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 114.341 буюу 4.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.





Зөрчил гаргасан 2.253.238 иргэн, 66.405 хуулийн этгээдийг 64698.9 сая төгрөгөөр торгох, 8266 хүнийг баривчлуулах, 17.487 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос торгуулсан иргэн 290.677 буюу 14.8 хувиар өсч, баривчлуулсан иргэн 899 буюу 9.8 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасуулсан иргэн 9695 буюу 35.7 хувиар тус тус буурсан байна.

Нийслэлийн хэмжээнд нийт 9890 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 41707 буюу 80.8 хувиар буурсан байх бөгөөд дурдсан хугацаанд 30767 хүнийг саатуулсан байна.

---oooOooo---



2.1. БАЯНГОЛ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн Баянгол дүүргийн цагдаагийн газар нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 34268 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 14458 буюу 42.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 19810 буюу 57.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 728 буюу 2.1 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 1904 буюу 8.8 хувиар тус тус буурсан бол гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 1176 буюу 8.9 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 2501 буюу 17.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 11097 буюу 76.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 82 буюу 0.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 10149 буюу 51.2 хувийг зөрчлийн хэрэг нээж, 9391 буюу 47.4 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 39 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Тус дүүрэгт нийт 4456 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 67 буюу 1.5 хувиар буурсан байх бөгөөд нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 17.8 хувийг эзэлж байна.

Тус дүүрэгт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/

Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт		Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	1-р хороо	162	238	76	46.9	18	18-р хороо	196	154	-42	-21.4
2	2-р хороо	325	306	-19	-5.8	19	19-р хороо	142	152	10	7.0
3	3-р хороо	276	217	-59	-21.4	20	20-р хороо	324	206	-118	-36.4
4	4-р хороо	376	253	-123	-32.7	21	21-р хороо	50	290	240	5.8 дах
5	5-р хороо	218	171	-47	-21.6	22	22-р хороо	98	103	5	5.1
6	6-р хороо	173	184	11	6.4	23	23-р хороо	43	48	5	11.6
7	7-р хороо	451	163	-288	-63.9	24	24-р хороо	77	114	37	48.1
8	8-р хороо	142	168	26	18.3	25	25-р хороо	67	181	114	2.7 дах
9	9-р хороо	97	113	16	16.5	26	26-р хороо	16	57	41	3.6 дах
10	10-р хороо	62	74	12	19.4	27	27-р хороо		25	25	
11	11-р хороо	174	119	-55	-31.6	28	28-р хороо		37	37	
12	12-р хороо	168	96	-72	-42.9	29	29-р хороо		140	140	
13	13-р хороо	121	136	15	12.4	30	30-р хороо		12	12	
14	14-р хороо	213	124	-89	-41.8	31	31-р хороо		49	49	
15	15-р хороо	129	149	20	15.5	32	32-р хороо		25	25	
16	16-р хороо	199	159	-40	-20.1	33	33-р хороо		19	19	
17	17-р хороо	224	168	-56	-25.0	34	34-р хороо		6	6	



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 4222 буюу 94.7 хувь нь хөнгөн, 234 буюу 5.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оноос хөнгөн хэрэг 55 буюу 1.3 хувиар, хүнд хэрэг 12 буюу 4.9 хувиар тус тус буурсан байна.


1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	46	59	28.3	1.3
	Үүнээс: Хүнийг алах	14	25	78.6	0.6
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	775	812	4.8	18.2
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	1	-50.0	0.0
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	54	55	1.9	1.2
	Үүнээс: Хүчиндэх	42	45	7.1	1.0
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	15	37	2.5 дах	0.8
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	10	6	-40.0	0.1
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	3	8	2.7 дах	0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	3410	3186	-6.6	71.5
7	Хулгайлах	775	567	-26.8	12.7
	Дээрэмдэх	88	67	-23.9	1.5
	Залилах	2212	2251	1.8	50.5
8	Эдийн засгийн гэмт хэрэг	18	20	11.1	0.4
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	54	73	35.2	1.6
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	7	16	2.3 дах	0.4
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	13	31	2.4 дах	0.7
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг		7		0.2
13	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	38	62	63.2	1.4
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	80	84	5.0	1.9
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	80	84	5.0	1.9

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 654 буюу 14.7 хувь нь даваа гарагт, 666 буюу 14.9 хувь нь мягмар гарагт, 665 буюу 14.9 хувь нь лхагва гарагт, 668 буюу 15.0 хувь нь пүрэв гарагт, 691 буюу 15.5 хувь нь баасан гарагт, 610 буюу 13.7 хувь нь бямба гарагт, 502 буюу 11.3 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 1691 буюу 37.9 хувь нь 06:00-14:00 цагт, 1436 буюу 32.2 хувь нь 14:00-19:00 цагт, 420 буюу 9.4 хувь нь 19:00-22:00 цагт, 909 буюу 20.4 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 1193 буюу 26.8 хувь нь гэр орон сууцанд, 740 буюу 16.6 хувь нь гудамж талбайд, 619 буюу 13.9 хувь нь олон нийтийн газарт, 25 буюу 0.6 хувь нь нийтийн тээвэрт, 22 буюу 0.5 хувь нь төрийн байгууллагад, 30 буюу 0.7 хувь нь төрийн бус байгууллагад, 499 буюу 12.2 хувь нь аж ахуйн нэгжид, 95 буюу 2.1 хувь нь авто замд, 1233 буюу 27.7 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 226 буюу 5.1 хувь нь согтуугаар, 1070 буюу 24.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 139 буюу 3.1 хувь нь бүлэглэн, 1501 буюу 33.7 хувь нь цахим орчинд, 61 буюу 1.4 хувь нь хүүхэд оролцож, 43 буюу 1.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 8457 хэрэгт хэрэг бүртгэлт, 233 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 8690 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 2441 урьд оны үлдэгдэл хэрэг, 5807 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 7, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 435 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 5507 буюу 63.4 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 3075 буюу 55.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 1330 буюу 24.2 хувийг шүүхэд шилжүүлж;
- 74 буюу 1.3 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 1010 буюу 18.3 хувийг бусад эрүүгийн хэрэгт нэгтгэн;
- 18 буюу 0.3 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгт нэгтгэж, нийт шалгасан хэргийн 87.1 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлэж 238 хүнд холбогдох 3249 хэргийн үлдэгдэлтэй байна.





Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Баянгол дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 906 буюу 20.3 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 52.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.5 нэгжээр буурсан.

Нийслэлийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус дүүрэг нь 3.4 нэгжээр бага байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 4348 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 9 буюу 0.2 хувиар өсч, 2268 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 16 буюу 0.7 хувиар буурсан байна.


Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 2512 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 161 буюу 6.0 хувиар буурсан.

Холбогдогчдын 876 буюу 34.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 99 буюу 12.7 хувиар өсч, 1636 буюу 65.1 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 260 буюу 13.7 хувиар, 76 буюу 3.0 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 50 буюу 39.7 хувиар тус тус буурсан байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 4364 иргэн, 8 хуулийн этгээд хохирч, 49 хүн нас барж, 929 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 58 буюу 1.3 хувиар, нас барсан хүн 2 буюу 3.9 хувиар тус тус буурч, гэмтсэн хүн 91 буюу 10.9 хувиар өссөн.





4.2. Учирсан хохирол.


Иргэн, хуулийн этгээдэд учирсан 61423.3 сая төгрөгийн хохирлын 49294.4 сая төгрөг буюу 80.3 хувийг нөхөн төлүүлж, 4005.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 25023.6 сая төгрөг буюу 68.7 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 26621.5 сая төгрөг буюу 2.2 дахин, битүүмжилсэн хөрөнгө 3961.5 сая төгрөг буюу 91.0 дахин тус тус өссөн байна.



Тав. Зөрчил.

Нийслэлийн Баянгол дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 128129 зөрчил шалгасан нь өмнөх оноос 929 буюу 0.7 хувиар, 127879 зөрчлийг шийдвэрлэсэн нь 839 буюу 0.7 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 97904 буюу 76.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 21139 буюу 16.5 хувийг олон нийтийн газарт зүй бусаар авч явах, 655 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 95 буюу 0.1 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 8336 буюу 6.5 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 124537 иргэн, 261 хуулийн этгээдийг 4066.9 сая төгрөгөөр торгож, 888 хүнийг баривчлуулж, 2193 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 2425 буюу 2.0 хувиар, баривчлуулсан шийтгэл 34 буюу 4.0 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 1427 буюу 39.4 хувиар буурсан байна.

Баянгол дүүрэгт нийт 941 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 5756 буюу 85.9 хувиар буурсан байх бөгөөд дурдсан хугацаанд 2647 хүнийг саатуулсан байна.

---oooOooo---



2.2. БАЯНЗҮРХ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн цагдаагийн газар нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 52367 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 20806 буюу 39.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 31561 буюу 60.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 973 буюу 1.8 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 2019 буюу 6.0 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 1046 буюу 5.3 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 3748 буюу 18.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 16026 буюу 77.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 69 буюу 0.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 16141 буюу 51.1 хувийг зөрчлийн хэрэг нээж, 14994 буюу 47.5 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 30 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Тус дүүрэгт нийт 6130 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 163 буюу 2.6 хувиар буурсан байх бөгөөд нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 24.5 хувийг эзэлж байна.

Тус дүүрэгт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.

Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт		Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	1-р хороо	343	224	-119	-34.7	23	23-р хороо	232	143	-89	-38.4
2	2-р хороо	336	190	-146	-43.5	24	24-р хороо	47	53	6	12.8
3	3-р хороо	200	238	38	19.0	25	25-р хороо	143	101	-42	-29.4
4	4-р хороо	269	188	-81	-30.1	26	26-р хороо	294	197	-97	-33.0
5	5-р хороо	252	130	-122	-48.4	27	27-р хороо	393	366	-27	-6.9
6	6-р хороо	210	227	17	8.1	28	28-р хороо	296	134	-162	-54.7
7	7-р хороо	211	239	28	13.3	29	29-р хороо	9	64	55	7.1 дах
8	8-р хороо	455	357	-98	-21.5	30	30-р хороо	18	109	91	6.1 дах
9	9-р хороо	174	131	-43	-24.7	31	31-р хороо	16	58	42	3.6 дах
10	10-р хороо	166	138	-28	-16.9	32	32-р хороо	7	63	56	9.0 дах
11	11-р хороо	210	188	-22	-10.5	33	33-р хороо	2	20	18	10.0 дах
12	12-р хороо	197	120	-77	-39.1	34	34-р хороо	7	22	15	3.1 дах
13	13-р хороо	185	145	-40	-21.6	35	35-р хороо		23	23	
14	14-р хороо	345	297	-48	-13.9	36	36-р хороо	16	72	56	4.5 дах
15	15-р хороо	93	107	14	15.1	37	37-р хороо	2	46	44	23.0 дах
16	16-р хороо	268	223	-45	-16.8	38	38-р хороо	7	53	46	7.6 дах
17	17-р хороо	92	101	9	9.8	39	39-р хороо	9	54	45	6.0 дах
18	18-р хороо	174	463	289	2.7 дах	40	40-р хороо	4	63	59	15.8 дах
19	19-р хороо	104	112	8	7.7	41	41-р хороо	7	75	68	10.7 дах



20	20-р хороо	181	107	-74	-40.9	42	42-р хороо	24	141	117	5.9 дах
21	21-р хороо	132	97	-35	-26.5	43	43-р хороо	14	82	68	5.9 дах
22	22-р хороо	149	169	20	13.4						

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 5644 буюу 92.1 хувь нь хөнгөн, 486 буюу 7.9 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оноос хөнгөн хэрэг 165 буюу 3.0 хувиар өсч, хүнд хэрэг 328 буюу 40.3 хувиар буурсан байна.


1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	105	127	21.0	2.1
	Үүнээс: Хүнийг алах	30	22	-26.7	0.4
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1503	1182	-21.4	19.3
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	13	18	38.5	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	95	118	24.2	1.9
	Үүнээс: Хүчиндэх	75	86	14.7	1.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	65	78	20.0	1.3
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	3	3.0 дах	0.0
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	12	19	58.3	0.3
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	4133	4202	1.7	68.5
	Хулгайлах	981	855	-12.8	13.9
	Дээрэмдэх	110	58	-47.3	0.9
	Залилах	2613	2919	11.7	47.6
8	Эдийн засгийн гэмт хэрэг	40	26	-35.0	0.4
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	85	101	18.8	1.6
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	14	16	14.3	0.3
11	Авлигын эсрэг гэмт хэрэг		1		0.0
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	32	24	-25.0	0.4
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	7	11	57.1	0.2
14	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	82	90	9.8	1.5
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	119	132	10.9	2.2
15	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	119	132	10.9	2.2

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.


Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 945 буюу 15.4 хувь нь даваа гарагт, 958 буюу 15.6 хувь нь мягмар гарагт, 876 буюу 14.3 хувь нь лхагва гарагт, 847 буюу 13.8 хувь нь пүрэв гарагт, 912 буюу 14.9 хувь нь баасан гарагт, 758 буюу 12.4 хувь нь бямба гарагт, 834 буюу 13.6 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 1845 буюу 30.1 хувь нь 06:00-14:00 цагт, 2127 буюу 34.7 хувь нь 14:00-19:00 цагт, 937 буюу 15.3 хувь нь 19:00-22:00 цагт, 1221 буюу 19.9 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 2179 буюу 35.5 хувь нь гэр орон сууцанд, 1334 буюу 21.8 хувь нь гудамж талбайд, 493 буюу 8.0 хувь нь олон нийтийн газарт, 41 буюу 0.7 хувь нь нийтийн тээвэрт, 28 буюу 0.5 хувь нь төрийн байгууллагад, 28





буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 395 буюу 6.4 хувь нь аж ахуйн нэгжид, 133 буюу 2.2 хувь нь авто замд, 1499 буюу 24.5 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 515 буюу 8.4 хувь нь согтуугаар, 1627 буюу 26.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 141 буюу 2.3 хувь нь бүлэглэн, 307 буюу 5.0 хувь нь хүүхэд оролцож, 171 буюу 2.8 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 2597 буюу 42.4 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 12590 хэрэгт хэрэг бүртгэлт, 783 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 13373 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 4269 урьд оны үлдэгдэл хэрэг, 7916 энэ оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 1161, урьд оны түдгэлзүүлсэнээс сэргээсэн 27 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 9160 буюу 68.5 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 5201 буюу 56.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 2353 буюу 25.7 хувийг шүүхэд шилжүүлж;
- 317 буюу 3.5 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 1230 буюу 13.4 хувийг бусад эрүүгийн хэрэгт нэгтгэн;
- 59 буюу 0.6 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгт нэгтгэж, нийт шалгасан хэргийн 68.5 хувь, хуулийн анхны хугацаанд 95.6 хувийг шийдэж, 386 хүнд холбогдох 4370 хэргийн үлдэгдэлтэй байна.






Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Баянзүрх дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 3114 буюу 50.8 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 57.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 5.6 нэгжээр өссөн.

Нийслэлийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус дүүрэг нь 1.6 хувиар их байна.

Илрүүлэлтийн хувь /хэргийн ангиллаар/



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 5910 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 140 хэрэг буюу 2.4 хувиар, 3380 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 402 буюу 13.5 хувиар тус тус өссөн байна.


Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 3697 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 29 буюу 0.8 хувиар өссөн.

Холбогдогчдын 2281 буюу 61.7 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оноос 461 буюу 16.8 хувиар, 330 буюу 8.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 13 буюу 3.8 хувиар тус тус буурч, 1416 буюу 38.3 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 490 буюу 52.9 хувиар өссөн байна.

3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн үлмаас 6008 иргэн, 8 хуулийн этгээд хохирч, 126 хүн нас барж, 1261 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 73 буюу 1.2 хувиар, хохирсон хуулийн этгээд 17 буюу 68.0 хувиар, гэмтсэн хүн 280 буюу 18.2 хувиар тус тус буурч, нас барсан хүн 31 буюу 32.6 хувиар өссөн байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 75511.8 сая төгрөгийн хохирлын 21818.8 сая төгрөг буюу 28.9 хувийг нөхөн төлүүлж, 79.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 29644.4 сая төгрөг буюу 64.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 5959.6 сая төгрөг буюу 37.6 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 139.3 сая төгрөг буюу 63.7 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 175419 зөрчил шалгасан нь өмнөх оноос 29031 буюу 14.2 хувиар, 174893 зөрчлийг шийдвэрлэсэн нь 29247 буюу 14.3 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 139584 буюу 79.6 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 10408 буюу 5.9 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 1906 буюу 1.1 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 152 буюу 0.1 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 23369 буюу 13.3 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 168247 иргэн, 816 хуулийн этгээдийг 6146.9 сая төгрөгөөр торгох, 3391 иргэнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 2439 хүнийг баривчлуулсан нь өмнөх оноос торгосон иргэн 24502 буюу 12.7 хувиар, хуулийн этгээд 1609 буюу 66.4 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 2696 буюу 44.3 хувиар, баривчлуулсан шийтгэл 440 буюу 15.3 хувиар тус тус буурсан байна.

Баянзүрх дүүрэгт нийт 841 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 5518 буюу 86.8 хувиар буурсан байх бөгөөд дурдсан хугацаанд 2794 хүнийг саатуулсан байна.

---oooOooo---



2.3. СҮХБААТАР ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Сүхбаатар дүүргийн цагдаагийн газар нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 28808 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 12344 буюу 42.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 16464 буюу 57.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх онтой харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 469 буюу 1.7 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 1624 буюу 15.1 хувиар тус тус өсч, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 1155 буюу 6.6 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 2447 буюу 19.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 9175 буюу 74.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 48 буюу 0.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 9460 буюу 57.5 хувийг зөрчлийн хэрэг нээж, 6849 буюу 41.6 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 3 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Тус дүүрэгт нийт 3832 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 206 буюу 5.7 хувиар өссөн байх бөгөөд нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 15.3 хувийг эзэлж байна.

Тус аймагт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.

Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт		Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	1-р хороо	774	729	-45	-5.8	11	11-р хороо	438	303	-135	-30.8
2	2-р хороо	72	51	-21	-29.2	12	12-р хороо	104	79	-25	-24.0
3	3-р хороо	202	209	7	3.5	13	13-р хороо	98	72	-26	-26.5
4	4-р хороо	94	76	-18	-19.1	14	14-р хороо	87	76	-11	-12.6
5	5-р хороо	83	84	1	1.2	15	15-р хороо	62	69	7	11.3
6	6-р хороо	255	210	-45	-17.6	16	16-р хороо	90	109	19	21.1
7	7-р хороо	120	152	32	26.7	17	17-р хороо	57	43	-14	-24.6
8	8-р хороо	457	918	461	2.0 дах	18	18-р хороо	67	79	12	17.9
9	9-р хороо	182	220	38	20.9	19	19-р хороо	95	65	-30	-31.6
10	10-р хороо	208	203	-5	-2.4	20	20-р хороо	81	85	4	4.9

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 3495 буюу 91.2 хувь нь хөнгөн, 337 буюу 8.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн 224 буюу гэмт хэрэг 6.8 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 18 буюу 5.1 хувиар буурсан байна.




1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	19	33	73.7	0.9
	Үүнээс: Хүнийг алах	8	12	50.0	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	743	634	-14.7	16.5
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	6	6	0.0	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	44	41	-6.8	1.1
	Үүнээс: Хүчиндэх	35	33	-5.7	0.9
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	53	58	9.4	1.5
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1	-	-	0.0
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	8	8	0.0	0.2
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	19	3	-84.2	0.1
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2485	2708	9.0	70.7
6	Хулгайлах	611	618	1.1	16.1
	Дээрэмдэх	50	45	-10.0	1.2
	Залилах	1610	1821	13.1	47.5
	Мал хулгайлах		2		0.1
7	Эдийн засгийн гэмт хэрэг	25	38	52.0	1.0
	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	2	-	0.1
	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	52	67	28.8	1.7
7	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	16	25	56.3	0.7
9	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	41	51	24.4	1.3
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг	8	7	-12.5	0.2
	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг		1		0.0
12	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	30	74	2.5 дах	1.9
13	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	82	81	-1.2	2.1
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	81	81	0.0	2.1
	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	-	1	-	0.0

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 608 буюу 15.9 хувь нь даваа гарагт, 585 буюу 15.3 хувь нь мягмар гарагт, 598 буюу 15.6 хувь нь лхагва гарагт, 590 буюу 15.4 хувь нь пүрэв гарагт, 606 буюу 15.8 хувь нь баасан гарагт, 454 буюу 11.8 хувь нь бямба гарагт, 391 буюу 10.2 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 1682 буюу 43.9 хувь нь 06:00-14:00 цагт, 1264 буюу 33.0 хувь нь 14:00-19:00 цагт, 262 буюу 6.8 хувь нь 19:00-22:00 цагт, 624 буюу 16.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 769 буюу 20.1 хувь нь гэр орон сууцанд, 888 буюу 23.2 хувь нь гудамж талбайд, 535 буюу 14.0 хувь нь олон нийтийн газарт, 10 буюу 0.3 хувь нь нийтийн тээвэрт, 33 буюу 0.9 хувь нь төрийн байгууллагад, 25 буюу 0.7 хувь нь төрийн бус байгууллагад, 1021 буюу 26.6 хувь нь аж ахуйн нэгжид, 83 буюу 2.2 хувь нь авто замд, 468 буюу 12.2 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 369 буюу 9.6 хувь нь согтуугаар, 500 буюу 13.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 162 буюу 4.2 хувь нь бүлэглэн, 110 буюу 2.9 хувь нь хүүхэд оролцож, 94 буюу 2.5 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 775 буюу 20.2 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 6851 хэрэгт хэрэг бүртгэлт, 603 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 7454 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 2035 урьд оны үлдэгдэл хэрэг, 4876 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 533 хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 10 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 5461 буюу 73.3 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 2851 буюу 52.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 1681 буюу 30.8 хувийг шүүхэд шилжүүлж;
- 10 буюу 0.2 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 861 буюу 15.8 хувийг бусад эрүүгийн хэрэгт нэгтгэн;
- 58 буюу 1.1 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгт нэгтгэж, нийт шалгасан хэргийн 73.3 хувь, хуулийн анхны хугацаанд 86.2 хувийг шийдэж, 252 хүнд холбогдох 2123 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Сүхбаатар дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 1861 буюу 48.6 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 56.8 хувьтай байгаа нь өмнөх оноос 3.8 нэгжээр өссөн.

Нийслэлийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус дүүрэг нь 1.2 нэгжээр их байна.





2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 3316 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 282 хэрэг буюу 9.3 хувиар, үүнээс 1883 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 274 буюу 17.0 хувиар тус тус өссөн байна.


Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 2610 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 181 буюу 7.4 хувиар өссөн.

Холбогдогчдын 402 буюу 15.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оноос 264 буюу 39.6 хувиар бүүрч, 2208 буюу 84.6 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 445 буюу 25.2 хувиар, 128 буюу 4.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 9 буюу 7.6 хувиар тус тус өссөн байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 3734 иргэн, 5 хуулийн этгээд хохирч, үүнээс 41 хүн нас барж, 676 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 170 буюу 4.8 хувиар, нас барсан хүн 17 буюу 70.8 хувиар тус тус өсч, гэмтсэн хүн 118 буюу 14.9 хувиар бүүрсэн байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 80541.5 сая төгрөгийн хохирлын 22697.2 сая төгрөг буюу 28.2 хувийг нөхөн төлүүлж, 53.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 32983.4 сая төгрөг буюу 69.4 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 73.6 сая төгрөг буюу 0.3 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 97.6 сая төгрөг буюу 64.7 хувиар бүүрсэн байна.



Тав. Зөрчил.

Сүхбаатар дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 98715 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 22193 буюу 29.0 хувиар, 98499 зөрчлийг шийдвэрлэсэн нь 22114 буюу 29.0 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 83091 буюу 84.2 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 7919 буюу 8.0 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 676 буюу 0.7 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 183 буюу 0.2 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 6846 буюу 6.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 94013 иргэнийг 3702.3 сая төгрөгөөр торгох, 975 хүнийг баривчлуулах, 2863 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 24191 буюу 34.6 хувиар, баривчлуулах шийтгэл 107 буюу 12.3 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 1143 буюу 28.5 хувиар буурсан байна.

---oooOooo---



2.4. СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газар нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 47137 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 13199 буюу 28.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 33938 буюу 72.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 423 буюу 0.9 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 569 буюу 4.5 хувиар тус тус өсч, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 146 буюу 0.4 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 1718 буюу 13.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 10801 буюу 81.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 73 буюу 0.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 14130 буюу 41.6 хувийг зөрчлийн хэрэг нээж, 19484 буюу 57.4 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 14 буюу 0.04 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Тус дүүрэгт нийт 3385 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 95 буюу 2.9 хувиар өссөн байх бөгөөд нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 13.6 хувийг эзэлж байна.

Тус дүүрэгт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.

Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт		Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	01-р хороо	73	73	0	0.0	23	23-р хороо	51	30	-21	-41.2
2	02-р хороо	74	79	5	6.8	24	24-р хороо	84	80	-4	-4.8
3	03-р хороо	56	43	-13	-23.2	25	25-р хороо	74	56	-18	-24.3
4	04-р хороо	55	74	19	34.5	26	26-р хороо	85	73	-12	-14.1
5	05-р хороо	69	60	-9	-13.0	27	27-р хороо	111	108	-3	-2.7
6	06-р хороо	166	109	-57	-34.3	28	28-р хороо	57	44	-13	-22.8
7	07-р хороо	88	77	-11	-12.5	29	29-р хороо	158	164	6	3.8
8	08-р хороо	77	48	-29	-37.7	30	30-р хороо	40	33	-7	-17.5
9	09-р хороо	70	99	29	41.4	31	31-р хороо	55	35	-20	-36.4
10	10-р хороо	72	78	6	8.3	32	32-р хороо	135	158	23	17.0
11	11-р хороо	69	59	-10	-14.5	33	33-р хороо	119	120	1	0.8
12	12-р хороо	91	104	13	14.3	34	34-р хороо	66	71	5	7.6
13	13-р хороо	74	51	-23	-31.1	35	35-р хороо	19	24	5	26.3
14	14-р хороо	86	84	-2	-2.3	36	36-р хороо	63	51	-12	-19.0
15	15-р хороо	78	69	-9	-11.5	37	37-р хороо	72	216	144	3.0 дах
16	16-р хороо	85	60	-25	-29.4	38	38-р хороо	32	46	14	43.8
17	17-р хороо	52	63	11	21.2	39	39-р хороо	27	35	8	29.6



18	18-р хороо	81	101	20	24.7	40	40-р хороо	72	62	-10	-13.9
19	19-р хороо	134	204	70	52.2	41	41-р хороо	43	48	5	11.6
20	20-р хороо	128	152	24	18.8	42	42-р хороо	38	33	-5	-13.2
21	21-р хороо	89	107	18	20.2	43	43-р хороо	30	36	6	20.0
22	22-р хороо	92	68	-24	-26.1						

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.


Нийт бүртгэгдсэн хэргийн 2958 буюу 87.4 хувь нь хөнгөн, 427 буюу 12.6 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оноос хөнгөн хэрэг 134 буюу 4.7 хувиар өссөн бол хүнд гэмт хэрэг нь 39 буюу 8.4 хувиар буурсан.

1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	45	54	20.0	1.6
	Үүнээс: Хүнийг алах	21	33	57.1	1.0
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1189	1159	-2.5	34.2
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	5	17	3.4 дах	0.5
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	70	68	-2.9	2.0
	Үүнээс: Хүчиндэх	64	59	-7.8	1.7
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	14	18	28.6	0.5
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	4	1	-75.0	0.0
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	7	9	28.6	0.3
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1758	1827	3.9	54.0
	Үүнээс: Хулгайлах	736	678	-7.9	20.0
	Дээрэмдэх	83	102	22.9	3.0
	Залилах	721	828	14.8	24.5
8	Эдийн засгийн гэмт хэрэг	10	13	30.0	0.4
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	27	60	2.2 дах	1.8
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	3	4	33.3	0.1
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	27	27.0 дах	0.8
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	11	26	2.4 дах	0.8
13	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	17	18	5.9	0.5
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	134	101	-24.6	3.0
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	134	101	-24.6	3.0


1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 535 буюу 15.8 хувь нь даваа гарагт, 496 буюу 14.7 хувь нь мягмар гарагт, 569 буюу 16.8 хувь нь лхагва гарагт, 446 буюу 13.2 хувь нь пүрэв гарагт, 527 буюу 15.6 хувь нь баасан гарагт, 398 буюу 11.8 хувь нь бямба гарагт, 414 буюу 12.2 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 1005 буюу 29.7 хувь нь 06:00-14:00 цагт, 919 буюу 27.1 хувь нь 14:00-19:00 цагт, 611 буюу 18.1 хувь нь 19:00-22:00 цагт, 850 буюу 25.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.





Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 1307 буюу 38.6 хувь нь гэр орон сууцанд, 929 буюу 27.4 хувь нь гудамж талбайд, 340 буюу 10.0 хувь нь олон нийтийн газарт, 28 буюу 0.8 хувь нь төрийн байгууллагад, 17 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 291 буюу 8.6 хувь нь аж ахуйн нэгжид, 102 буюу 3.0 хувь нь авто замд, 19 буюу 0.6 хувь нь нийтийн тээвэрт, 352 буюу 10.4 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 332 буюу 9.8 хувь нь согтуугаар, 484 буюу 14.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 168 буюу 5.0 хувь нь бүлэглэн, 177 буюу 5.2 хувь нь хүүхэд оролцож, 247 буюу 7.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 7057 хэрэгт хэрэг бүртгэлт, 450 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 7507 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 2281 урьд оны үлдэгдэл хэрэг, 4471 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 7, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 748 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 5232 буюу 69.7 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 3055 буюу 58.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 1893 буюу 36.2 хувийг шүүхэд шилжүүлж;
- 77 буюу 1.5 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 195 буюу 3.7 хувийг бусад эрүүгийн хэрэгт нэгтгэн;
- 12 буюу 0.2 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгт нэгтгэж, нийт шалгасан хэргийн 69.7 хувь, хуулийн анхны хугацаанд 93.9 хувийг шийдэж, 158 хүнд холбогдох 2317 хэргийн үлдэгдэлтэй байна.






Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газарт нийт бүртгэгдсэн хэргийн 1347 буюу 39.8 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 57.5 хувьтай байгаа нь өмнөх оноос 5.7 нэгжээр өссөн.

Нийслэлийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус дүүрэг нь 1.9 нэгжээр их байна.

Илрүүлэлтийн хувь /хэргийн ангиллаар/



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 3090 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 182 хэрэг буюу 6.3 хувиар, 1778 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 271 буюу 18.0 хувиар тус тус өссөн байна.


Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 2273 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 252 буюу 12.5 хувиар өссөн.

Холбогдогчдын 1876 буюу 82.5 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оноос 172 буюу 10.1 хувиар, 397 буюу 17.5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 80 буюу 25.2 хувиар, 211 буюу 9.3 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 75 буюу 55.1 хувиар тус тус өссөн байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 3359 иргэн, 8 хуулийн этгээд хохирч, 66 хүн нас барж, 1291 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 47 буюу 1.4 хувиар өсч, гэмтсэн хүн 36 буюу 2.7 хувиар, нас барсан хүн 5 буюу 7.0 хувиар тус тус буурсан.





4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 16399.3 сая төгрөгийн хохирлын 5126.3 сая төгрөг буюу 31.3 хувийг нөхөн төлүүлж, 137.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 1892.3 сая төгрөг буюу 13.0 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 56.0 сая төгрөг буюу 68.5 хувиар тус тус өсч, нөхөн төлүүлсэн хохирол 900.7 сая төгрөг буюу 14.9 хувиар буурсан байна.

/Сая төгрөгөөр/

Тав. Зөрчил.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 116288 зөрчил шалгасан нь өмнөх оноос 23423 буюу 25.2 хувиар, 115782 зөрчлийг шийдвэрлэсэн нь 23140 буюу 25.0 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 84261 буюу 72.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 19499 буюу 16.8 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 1561 буюу 1.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 263 буюу 0.2 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 10704 буюу 9.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 112106 иргэн, 46 хуулийн этгээдийг 3919.4 сая төгрөгөөр торгох, 1875 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, 1755 хүнийг баривчлуулсан нь өмнөх оноос торгосон иргэн 25992 буюу 30.2 хувиар өсч, торгож тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 2158 буюу 53.5 хувиар, баривчлуулсан шийтгэл 304 буюу 14.8 хувиар тус тус буурсан байна.

Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газар нийт 1907 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 7780 буюу 80.3 хувиар буурсан байх бөгөөд дурдсан хугацаанд 6999 хүнийг саатуулсан байна.

---oooOooo---



2.5. ХАН-УУЛ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн Хан-Уул дүүргийн цагдаагийн газар нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 25030 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 8854 буюу 35.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 16176 буюу 64.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 1971 буюу 7.3 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 2804 буюу 14.8 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 833 буюу 10.4 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 2695 буюу 30.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 5681 буюу 64.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 64 буюу 0.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 9826 буюу 60.7 хувийг зөрчлийн хэрэг нээж, 6105 буюу 37.7 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 23 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 3974 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 795 буюу 25.0 хувиар өсч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 15.9 хувийг эзэлж байна.

Тус дүүрэгт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.

Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт		Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	1-р хороо	157	183	26	16.6	14	14-р хороо	79	57	-22	-27.8
2	2-р хороо	141	221	80	56.7	15	15-р хороо	453	414	-39	-8.6
3	3-р хороо	272	436	164	60.3	16	16-р хороо	139	236	97	69.8
4	4-р хороо	330	224	-106	-32.1	17	17-р хороо	133	177	44	33.1
5	5-р хороо	38	49	11	28.9	18	18-р хороо	106	112	6	5.7
6	6-р хороо	54	75	21	38.9	19	19-р хороо	141	118	-23	-16.3
7	7-р хороо	38	40	2	5.3	20	20-р хороо	245	580	335	2.4 дах
8	8-р хороо	102	90	-12	-11.8	21	21-р хороо	138	127	-11	-8.0
9	9-р хороо	46	54	8	17.4	22	22-р хороо	1	38	37	38.0 дах
10	10-р хороо	89	74	-15	-16.9	23	23-р хороо	4	73	69	18.3 дах
11	11-р хороо	363	319	-44	-12.1	24	24-р хороо	4	100	96	25.0 дах
12	12-р хороо	68	51	-17	-25.0	25	25-р хороо	1	95	94	95.0 дах
13	13-р хороо	36	31	-5	-13.9	26	26-р хороо	1	0	-	-



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 3606 буюу 90.7 хувь нь хөнгөн, 368 буюу 9.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 808 буюу 28.9 хэргээр өсч, хүнд хэрэг 13 буюу 3.4 хувиар буурсан байна.


1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	62	76	22.6	1.9
	Үүнээс: Хүнийг алах	15	13	-13.3	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	700	621	-11.3	15.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	4	5	25.0	0.1
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	41	47	14.6	1.2
	Үүнээс: Хүчиндэх	36	37	2.8	0.9
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	24	48	2.0 дах	1.2
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	2	-	-	0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	3	5	66.7	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	3	1	-66.7	0.0
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2102	2814	33.9	70.8
8	Үүнээс: Хулгайлах	588	431	-26.7	10.8
	Дээрэмдэх	18	13	-27.8	0.3
	Залилах	1174	2059	75.4	51.8
9	Эдийн засгийн гэмт хэрэг	17	24	41.2	0.6
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	39	81	2.1 дах	2.0
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	7	22	3.1 дах	0.6
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	21	38	81.0	1.0
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	8	7	-12.5	0.2
14	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	49	79	61.2	2.0
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	100	109	9.0	2.7
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	100	109	9.0	2.7
16	Цэргийн албаны эсрэг	1	1	0.0	0.0

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 574 буюу 14.4 хувь нь даваа гарагт, 620 буюу 15.6 хувь нь мягмар гарагт, 609 буюу 15.3 хувь нь лхагва гарагт, 595 буюу 15.0 хувь нь пүрэв гарагт, 650 буюу 16.4 хувь нь баасан гарагт, 466 буюу 11.7 хувь нь бямба гарагт, 460 буюу 11.7 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 1667 буюу 41.9 хувь нь 06:00-14:00 цагт, 1417 буюу 35.7 хувь нь 14:00-19:00 цагт, 331 буюу 8.3 хувь нь 19:00-22:00 цагт, 559 буюу 14.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 1179 буюу 29.7 хувь нь гэр орон сууцанд, 626 буюу 15.8 хувь нь гудамж талбайд, 223 буюу 5.9 хувь нь олон нийтийн газарт, 15 буюу 0.4 хувь нь нийтийн тээвэрт, 18 буюу 0.5 хувь нь төрийн байгууллагад, 22 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 469 буюу 11.8 хувь нь аж ахуйн нэгжид, 119 буюу 3.0 хувь нь авто замд, 1292 буюу 32.6 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 1237 буюу 31.1 хувь нь цахим орчинд, 264 буюу 6.6 хувь нь согтуугаар, 497 буюу 12.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 140 буюу 3.5 хувь нь бүлэглэн, 54 буюу 1.4 хувь нь хүүхэд оролцож, 68 буюу 1.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.


1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 8212 хэрэгт хэрэг бүртгэлт, 391 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 8603 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 2643 урьд оны үлдэгдэл хэрэг, 5495 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 458, урьд оны түдгэлзүүлсэнээс сэргээсэн 7 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 5122 буюу 59.5 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 2675 буюу 52.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 1465 буюу 28.6 хувийг шүүхэд шилжүүлж;
- 155 буюу 3.0 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 623 буюу 12.2 хувийг бусад эрүүгийн хэрэгт нэгтгэн;
- 204 буюу 4.0 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгт нэгтгэж,

нийт шалгасан хэргээс хуулийн анхны хугацаанд 99.0 хувийг шийдэж, 238 хүнд холбогдох 3589 хэргийн үлдэгдэлтэй байна.





Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Хан-Уул дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 1218 буюу 30.6 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 50.3 хувьтай байгаа нь өмнөх оноос 6.0 нэгжээр өссөн.

Нийслэлийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус дүүрэг нь 5.3 хувиар бага байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 3882 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 792 хэрэг буюу 25.6 хувиар, 1954 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 584 буюу 42.6 хувиар тус тус өссөн байна.

Илрүүлэлтийн хувь /хэргийн ангиллаар/





Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 2185 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 541 буюу 32.9 хувиар өссөн.

Холбогдогчдын 1850 буюу 84.7 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 488 буюу 35.8 хувиар, 335 буюу 15.3 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 53 буюу 18.8 хувиар тус тус өсч, 62 буюу 2.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 68 буюу 52.3 хувиар буурсан байна.

3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.






Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 3884 иргэн, 20 хуулийн этгээд хохирч, 79 хүн нас барж, 651 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 716 буюу 22.6 хувиар, нас барсан хүн 23 буюу 41.1 хувиар тус тус өсч, гэмтсэн хүн 98 буюу 13.1 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 107.0 тэрбум төгрөгийн хохирлын 55.5 тэрбум төгрөг буюу 51.9 хувийг нөхөн төлүүлж, 44.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 887.0 сая төгрөг буюу 0.8 хувиар өсч, битүүмжилсэн хөрөнгө 100.3 сая төгрөг буюу 69.3 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 14598.1 сая төгрөг буюу 20.8 хувиар тус тус буурсан байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 98986 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 5960 буюу 6.4 хувиар, 98128 зөрчлийг шийдвэрлэсэн нь 5704 буюу 6.2 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 80067 буюу 80.9 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 9182 буюу 9.3 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 731 буюу 0.7 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 268 буюу 0.3 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 8738 буюу 8.8 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 94952 иргэн, 354 хуулийн этгээдийг 3612.9 сая төгрөгөөр торгох, 881 хүнийг баривчлуулах, 1941 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх онтой харьцуулахад торгосон иргэн 7336 буюу 8.4 хувиар өсч, баривчлуулсан шийтгэл 108 буюу 10.9 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 1589 буюу 45.0 хувиар тус тус буурсан байна.

Хан-Уул дүүрэгт нийт 571 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 4167 буюу 87.9 хувиар буурч, 1823 иргэнийг саатуулсан байна.

--00000000--



2.6. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн цагдаагийн газар нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 24681 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 7882 буюу 31.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 16799 буюу 68.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх онтой нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 356 буюу 1.4 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 51 буюу 0.6 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 305 буюу 1.8 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 1900 буюу 24.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 5520 буюу 70.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 77 буюу 1.0 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 9208 буюу 54.8 хувийг зөрчлийн хэрэг нээж, 7355 буюу 43.8 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 30 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Тус дүүрэгт нийт 2666 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 182 буюу 6.4 хувиар буурсан байх бөгөөд нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 10.7 хувийг эзэлж байна.

Тус дүүрэгт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.

Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт		Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	1-р хороо	261	207	-54	-20.7	13	13-р хороо	120	115	-5	-4.2
2	2-р хороо	176	209	33	18.8	14	14-р хороо	99	86	-13	-13.1
3	3-р хороо	264	212	-52	-19.7	15	15-р хороо	93	98	5	5.4
4	4-р хороо	187	224	37	19.8	16	16-р хороо	96	86	-10	-10.4
5	5-р хороо	277	312	35	12.6	17	17-р хороо	113	69	-44	-38.9
6	6-р хороо	136	114	-22	-16.2	18	18-р хороо	140	101	-39	-27.9
7	7-р хороо	100	83	-17	-17.0	19	19-р хороо	182	127	-55	-30.2
8	8-р хороо	55	38	-17	-30.9	20	20-р хороо		8		
9	9-р хороо	72	57	-15	-20.8	21	21-р хороо		31		
10	10-р хороо	118	103	-15	-12.7	22	22-р хороо		13		
11	11-р хороо	148	97	-51	-34.5	23	23-р хороо		35		
12	12-р хороо	211	157	-54	-25.6	24	24-р хороо		84		



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 2465 буюу 92.5 хувь нь хөнгөн, 201 буюу 7.5 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 141 буюу 5.4, хүнд хэрэг 41 буюу 16.9 хувиар тус тус буурсан байна.


1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	28	16	-42.9	0.6
	Үүнээс: Хүнийг алах	9	11	22.2	0.4
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	634	576	-9.1	21.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	5	9	80.0	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	31	26	-16.1	1.0
	Үүнээс: Хүчиндэх	24	20	-16.7	0.8
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	21	32	52.4	1.2
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	2	7	3.5 дах	0.3
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1963	1776	-9.5	66.6
6	Үүнээс: Хулгайлах	393	416	5.9	15.6
	Дээрэмдэх	39	21	-46.2	0.8
	Залилах	1382	1217	-11.9	45.6
7	Эдийн засгийн гэмт хэрэг	20	20	0.0	0.8
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	35	79	2.2 дах	3.0
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	11	12	9.1	0.5
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	26	23	-11.5	0.9
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	6	18	3.0 дах	0.7
12	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	5	6	20.0	0.2
13	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7	26	3.7 дах	1.0
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	59	49	-16.9	1.6
14	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	59	19	-67.8	0.7

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.


Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 417 буюу 15.6 хувь нь даваа гарагт, 429 буюу 16.1 хувь нь мягмар гарагт, 436 буюу 16.4 хувь нь лхагва гарагт, 379 буюу 14.2 хувь нь пүрэв гарагт, 372 буюу 14.0 хувь нь баасан гарагт, 324 буюу 12.2 хувь нь бямба гарагт, 309 буюу 11.6 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 1037 буюу 38.9 хувь нь 06:00-14:00 цагт, 909 буюу 34.1 хувь нь 14:00-19:00 цагт, 293 буюу 11.0 хувь нь 19:00-22:00 цагт, 427 буюу 16.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 764 буюу 28.7 хувь нь гэр орон сууцанд, 653 буюу 24.5 хувь нь гудамж талбайд, 290 буюу 10.9 хувь нь олон нийтийн газарт, 8 буюу 0.3 хувь нь нийтийн тээвэрт, 27 буюу 1.0 хувь нь төрийн байгууллагад, 7 буюу 0.3 хувь нь төрийн бус байгууллагад, 354 буюу 13.3 хувь нь аж ахуйн нэгжид, 50 буюу 1.9 хувь нь авто замд, 513 буюу 19.2 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.



Бүртгэгдсэн гэмт хэргийн 1022 буюу 38.3 хувь нь цахим орчинд, 282 буюу 10.6 хувь нь согтуугаар, 510 буюу 19.1 хувь нь эмэгтэй хүн оролцож, 69 буюу 2.6 хувь нь бүлэглэн, 62 буюу 2.3 хувь нь хүүхэд оролцож, 69 буюу 2.6 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.


1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 4662 хэрэгт хэрэг бүртгэлт, 139 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 4801 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 1381 урьд оны үлдэгдэл хэрэг, 3263 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 10, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 147 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 3395 буюу 72.8 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 1668 буюу 49.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 981 буюу 28.9 хувийг шүүхэд шилжүүлж;
- 41 буюу 1.2 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 670 буюу 19.7 хувийг бусад эрүүгийн хэрэгт нэгтгэн;

-35 буюу 1.1 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгт нэгтгэж, нийт шалгасан хэргийн 72.8 хувь, хуулийн анхны хугацаанд 98.1 хувийг шийдэж 121 хүнд холбогдох 1143 хэргийн үлдэгдэлтэй байна.





Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Чингэлтэй дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 1319 буюу 49.5 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 59.8 хувьтай байгаа нь өмнөх оноос 1.9 нэгжээр өссөн. Нийслэлийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус дүүрэг нь 4.2 нэгжээр их байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 2561 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 112 буюу 4.6 хувиар, 1532 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 113 буюу 8.0 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 1771 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 182 буюу 9.3 хувиар буурсан.

Холбогдогчдын 390 буюу 22.0 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 66 буюу 20.4 хувиар өсч, 1381 буюу 78.0 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 248 буюу 15.2 хувиар, 70 буюу 4.0 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 30 буюу 30.0 хувиар тус тус буурсан байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 2559 иргэн, 11 хуулийн этгээд хохирч, 18 хүн нас барж, 549 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 249 буюу 8.9 хувиар, гэмтсэн хүн 68 буюу 11.0 хувиар, нас барсан хүн 5 буюу 21.7 хувиар тус тус буурсан байна.





4.2. Учирсан хохирол.



/Сая төгрөгөөр/


■ 2022 он ■ 2023 он

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 29369.8 сая төгрөгийн хохирлын 6162.4 сая төгрөг буюу 21.0 хувийг нөхөн төлүүлж, 68.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 2937.9 сая төгрөг буюу 9.1 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 487.9 сая төгрөг буюу 87.7 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 13747.3 сая төгрөг буюу 69.0 хувиар тус тус буурсан байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 113236 зөрчил шалгасан нь өмнөх оноос 11924 буюу 11.8 хувиар, 112716 зөрчлийг шийдвэрлэсэн нь 11691 буюу 11.6 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 96869 буюу 85.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 5870 буюу 5.2 хувийг олон нийтийн газарт зүй бусаар авч явах, 478 буюу 0.4 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 49 буюу 0.1 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 9970 буюу 8.8 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 108869 иргэн, 553 хуулийн этгээдийг 3572.5 сая төгрөгөөр торгох, 767 хүнийг баривчлуулах, 2527 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос торгосон иргэн 14581 буюу 15.5 хувиар өсч, баривчлуулсан шийтгэл 391 буюу 33.8 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 1898 буюу 42.9 хувиар тус тус буурсан байна.

---oooOooo---



2.7. БАГАНУУР ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 1838 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 502 буюу 27.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1336 буюу 72.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх онтой харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 104 буюу 5.4 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 75 буюу 5.3 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 29 буюу 5.5 хувиар тус тус буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 179 буюу 35.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 278 буюу 55.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 4 буюу 0.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1198 буюу 89.7 хувийг зөрчлийн хэрэг нээж, 100 буюу 7.5 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 8 буюу 0.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Тус дүүрэгт нийт 188 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 13 буюу 6.5 хувиар буурсан байх бөгөөд нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 0.8 хувийг эзэлж байна.

Тус дүүрэгт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.

Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	1-р хороо	87	80	-7	-8.0
2	2-р хороо	9	7	-2	-22.2
3	3-р хороо	35	42	7	20.0
4	4-р хороо	37	25	-12	-32.4
5	5-р хороо	33	34	1	3.0

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 159 буюу 84.6 хувь нь хөнгөн, 29 буюу 15.4 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг өмнөх оны түвшинд, хүнд хэрэг 13 буюу 31.0 хувиар буурсан байна.

1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	2	4	2.0 дах	2.1
	Үүнээс: Хүнийг алах	2	2	-	1.1
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	94	79	-16	42.0




	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	-	1	-	0.5
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5	4	-20.0	2.1
	Үүнээс: Хүчиндэх	5	3	-40.0	1.6
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	83	77	-7.2	41.0
4	Үүнээс: Хулгайлах	38	29	-23.7	15.0
	Дээрэмдэх	3	2	-33.3	1.1
	Залилах	29	34	17.2	18.0
5	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	-	5	-	2.7
6	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	-	1	-	0.5
7	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	8	6	-25.0	3.2
8	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	-	1	-	0.5
9	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	-	-	-
10	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	8	11	37.5	5.9
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	8	11	37.5	5.9

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 31 буюу 16.5 хувь нь даваа гарагт, 21 буюу 11.2 хувь нь мягмар гарагт, 26 буюу 13.8 хувь нь лхагва гарагт, 28 буюу 14.9 хувь нь пүрэв гарагт, 25 буюу 13.3 хувь нь баасан гарагт, 36 буюу 19.1 хувь нь бямба гарагт, 21 буюу 11.2 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 53 буюу 28.2 хувь нь 06:00-14:00 цагт, 45 буюу 23.9 хувь нь 14:00-19:00 цагт, 23 буюу 12.2 хувь нь 19:00-22:00 цагт, 67 буюу 35.6 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 69 буюу 36.7 хувь нь гэр орон сууцанд, 19 буюу 10.1 хувь нь гудамж талбайд, 34 буюу 18.1 хувь нь олон нийтийн газарт, 3 буюу 1.6 хувь нь төрийн байгууллагад, 3 буюу 1.6 хувь нь төрийн бус байгууллагад, 22 буюу 11.7 хувь нь аж ахуйн нэгжид, 11 буюу 5.9 хувь нь авто замд, 27 буюу 14.4 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



Гэр, орон сууц
36.7%




Гудамж, талбай
10.1%




Олон нийтийн газар
18.1%



Аж ахуйн нэгж
11.7%



Авто зам
5.9%



Бусад газар
17.5%



1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 73 буюу 38.8 хувь нь согтуугаар, 20 буюу 10.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 8 буюу 4.3 хувь нь бүлэглэн, 5 буюу 2.7 хувь нь хүүхэд оролцож, 16 буюу 8.5 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 29 буюу 15.4 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 316 хэрэгт хэрэг бүртгэлт, 25 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 341 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 89 урьд оны үлдэгдэл хэрэг, 249 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 3 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 232 буюу 68.0 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:


-98 буюу 42.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;

-120 буюу 51.7 хувийг шүүхэд шилжүүлж;

-7 буюу 3.0 хувийг хэрэгсэхгүй болгож;

-5 буюу 2.2 хувийг бусад эрүүгийн хэрэгт нэгтгэн;

-2 буюу 0.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэгт нэгтгэж нийт шалгасан хэргээс хуулийн анхны хугацаанд 95.3 хувийг шийдэж, 5 хүнд холбогдох 115 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Багануур дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 59 буюу 31.4 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 64.4 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулбал 2.0 хувиар өссөн.

Нийслэлийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус дүүрэг нь 8.8 нэгжээр их байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 174 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 25 хэрэг буюу 16.8 хувиар, 112 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 19 буюу 20.4 хувиар тус тус өссөн байна.




Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 139 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулбал 13 буюу 8.6 хувиар буурсан.

Холбогдогчдын 124 буюу 89.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулбал 9 буюу 6.8 хувиар, 15 буюу 10.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 4 буюу 21.1 хувиар тус тус буурч, 10 буюу 7.2 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 4 буюу 66.7 хувиар өссөн байна.

3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 179 иргэн, 4 хуулийн этгээд хохирч, 5 хүн нас барж, 91 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 24 буюу 11.8 хувиар, гэмтсэн хүн 10 буюу 9.9 хувиар тус тус буурч, нас барсан хүн 1 буюу 25.0 хувиар өссөн байна.

4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 452.3 сая төгрөгийн хохирлын 265.8 сая төгрөг буюу 58.8 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнө оноос хохирлын хэмжээ 132.1 сая төгрөг буюу 41.2 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 64.6 сая төгрөг буюу 32.1 хувиар тус тус өссөн байна.



Тав. Зөрчил.

Нийслэлийн Багануур дүүргийн цагдаагийн хэлтсийн хэмжээнд нийт 44441 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 6761 буюу 17.9 хувиар, 44405 зөрчлийг шийдвэрлэсэн нь 6695 буюу 17.8 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 42831 буюу 96.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 528 буюу 1.2 хувийг олон нийтийн газарт зүй бусаар авч явах, 121 буюу 0.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2 зөрчлийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 959 буюу 2.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 43862 иргэн, 6 хуулийн этгээдийг 1335.7 сая төгрөгөөр торгох, 205 хүнийг баривчлуулах, 332 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 6744 буюу 18.2 хувиар, баривчлуулсан шийтгэл 1 буюу 0.5 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 50 буюу 13.1 хувиар буурсан байна.

Багануур дүүрэгт нийт 123 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнө оноос 498 буюу 80.2 хувиар буурсан байх бөгөөд дурдсан хугацаанд 331 хүнийг саатуулсан байна.

---oooOooo--



2.8. БАГАХАНГАЙ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн Багахангай дүүргийн цагдаагийн хэлтэс нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 368 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 79 буюу 21.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 289 буюу 78.5 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх онтой харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 87 буюу 31.0 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 65 буюу 29.0 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 22 буюу 38.6 хувиар тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 22 буюу 27.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 52 буюу 65.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 3 буюу 3.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 234 буюу 81.0 хувийг зөрчлийн хэрэг нээж, 53 буюу 18.3 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 20 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулбал 1 буюу 4.8 хувиар буурч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 0.1 хувийг эзэлж байна.

Тус дүүрэгт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.

Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	1-р хороо	9	7	-2	-22.2
2	2-р хороо	12	13	1	8.3

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 19 буюу 95.0 хувь нь хөнгөн, 1 буюу 5.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулбал хөнгөн хэрэг 1 буюу 5.0 хувиар буурч, хүнд хэрэг өмнөх оны түвшинд байна.

1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	11	10	-9.1	50.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	-	1	-	5.0
2	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	6	6	0.0	30.0
	≥ 5 Хулгайлах	5	2	-60.0	10.0




	Залилах	-	4	-	20.0
3	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	-	-	-
4	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	5.0
5	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	2	3	50.0	15.0
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	2	3	50.0	15.0

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 3 буюу 15.0 хувь нь даваа гарагт, 4 буюу 20.0 хувь нь мягмар гарагт, 2 буюу 10.0 хувь нь лхагва гарагт, 2 буюу 10.0 хувь нь пүрэв гарагт, 4 буюу 20.0 хувь нь баасан гарагт, 1 буюу 5.0 хувь нь бямба гарагт, 4 буюу 20.0 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 4 буюу 20.0 хувь нь 06:00-14:00 цагт, 7 буюу 35.0 хувь нь 14:00-19:00 цагт, 6 буюу 30.0 хувь нь 19:00-22:00 цагт, 3 буюу 15.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 7 буюу 35.0 хувь нь гэр орон сууцанд, 4 буюу 20.0 хувь нь гудамж талбайд, 1 буюу 5.0 хувь нь төрийн бус байгууллага, 4 буюу 20.0 хувь нь аж ахуйн нэгжид, 3 буюу 15.0 хувь нь авто замд, 1 буюу 5.0 хувь нь бусад газарт бүртгэгджээ.




1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 8 буюу 40.0 хувь нь согтуугаар, 1 буюу 5.0 хувь нь хүүхэд оролцож, 5 буюу 25.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 1 буюу 5.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 3 буюу 15.0 хувь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 18 хэрэгт хэрэг бүртгэлт, 12 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 30 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 7 урьд оны үлдэгдэл хэрэг, 22 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 1 хэрэг байна.





Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 25 буюу 83.3 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-6 буюу 24.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;

-17 буюу 68.0 хувийг шүүхэд шилжүүлж;

-2 буюу 8.0 хувийг хэрэгсэхгүй болгож, нийт шалгасан хэргийг бүгдийг хуулийн анхны хугацаанд шийдэж, 1 хүнд холбогдох 8 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Багахангай дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 7 буюу 35.0 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 90.0 хувьтай байгаа нь өмнөх оноос 10.0 нэгжээр өссөн. Нийслэлийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус дүүрэг нь 34.4 нэгжээр их байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 10 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 5 буюу 2 дахин, 9 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 5 буюу 2.3 дахин тус тус өссөн байна.


Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 20 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулбал 1 буюу 4.8 хувиар буурсан байна.

Холбогдогчдын 15 буюу 75.0 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оноос 4 буюу 21.1 хувиар буурч, 5 буюу 25.0 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 3 буюу 2.5 дахин өсч, 1 буюу 5.0 хувийг хүүхэд эзэлж байна.

3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 24 иргэн хохирч, 13 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 4 буюу 20 хувиар өсч, гэмтсэн хүн 1 буюу 7.1 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 68.6 сая төгрөгийн хохирлын 66.4 сая төгрөг буюу 96.8 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирлын хэмжээ 23.2 сая төгрөг буюу 25.3 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирол 22.6 сая төгрөг буюу 51.7 хувиар өссөн байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Багахангай дүүргийн цагдаагийн хэлтсийн хэмжээнд нийт 25228 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 9418 буюу 59.6 хувиар, 25225 зөрчлийг шийдвэрлэсэн нь 9421 буюу 59.6 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 24099 буюу 95.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 12 буюу 0.04 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 12 буюу 0.04 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1105 буюу 4.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 25099 иргэнийг 770.5 сая төгрөгөөр торгож, 42 хүнийг баривчлуулж, 84 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх онтой харьцуулбал иргэнийг торгосон шийтгэл 9430 буюу 60.2 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 1 буюу 1.2 хувиар тус тус өсч, баривчлуулсан шийтгэл 7 буюу 14.3 хувиар буурсан байна.

Багахангай дүүрэгт нийт 13 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 90 буюу 87.4 хувиар буурсан байх бөгөөд дурдсан хугацаанд 34 хүнийг саатуулсан байна.

---oooOooo---



2.9. НАЛАЙХ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн Налайх дүүргийн цагдаагийн хэлтэс нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 3296 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1071 буюу 32.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2225 буюу 67.5 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх онтой харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 283 буюу 9.4 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 374 буюу 53.7 хувиар тус тус өсч, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 91 буюу 3.9 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 308 буюу 28.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 699 буюу 65.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 17 буюу 1.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1671 буюу 75.1 хувийг зөрчлийн хэрэг нээж, 535 буюу 24.0 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 4 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Тус дүүрэгт нийт 327 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 2 буюу 0.6 хувиар буурсан байх бөгөөд нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.3 хувийг эзэлж байна.

Тус дүүрэгт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.

Д/д	Хороо	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	1-р хороо	64	70	6	9.4
2	2-р хороо	51	44	-7	-13.7
3	3-р хороо	33	64	31	93.9
4	4-р хороо	28	32	4	14.3
5	5-р хороо	48	25	-23	-47.9
6	6-р хороо	41	42	1	2.4
7	7-р хороо	27	18	-9	-33.3
8	8-р хороо	37	32	-5	-13.5

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 278 буюу 85.0 хувь нь хөнгөн, 49 буюу 15.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 14 буюу 4.8 хувиар буурч, хүнд хэрэг 12 буюу 32.4 хувиар өссөн байна.




1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	8	10	25.0	3.1
	Үүнээс: Хүнийг алах	4	3	-25.0	0.9
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	138	134	-2.9	41.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	5	1	-80.0	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4	5	25.0	1.5
	Үүнээс: Хүчиндэх	4	4	0.0	1.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	4	4.0 дах	1.2
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		1	-	0.3
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	147	140	-4.8	42.8
	Үүнээс: Хулгайлах	52	22	57.7	6.7
	Дээрэмдэх	5	2	-60.0	0.6
	Залилах	69	87	26.1	26.6
7	Эдийн засгийн гэмт хэрэг	1	1	0.0	0.3
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	17	4.3 дах	5.2
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг		1	-	0.3
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2	-	-	-
Нийт бүртгэгдсэн зөрчлийн 35303 буюу 93.0 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 460 буюу 1.2 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 13 буюу 0.03 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 211 буюу 0.6 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1966 буюу 5.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 36872 иргэн, 1 хуулийн этгээдийг 1638.7 сая төгрөгөөр торгох, 454 хүнийг баривчлуулах, 566 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 2138 буюу 6.2 хувиар, баривчлуулсан шийтгэл 21 буюу 4.8 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 93 буюу 14.1 хувиар буурсан.

Булган аймагт нийт 101 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 400 буюу 79.8 хувиар буурсан байх бөгөөд дурдсан хугацаанд 267 хүнийг саатуулсан байна.

---oooOooo---



3.5 ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Говь-Алтай аймгийн цагдаагийн газар нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 2278 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 509 буюу 22.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1769 буюу 77.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 97 буюу 4.1 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 8 буюу 1.5 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 89 буюу 4.8 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 189 буюу 37.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 295 буюу 58.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 7 буюу 1.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1576 буюу 89.1 хувийг зөрчлийн хэрэг нээж, 119 буюу 6.7 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 59 буюу 3.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Тус аймагт нийт 273 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 42 буюу 18.2 хувиар өссөн байх бөгөөд орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 2.6 хувийг эзэлж байна.

Тус аймагт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2022 он	2023 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Алтай	8	65	57	8.1 дах	10	Тонхил	5	4	-1	-20.0
2	Баян-Уул	5	4	-1	-20	11	Төгрөг	5	-	-	-
3	Бигэр	5	3	-2	-40.0	12	Халиун	12	1	-11	-91.7
4	Бугат	5	7	2	40.0	13	Хөхморьт	3	5	2	66.7
5	Дарви	7	3	-4	-57.1	14	Цогт	13	4	-9	-69.2
6	Дэлгэр	6	10	4	66.7	15	Цээл	5	3	-2	-40.0
7	Есөнбулаг	105	139	34	32.4	16	Чандмань	11	3	-8	-72.7
8	Жаргалан	7	6	-1	-14.3	17	Шарга	7	6	-1	-14.3
9	Тайшир	17	7	-10	-58.8	18	Эрдэнэ	5	3	-2	-40.0

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 231 буюу 84.6 хувь нь хөнгөн, 42 буюу 15.4 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оноос хөнгөн хэрэг 43 буюу 22.9 хувиар өсч, хүнд хэрэг 1 буюу 2.3 хувиар буурсан байна.




1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	4	5	25.0	1.8
	Үүнээс: Хүнийг алах	2	1	-50.0	0.4
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	70	72	2.9	26.4
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7	3	-57.1	1.1
	Үүнээс: Хүчиндэх	4	1	-75.0	0.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	-	1	-	0.4
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	120	149	24.2	54.6
5	Үүнээс: Хулгайлах	31	62	2.0 дах	22.7
	Дээрэмдэх	1	-	-	0.0
	Залилах	47	53	12.8	19.4
6	Эдийн засгийн гэмт хэрэг	1	1	0.0	0.4
7	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	16	16.0 дах	5.9
8	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.4
9	Авилгын гэмт хэрэг		1	-	0.4
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.4
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	11	11	0.0	4.0
12	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	-	-	-
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	13	12	-7.7	4.2
13	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	13	12	-7.7	4.2

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 48 буюу 17.6 хувь нь даваа гарагт, 51 буюу 18.7 хувь нь мягмар гарагт, 38 буюу 13.9 хувь нь лхагва гарагт, 35 буюу 12.8 хувь нь пүрэв гарагт, 38 буюу 13.9 хувь нь баасан гарагт, 32 буюу 11.7 хувь нь бямба гарагт, 31 буюу 11.4 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 89 буюу 32.6 хувь нь 06:00-14:00 цагт, 69 буюу 25.3 хувь нь 14:00-19:00 цагт, 48 буюу 17.6 хувь нь 19:00-22:00 цагт, 67 буюу 24.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 65 буюу 23.8 хувь нь гэр орон сууцанд, 19 буюу 7.0 хувь нь гудамж талбайд, 12 буюу 4.4 хувь нь олон нийтийн газарт, 6 буюу 2.2 хувь нь төрийн байгууллагад, 1 буюу 0.4 хувь нь төрийн бус байгууллагад, 11 буюу 4.0 хувь нь аж ахуйн нэгжид, 9 буюу 3.3 хувь нь авто замд, 149 буюу 54.6 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 57 буюу 20.9 хувь нь согтуугаар, 17 буюу 6.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 19 буюу 7.0 хувь нь бүлэглэн, 18 буюу 6.6 хувь нь хүүхэд оролцож, 1 буюу 0.4 хувь нь гал зэвсгээр, 55 буюу 20.1 хувь нь цахим орчинд, 9 буюу 3.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 398 хэрэгт хэрэг бүртгэлт, 54 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 452 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 117 урьд оны үлдэгдэл хэрэг, 311 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 24 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 293 буюу 64.8 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 98 буюу 33.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 178 буюу 60.8 хувийг шүүхэд шилжүүлж;
- 13 буюу 4.4 хувийг бусад эрүүгийн хэрэгт нэгтгэн;
- 1 буюу 0.3 хувийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт хүргүүлж;
- 3 буюу 1.0 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 64.8 хувь, хуулийн анхны хугацаанд 99.0 хувийг шийдэж, 18 хүнд холбогдох 163 хэргийн үлдэгдэлтэй байна.





Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Говь-Алтай аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 155 буюу 56.8 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 61.6 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.9 нэгжээр буурсан.

Орон нутгийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус аймаг нь ижил түвшинд байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 219 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 67 хэрэг буюу 44.1 хувиар, 135 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 40 буюу 42.1 хувиар тус тус өссөн байна.


Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 242 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 14 буюу 6.1 хувиар өссөн.

Холбогдогчдын 225 буюу 93.0 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оноос 26 буюу 13.1 хувиар, 21 буюу 8.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь урд оноос 2.3 дахин тус тус өсч, 17 буюу 7.0 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 12 буюу 41.4 хувиар буурсан байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


4.1. Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 270 иргэн хохирч, 9 хүн нас барж, 86 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 23 буюу 9.3 хувиар, гэмтсэн хүн 4 буюу 4.9 хувиар тус тус өсч, нас барсан хүн өмнөх оны түвшинд байна.





4.2. Учирсан хохирол.




Иргэнд учирсан 1305.4 сая төгрөгийн хохирлын 917.8 сая төгрөг буюу 70.3 хувийг нөхөн төлүүлж, 107.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 548.6 сая төгрөг буюу 72.5 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 14.1 сая төгрөг буюу 15.0 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 480.5 сая төгрөг буюу 2.1 дахин тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Говь-Алтай аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 25677 зөрчил шалгасан нь өмнөх оноос 3664 буюу 16.6 хувиар, 25632 зөрчлийг шийдвэрлэсэн нь 3649 буюу 16.6 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 17904 буюу 69.7 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 2 буюу 0.03 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 3129 буюу 12.2 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 90 буюу 0.4 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 4552 буюу 17.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 24784 иргэн, 7 хуулийн этгээдийг 778.8 сая төгрөгөөр торгох, 341 хүнийг баривчлуулж, 500 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан нь өмнөх оноос торгосон иргэн 3860 буюу 18.4 хувиар өсч, баривчлуулсан шийтгэл 11 буюу 3.1 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 198 буюу 28.4 хувиар тус тус буурсан байна.

Говь-Алтай аймагт 161 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 142 буюу 46.9 хувиар буурсан байна.

---oooOooo---



3.6. ГОВЬСҮМБЭР АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 1175 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 321 буюу 27.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 854 буюу 72.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх онтой харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 46 буюу 3.8 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 66 буюу 7.2 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 20 буюу 6.6 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 142 буюу 44.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 158 буюу 49.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 8 буюу 2.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 808 буюу 94.6 хувийг зөрчлийн хэрэг нээж, 36 буюу 4.2 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Тус аймагт нийт 139 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 4 буюу 2.8 хувиар буурсан байх бөгөөд орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 1.3 хувийг эзэлж байна.

Тус аймагт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баянтал	17	20	3	17.6
2	Сүмбэр	107	104	-3	-2.8
3	Шивээговь	19	15	-4	-21.1

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 121 буюу 87.1 хувь нь хөнгөн, 18 буюу 12.9 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн гэмт хэрэг өмнөх оны түвшинд, хүнд гэмт хэрэг 4 буюу 18.2 хувиар буурсан байна.

1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.7
	Үүнээс: Хүнийг алах	2	-	-	0.0
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	66	73	10.6	52.5





	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	3	50.0	2.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5	9	80.0	6.5
	Үүнээс: Хүчиндэх	4	9	2.2 дах	6.5
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	-	2	-	1.4
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	59	34	-42.4	24.5
5	Хулгайлах	16	9	-43.8	6.5
	Дээрэмдэх	-	2	-	1.4
	Залилах	24	16	-33.3	11.5
	Мал хулгайлах	9	1	-88.9	0.7
6	Эдийн засгийн гэмт хэрэг	-	3	-	2.2
7	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	7	4	-42.9	2.9
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	-	3	-	2.2
9	Хүрээлэн байгаа орчны эсрэг	1	-	-	0.0
10	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	3	10	3.3 дах	7.2
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	3	10	3.3 дах	7.2

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 27 буюу 19.4 хувь нь даваа гарагт, 21 буюу 15.1 хувь нь мягмар гарагт, 19 буюу 13.7 хувь нь лхагва гарагт, 23 буюу 16.5 хувь нь пүрэв гарагт, 15 буюу 10.8 хувь нь баасан, бямба гарагт, 19 буюу 13.7 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 33 буюу 21.6 хувь нь 06:00-14:00 цагт, 33 буюу 23.7 хувь нь 14:00-19:00 цагт, 30 буюу 21.6 хувь нь 19:00-22:00 цагт, 46 буюу 33.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 53 буюу 38.1 хувь нь гэр орон сууцанд, 20 буюу 14.4 хувь нь гудамж талбайд, 7 буюу 5.0 хувь нь олон нийтийн газарт, 4 буюу 2.9 хувь нь төрийн байгууллагад, 2 буюу 1.4 хувь нь төрийн бус байгууллагад, 11 буюу 7.9 хувь нь аж ахуйн нэгжид, 9 буюу 6.5 хувь нь авто замд, 33 буюу 23.7 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 59 буюу 42.4 хувь нь согтуугаар, 22 буюу 15.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 6 буюу 4.3 хувь нь бүлэглэн, 6 буюу 4.3 хувь нь хүүхэд оролцож, 21 буюу 15.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 14 буюу 10.1 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 247 хэрэгт хэрэг бүртгэлт, 35 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 282 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 83 урьд оны үлдэгдэл хэрэг, 193 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 6 хэрэг байна.


Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 201 буюу 71.3 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-81 буюу 40.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;

-115 буюу 57.2 хувийг шүүхэд шилжүүлж;

-4 буюу 2.0 хувийг хэрэгсэхгүй болгож;

-1 буюу 0.5 хувийг бусад эрүүгийн хэрэгтэй нэгтгэн, нийт шалгасан хэргийн 71.3 хувь, хуулийн анхны хугацаанд 96.0 хувийг шийдэж, 6 хүнд холбогдох 85 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Говьсүмбэр аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 26 буюу 18.7 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 70.0 хувьтай байгаа нь өмнөх оноос 4.5 нэгжээр өссөн байна.

Орон нутгийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус аймаг нь 8.4 нэгжээр их байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 110 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9 хэрэг буюу 7.6 хувиар, үүнээс 77 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 1 буюу 1.3 хувиар тус тус буурсан байна.





Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 121 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 2 буюу 1.7 хувиар өссөн.

Холбогдогчдын 18 буюу 14.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оноос 2 буюу 12.5 хувиар өсч, 103 буюу 85.1 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны түвшинд, 6 буюу 5.0 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 6 буюу 50.0 хувиар буурсан байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 146 иргэн хохирч, үүнээс 7 хүн нас барж, 83 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 4 буюу 2.7 хувиар буурч, нас барсан хүн 5 буюу 3.5 дахин, гэмтсэн хүн 2 буюу 2.5 хувиар тус тус өссөн байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэнд учирсан 779.0 сая төгрөгийн хохирлын 185.7 сая төгрөг буюу 23.8 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 532.1 сая төгрөг буюу 3.2 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 30.8 сая төгрөг буюу 19.9 хувиар тус тус өссөн байна.



Тав. Зөрчил.

Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтсийн хэмжээнд нийт 27033 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 4556 буюу 20.3 хувиар, 27029 зөрчлийг шийдвэрлэсэн нь 4558 буюу 20.3 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 24114 буюу 89.2 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 694 буюу 2.6 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 50 буюу 0.2 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2175 буюу 8.0 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 26533 иргэнийг 856.7 сая төгрөгөөр торгох, 232 хүнийг баривчлуулах, 264 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 4670 буюу 21.4 хувиар, баривчлуулсан шийтгэл 30 буюу 14.9 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 140 буюу 34.7 хувиар буурсан байна.

Говьсүмбэр аймагт нийт 131 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 397 буюу 75.2 хувиар буурсан байх бөгөөд дурдсан хугацаанд 200 хүнийг саатуулсан байна.

---oooOooo---



3.7. ДАРХАН-УУЛ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Дархан-Уул аймгийн цагдаагийн газар нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 4659 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1435 буюу 30.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3224 буюу 69.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 208 буюу 4.3 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 318 буюу 9.0 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 110 буюу 8.3 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 617 буюу 43.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 731 буюу 50.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 18 буюу 1.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2992 буюу 92.8 хувийг зөрчлийн хэрэг нээж, 132 буюу 4.1 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 72 буюу 2.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 714 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 36 буюу 5.3 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.8 хувийг эзэлж байна.

Тус аймагт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Дархан сум	581	623	42	7.2
2	Орхон сум	18	13	-5	-27.8
3	Хонгор сум	38	38	0	0.0
4	Шарын гол сум	41	40	-1	-2.4

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 633 буюу 88.7 хувь нь хөнгөн, 81 буюу 11.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оноос хөнгөн хэрэг 37 буюу 6.2 хувиар өсч, хүнд хэрэг 1 буюу 1.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	9	9	0.0	1.3
	Үүнээс: Хүнийг алах	4	2	-50.0	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	223	190	-14.8	26.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	5	3	-40.0	0.4





3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	13	17	30.8	2.4
	Үүнээс: Хүчиндэх	7	10	42.9	1.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	5	2	-60.0	0.3
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	-	1	-	0.1
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	-	3	-	0.4
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	344	391	13.7	54.8
7	Үүнээс: Хулгайлах	106	128	20.8	17.9
	Дээрэмдэх	11	15	36.4	2.1
	Залилах	170	153	-10.0	21.4
	Малын хулгай	2	13	6.5 дах	1.8
8	Эдийн засгийн гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.3
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	13	28	2.2 дах	3.9
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.3
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	11	14	27.3	2.0
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	17	6	-67.7	0.8
13	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	6	3	-50.0	0.4
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	33	45	36.4	6.3
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	33	45	36.4	6.3
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.1

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 103 буюу 14.4 хувь нь даваа гарагт, 118 буюу 16.5 хувь нь мягмар гарагт, 102 буюу 14.3 хувь нь лхагва гарагт, 88 буюу 12.3 хувь нь пүрэв гарагт, 110 буюу 15.4 хувь нь баасан гарагт, 103 буюу 14.4 хувь нь бямба гарагт, 90 буюу 12.6 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 168 буюу 23.5 хувь нь 06:00-14:00 цагт, 213 буюу 29.8 хувь нь 14:00-19:00 цагт, 104 буюу 14.6 хувь нь 19:00-22:00 цагт, 229 буюу 32.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 259 буюу 36.3 хувь нь гэр орон сууцанд, 157 буюу 22.0 хувь нь гудамж талбайд, 116 буюу 16.2 хувь нь олон нийтийн газарт, 33 буюу 4.6 хувь нь аж ахуйн нэгжид, 46 буюу 6.4 хувь нь авто замд, 8 буюу 1.1 хувь нь нийтийн тээвэрт, 11 буюу 1.5 хувь нь төрийн байгууллагад, 1 буюу 0.1 хувь нь төрийн бус байгууллагад, 83 буюу 11.5 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 196 буюу 27.5 хувь нь согтуугаар, 134 буюу 18.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 82 буюу 11.5 хувь нь бүлэглэн, 59 буюу 8.3 хувь нь хүүхэд оролцож, 41 буюу 5.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 148 буюу 20.7 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 775 хэрэгт хэрэг бүртгэлт, 275 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1050 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 263 урьд оны үлдэгдэл хэрэг, 769 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 18 хэрэг байна.


Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 914 буюу 87.0 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 287 буюу 31.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;

- 497 буюу 54.4 хувийг шүүхэд шилжүүлж;

- 24 буюу 2.6 хувийг хэрэгсэхгүй болгож;

- 106 буюу 11.6 хувийг бусад эрүүгийн хэрэгтэй нэгтгэн, нийт шалгасан хэргийн 87.0 хувь, хуулийн анхны хугацаанд 82.7 хувийг шийдэж, 16 хүнд холбогдох 164 гэмт хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Дархан-Уул аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 306 буюу 42.9 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 75.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 17.5 нэгжээр өссөн.

Орон нутгийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус аймаг нь 13.6 нэгжээр их байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 459 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 34 хэрэг буюу 8.0 хувиар, үүнээс 345 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 100 буюу 40.8 хувиар тус тус өссөн байна.




Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 723 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 171 буюу 31.0 хувиар өссөн.

Холбогдогчдын 136 буюу 18.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оноос 20 буюу 17.2 хувиар, 587 буюу 81.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 151 буюу 34.6 хувиар, 94 буюу 13.0 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 48 буюу 2.0 дахин тус тус өссөн байна.

3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн.

Гэмт хэргийн үлмаас 688 иргэн хохирч, үүнээс 18 хүн нас барж, 229 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 9 буюу 1.3 хувиар өсч, гэмтсэн хүн 24 буюу 9.5 хувиар буурч, нас барсан хүн өмнөх оны түвшинд байна.

4.2. Учирсан хохирол.




Иргэнд учирсан 3030.0 сая төгрөгийн хохирлын 1541.3 сая төгрөг буюу 50.9 хувийг нөхөн төлүүлж, 33.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 2221.4 сая төгрөг буюу 42.3 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 651.7 сая төгрөг буюу 29.7 хувиар тус тус буурч, битүүмжилсэн хөрөнгө 29.4 сая төгрөг буюу 8.5 дахин өссөн байна.



Тав. Зөрчил.

Дархан-Уул аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 60551 зөрчил шалгасан нь өмнөх оноос 11586 буюу 23.7 хувиар, 60588 зөрчлийг шийдвэрлэсэн нь 11599 буюу 23.7 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 51992 буюу 85.9 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 1320 буюу 2.2 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 248 буюу 0.4 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 6973 буюу 11.5 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 58453 иргэн, 33 хуулийн этгээдийг 2486.7 сая төгрөгөөр торгох, 519 хүнийг баривчлуулах, 1583 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 11596 буюу 24.7 хувиар, баривчлуулсан шийтгэл 134 буюу 34.8 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 139 буюу 8.1 хувиар буурсан байна.

Дархан-Уул аймагт нийт 161 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 741 буюу 82.2 хувиар буурсан байх бөгөөд дурдсан хугацаанд 321 хүнийг саатуулсан байна.

---oooOooo---



3.8. ДОРНОГОВЬ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Дорноговь аймгийн цагдаагийн газар нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 4393 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1367 буюу 31.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3026 буюу 68.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх онтой харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 59 буюу 1.4 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 68 буюу 2.3 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 9 буюу 0.7 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 711 буюу 52.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 550 буюу 40.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 11 буюу 0.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 2882 буюу 95.2 хувийг зөрчлийн хэрэг нээж, 109 буюу 3.6 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 1 буюу 0.03 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Тус аймагт нийт 677 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 56 буюу 9.0 хувиар өссөн байх бөгөөд орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.4 хувийг эзэлж байна.

Тус аймагт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2022 он		Өсөлт, бууралт		Д/д	Сум	2023 он		Өсөлт, бууралт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь			Тоо	Хувь		
1	Айраг сум	26	30	4	15.4	8	Өргөн	23	30	7	30.4
2	Алтанширээ	14	15	1	7.1	9	Сайншанд	294	353	59	20.1
3	Даланжаргалан	19	-	-	-	10	Сайхандулаан	12	-	-	-
4	Дэлгэрэх	8	10	2	25.0	11	Улаанбадрах	13	5	-8	-61.5
5	Замын үүд	121	163	42	34.7	12	Хатанбулаг	36	24	-12	-33.3
6	Иххэт	17	21	4	23.5	13	Хөвсгөл	15	9	-6	-40.0
7	Мандах	7	6	-1	-14.3	14	Эрдэнэ	16	11	-5	-31.3

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 570 буюу 84.2 хувь нь хөнгөн, 107 буюу 15.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 50 буюу 9.6 хувиар, хүнд гэмт хэрэг 6 буюу 5.9 хувиар тус тус өссөн байна.

1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	10	18	80	2.7
	Үүнээс: Хүнийг алах	3	9	3.0 дах	1.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	186	179	-3.8	26.4





	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1	5	5.0 дах	0.7	
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	18	32	77.8	4.7	
	Үүнээс: Хүчиндэх	12	26	2.2 дах	3.8	
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	1	0	0.1	
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	0	2	-	0.3	
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	0	2	-	0.3	
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	335	340	1.5	50.2	
7	Үүнээс	Хулгайлах	98	102	4.1	15.1
		Дээрэмдэх	8	4	-50	0.6
		Залилах	163	168	3.1	24.8
		Мал хулгайлах	21	18	-14.3	2.7
8	Эдийн засгийн гэмт хэрэг	4	14	3.5 дах	2.1	
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	4	21	5.3 дах	3.1	
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.3	
11	Авлигын эсрэг гэмт хэрэг	2	1	-50	0.1	
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	14	14	0	2.1	
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг	13	9	-30.8	1.3	
14	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	0	-	0.0	
15	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	32	42	31.3	6.2	
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	31	42	35.5	6.2	

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 109 буюу 16.1 хувь нь даваа гарагт, 97 буюу 14.3 хувь нь мягмар гарагт, 111 буюу 15.0 хувь нь лхагва гарагт, 80 буюу 11.8 хувь нь пүрэв гарагт, 87 буюу 12.9 хувь нь баасан гарагт, 92 буюу 13.6 хувь нь бямба гарагт, 101 буюу 14.9 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 183 буюу 27.0 хувь нь 06:00-14:00 цагт, 184 буюу 27.2 хувь нь 14:00-19:00 цагт, 92 буюу 13.6 хувь нь 19:00-22:00 цагт, 218 буюу 32.2 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 199 буюу 29.4 хувь нь гэр орон сууцанд, 108 буюу 16.0 хувь нь гудамж талбайд, 45 буюу 6.6 хувь нь олон нийтийн газарт, 40 буюу 6.0 хувь нь аж ахуйн нэгжид, 38 буюу 5.6 хувь нь авто замд, 230 буюу 34.1 хувь нь бусад газарт, 4 буюу 0.6 хувь нь нийтийн тээвэрт, 9 буюу 1.3 хувь нь төрийн байгууллагад, 3 буюу 0.4 хувь нь төрийн бус байгууллагад тус тус бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 168 буюу 24.8 хувь нь цахим орчинд, 165 буюу 24.4 хувь нь согтуугаар, 98 буюу 14.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 38 буюу 5.6 хувь нь бүлэглэн, 24 буюу 3.5 хувь нь хүүхэд оролцож, 35 буюу 5.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн үлмаас тус тус үйлдэгдсэн байна.


1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 982 хэрэгт хэрэг бүртгэлт, 181 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1163 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 271 урьд оны үлдэгдэл хэрэг, 853 тухайн оны дугаартай, 37 нь урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 2 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 851 буюу 73.2 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 369 буюу 43.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
- 358 буюу 42.1 хувийг шүүхэд шилжүүлж;
- 28 буюу 3.3 хувийг хэрэгсэхгүй болгож;
- 92 буюу 10.8 хувийг бусад эрүүгийн хэрэгт нэгтгэн;

-4 буюу 0.5 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 73.2 хувь, хуулийн анхны хугацаанд 71.0 хувийг шийдэж, 19 хүнд холбогдох 321 хэргийн үлдэгдэлтэй байна.





Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Дорноговь аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 357 буюу 52.7 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 54.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 12.0 нэгжээр буурсан. Орон нутгийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус аймаг нь 7.4 нэгжээр бага байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 539 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 96 хэрэг буюу 21.7 хувиар өсч, үүнээс 292 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 1 буюу 0.3 хувиар буурсан байна.


Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 468 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 53 буюу 10.2 хувиар буурсан байна.

Холбогдогчдын 84 буюу 17.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оноос 23 буюу 21.5 хувиар, 384 буюу 82.1 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 30 буюу 7.2 хувиар, 30 буюу 6.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 8 буюу 21.1 хувиар тус тус буурсан байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 649 иргэн, 16 хуулийн этгээд хохирч, үүнээс 31 хүн нас барж, 228 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 41 буюу 6.7 хувиар, гэмтсэн хүн 7 буюу 3.2 хувиар, нас барсан хүн 14 буюу 82.4 хувиар тус тус өссөн байна.





4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 3918.5 сая төгрөгийн хохирлын 1521.9 сая төгрөг буюу 38.8 хувийг нөхөн төлүүлж, 36.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 642.2 сая төгрөг буюу 19.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 427.3 сая төгрөг буюу 39.0 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 164.0 сая төгрөг 81.9 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.

Дорноговь аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 35043 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 9356 буюу 36.4 хувиар, 35042 зөрчлийг шийдвэрлэсэн нь 9336 буюу 36.3 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 30246 буюу 86.3 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 100 буюу 0.3 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 228 буюу 0.7 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 3 буюу 0.01 хувь нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 4466 буюу 12.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 33684 иргэн, 35 хуулийн этгээдийг 1639.9 сая төгрөгөөр торгох, 486 хүнийг баривчлуулж, 837 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 9530 буюу 39.5 хувиар өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 201 буюу 19.4 хувиар буурсан бол баривчилуулсан шийтгэл өнгөрсөн оны түвшинд байна.

Дорноговь аймагт нийт 196 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 492 буюу 71.5 хувиар буурсан байх бөгөөд дурдсан хугацаанд 307 хүнийг саатуулсан байна.

---oooOooo---



3.9. ДОРНОД АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Дорнод аймгийн цагдаагийн газар нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 3562 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1252 буюу 35.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2310 буюу 64.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх онтой харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 1322 буюу 27.1 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 396 буюу 24.0 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 926 буюу 28.6 хувиар тус тус буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 567 буюу 45.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 605 буюу 48.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 9 буюу 0.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 2018 буюу 87.4 хувийг зөрчлийн хэрэг нээж, 236 буюу 10.2 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 2 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Тус аймагт нийт 533 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 28 буюу 5.0 хувиар буурсан байх бөгөөд орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 5.0 хувийг эзэлж байна.

Тус аймагт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2022 он	2023 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Баяндун	22	27	5	22.7	8	Сэргэлэн	14	5	-9	-64.3
2	Баянтүмэн	29	20	-9	-31.0	9	Халхгол	13	14	1	7.7
3	Баян-Уул	26	26	0	0.0	10	Хөлөнбуйр	12	15	3	25.0
4	Булган	16	20	4	25.0	11	Хэрлэн	339	322	-17	-5.0
5	Гурван загал	10	6	-4	-40.0	12	Цагаан-Овоо	10	16	6	60.0
6	Дашбалбар	20	19	-1	-5.0	13	Чойбалсан	16	24	8	50.0
7	Матад	26	11	-15	-57.7	14	Чулуунхороот	8	8	0.0	0.0

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 446 буюу 83.7 хувь нь хөнгөн, 87 буюу 16.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 3 буюу 0.7 хувиар, хүнд гэмт хэрэг 25 буюу 22.3 хувиар тус тус буурсан байна.

1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	12	8	-33.3	1.5
	Үүнээс: Хүнийг алах	9	3	-66.7	0.6





2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	237	206	-13.1	38.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	3	-	-	0.0
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	15	21	40.0	3.9
	Үүнээс: Хүчиндэх	12	18	50.0	3.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	5	5	0.0	0.9
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.2
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1	-	-	0.0
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	232	215	-7.3	40.3
7	Хулгайлах	82	79	-3.7	14.8
	Дээрэмдэх	4	8	2.0 дах	1.5
	Залилах	70	55	-21.4	10.3
	Мал хулгайлах	39	38	-2.6	7.1
8	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.2
9	Эдийн засгийн гэмт хэрэг	1	1	0.0	0.2
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	5	2	-60.0	0.4
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	5	9	80.0	1.7
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг	18	26	44.4	4.9
13	Кибер аюулгүй байдлын эсрэг	4	8	2.0 дах	1.6
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	23	30	30.4	5.6
14	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	23	30	30.4	5.6
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1	-	-	0.0

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 77 буюу 14.4 хувь нь даваа гарагт, 90 буюу 16.9 хувь нь мягмар гарагт, 81 буюу 15.2 хувь нь лхагва гарагт, 78 буюу 14.6 хувь нь пүрэв гарагт, 88 буюу 16.5 хувь нь баасан гарагт, 54 буюу 10.1 хувь нь бямба гарагт, 65 буюу 12.2 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 97 буюу 18.2 хувь нь 06:00-14:00 цагт, 115 буюу 21.6 хувь нь 14:00-19:00 цагт, 83 буюу 15.6 хувь нь 19:00-22:00 цагт, 238 буюу 44.7 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 173 буюу 32.5 хувь нь гэр орон сууцанд, 65 буюу 12.2 хувь нь гудамж талбайд, 25 буюу 4.7 хувь нь олон нийтийн газарт, 4 буюу 0.8 хувь нь төрийн байгууллага, 1 буюу 0.2 хувь нь төрийн бус байгууллага, 26 буюу 4.9 хувь нь аж ахуйн нэгжид, 27 буюу 5.1 хувь нь авто замд, 212 буюу 39.8 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 142 буюу 26.6 хувь нь согтуугаар, 56 буюу 10.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 29 буюу 5.4 хувь нь бүлэглэн, 21 буюу 3.9 хувь нь хүүхэд оролцож, 20 буюу 3.8 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 52 буюу 9.8 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 990 хэрэгт хэрэг бүртгэлт, 114 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1104 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 303 урьд оны үлдэгдэл хэрэг, 668 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 133 хэрэг байна.


Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 754 буюу 68.3 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-328 буюу 43.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;

-393 буюу 52.1 хувийг шүүхэд шилжүүлж;

-13 буюу 1.7 хувийг бусад эрүүгийн хэрэгт нэгтгэн;

-20 буюу 2.7 хувийг хэрэгсэхгүй болгож, нийт шалгасан хэргийн 68.3 хувь, хуулийн анхны хугацаанд 90.2 хувийг шийдэж, 11 хүнд холбогдох 354 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Дорнод аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 190 буюу 35.6 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 62.3 хувьтай байгаа нь өмнөх оноос 3.6 нэгжээр буурсан.

Орон нутгийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус аймаг нь 0.7 нэгжээр их байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 430 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 66 хэрэг буюу 18.1 хувиар, үүнээс 268 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 28 буюу 11.7 хувиар тус тус өссөн байна.





Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 441 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 54 буюу 10.9 хувиар буурсан байна.

Холбогдогчдын 52 буюу 11.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оноос 4 буюу 8.3 хувиар өсч, 389 буюу 88.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 58 буюу 13.0 хувиар, 25 буюу 5.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 3 буюу 10.7 хувиар тус тус буурсан байна.

3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 538 иргэн хохирч, үүнээс 19 хүн нас барж, 236 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 34 буюу 5.9 хувиар, гэмтсэн хүн 18 буюу 7.1 хувиар тус тус буурч, нас барсан хүн 1 буюу 5.6 хувиар өссөн байна.

4.2. Учирсан хохирол.




Иргэнд учирсан 2819.1 сая төгрөгийн хохирлын 1919.6 сая төгрөг буюу 68.1 хувийг нөхөн төлүүлж, 175.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 760.4 сая төгрөг буюу 36.9 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 830.0 сая төгрөг буюу 76.2 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 17.3 сая төгрөг буюу 10.9 хувиар тус тус өссөн байна.



Тав. Зөрчил.

Дорнод аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 30605 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 11039 буюу 56.4 хувиар, 30500 зөрчлийг шийдвэрлэсэн нь 11095 буюу 57.2 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 25830 буюу 84.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 2166 буюу 7.1 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 180 буюу 0.6 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2429 буюу 7.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 29090 иргэн, 5 хуулийн этгээдийг 1277.2 сая төгрөгөөр торгох, 440 хүнийг баривчлуулж, 965 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 11257 буюу 63.1 хувиар, баривчлуулсан шийтгэл 85 буюу 23.9 хувиар тус тус өсч, торгож тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 245 буюу 20.2 хувиар буурсан байна.

Дорнод аймагт нийт 1475 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 1310 буюу 47.0 хувиар буурсан байх бөгөөд дурдсан хугацаанд 418 хүнийг саатуулсан байна.

---oooOooo---



3.10. ДУНДГОВЬ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Дундговь аймгийн цагдаагийн газар нь 2023 онд иргэн, хуулийн этгээдээс 1663 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 635 буюу 38.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1028 буюу 61.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 72 буюу 4.1 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 120 буюу 10.5 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 48 буюу 8.2 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 215 буюу 33.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 393 буюу 61.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 8 буюу 1.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 922 буюу 89.7 хувийг зөрчлийн хэрэг нээж, 87 буюу 8.5 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 2 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 246 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1 буюу 0.4 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 2.3 хувийг эзэлж байна.

Тус аймагт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Адаацаг	13	17	4	30.8
2	Баянжаргалан	3	7	4	2.3 дах
3	Говь-Угтаал	5	3	-2	-40.0
4	Гурвансайхан	9	21	12	2.3 дах
5	Дэлгэрхангай	3	7	4	2.3 дах
6	Дэлгэрцогт	9	10	1	11.1
7	Дэрэн	11	9	-2	-18.2
8	Луус	9	9	0	0.0
9	Өлзийт	16	8	-8	-50.0
10	Өндөршил	6	4	-2	-33.3
11	Сайнцагаан	131	113	-18	-13.7
12	Сайхан-Овоо	7	6	-1	-14.3
13	Хулд	8	13	5	62.5
14	Цагаандэлгэр	4	4	0	0.0
15	Эрдэнэдалай	13	15	2	15.4



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 217 буюу 88.2 хувь нь хөнгөн, 29 буюу 11.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оноос хөнгөн хэрэг 29 буюу 15.4 хувиар өсч, хүнд хэрэг 30 буюу 50.8 хувиар буурсан байна.


1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт ээлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	9	3	-66.7	1.2
	Үүнээс: Хүнийг алах	7	1	-85.7	0.4
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	97	117	20.6	47.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	2	0.0	0.8
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	13	6	-53.8	2.4
	Үүнээс: Хүчиндэх	10	3	-70.0	1.2
4	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1	-	-	-
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	95	85	-10.5	34.6
5	Үүнээс Хулгайлах	39	40	2.6	16.3
	Дээрэмдэх	2	3	50.0	1.2
	Залилах	28	32	14.3	13.0
	Мал хулгайлах	9	2	-77.8	0.8
6	Эдийн засгийн гэмт хэрэг	-	2	-	0.8
7	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3	2	-33.3	0.8
8	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	3	-25.0	1.2
9	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	7	-	-	-
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	18	28	55.6	11.4
10	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	18	28	55.6	11.4

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 46 буюу 18.7 хувь нь даваа гарагт, 37 буюу 15.0 хувь нь мягмар гарагт, 33 буюу 13.4 хувь нь лхагва гарагт, 45 буюу 18.3 хувь нь пүрэв гарагт, 36 буюу 14.6 хувь нь баасан гарагт, 21 буюу 8.5 хувь нь бямба гарагт, 28 буюу 11.5 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 61 буюу 24.8 хувь нь 06:00-14:00 цагт, 75 буюу 30.5 хувь нь 14:00-19:00 цагт, 40 буюу 16.3 хувь нь 19:00-22:00 цагт, 70 буюу 28.4 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 94 буюу 38.2 хувь нь гэр орон сууцанд, 18 буюу 7.3 хувь нь гудамж талбайд, 5 буюу 2.0 хувь нь олон нийтийн газарт, 2 буюу 0.8 хувь нь нийтийн тээвэрт, 6 буюу 2.4 хувь нь төрийн байгууллагад, 5 буюу 2.0 хувь нь төрийн бус байгууллагад, 8 буюу 3.3 хувь нь аж ахуйн нэгжид, 26 буюу 10.6 хувь нь авто замд, 82 буюу 33.3 хувь нь бусад газарт тус тус үйлдэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 83 буюу 33.7 хувь нь согтуугаар, 27 буюу 11.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 6 буюу 2.4 хувь нь бүлэглэн, хүүхэд оролцож, 7 буюу 2.8 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 20 буюу 8.1 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.


1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2023 онд 436 хэрэгт хэрэг бүртгэлт, 81 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 517 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 158 урьд оны үлдэгдэл хэрэг, 323 энэ оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 35, урьд оны түдгэлзүүлсэнээс сэргээсэн 1 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 402 буюу 77.8 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 189 буюу 47.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,
- 203 буюу 50.5 хувийг шүүхэд шилжүүлж,
- 3 буюу 0.7 хувийг хэрэгсэхгүй болгож,

-7 буюу 1.7 хувийг бусад эрүүгийн хэрэгт нэгтгэж, нийт шалгасан хэргийн 77.8 хувь, хуулийн анхны хугацаанд 73.4 хувийг шийдэж, 24 хүнд холбогдох 121 гэмт хэргийн үлдэгдэлтэй байна.





Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Дундговь аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 88 буюу 35.8 хувийг далд аргаар үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 66.9 хувьтай байгаа нь өмнөх оноос 7.4 нэгжээр өссөн байна.

Орон нутгийн хэмжээний илрүүлэлттэй харьцуулахад тус аймаг нь 5.3 нэгжээр их байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 181 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 11 хэрэг буюу 6.5 хувиар, үүнээс 121 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 20 буюу 19.8 хувиар тус тус өссөн байна.


Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 197 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны түвшинд байна.

Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 696 иргэн, 1 хуулийн этгээд хохирч, үүнээс 57 хүн нас барж, 204 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 28 буюу 3.9 хувиар, гэмтсэн хүн 64 буюу 23.9 хувиар тус тус буурч, нас барсан хүн 27 буюу 90.0 хувиар өссөн байна.





4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 4139.6 сая төгрөгийн хохирлын 2586.7 сая төгрөг буюу 62.5 хувийг нөхөн төлүүлж, 0.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 823.9 сая төгрөг буюу 24.8 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 1126.8 сая төгрөг буюу 77.2 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 47.3 сая төгрөг буюу 98.5 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.

Хэнтий аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 33331 зөрчил шалгасан нь өмнөх оноос 2654 буюу 8.7 хувиар, 33105 зөрчлийг шийдвэрлэсэн нь 2697 буюу 8.9 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 28724 буюу 86.2 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 203 буюу 0.6 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 285 буюу 0.9 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 4119 буюу 12.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 31878 иргэнийг 1241.3 сая төгрөгөөр торгох, 507 хүнийг баривчлуулах, 717 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 2872 буюу 9.9 хувиар өсч, баривчлуулсан шийтгэл 33 буюу 6.1 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 144 буюу 16.7 хувиар тус тус буурсан байна.

Хэнтий аймагт нийт 353 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 14 буюу 3.8 хувиар буурсан байх бөгөөд дурдсан хугацаанд 193 хүнийг саатуулсан байна.

---oooOooo---



ДӨРӨВ. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ.

4.1 ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2023 онд 199 бүртгэгдсэн нь өмнөх онтой ижил, нийслэлийн хэмжээнд 121 бүртгэгдсэн нь 18 буюу 17.5 хувиар өсч, орон нутгийн хэмжээнд 78 бүртгэгдсэн нь 18 гэмт хэргээр буюу 18.8 хувиар буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	199	199	0.0	0.6	0.6
Нийслэлд	103	121	17.5	0.4	0.5
Орон нутагт	96	78	-18.8	0.9	0.7

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/.







1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 34 буюу 17.2 хувь нь даваа гарагт, 29 буюу 14.6 хувь нь мягмар гарагт, 27 буюу 13.6 хувь нь лхагва гарагт, 31 буюу 15.7 хувь нь пүрэв гарагт, 25 буюу 12.6 хувь нь баасан гарагт, 26 буюу 13.1 хувь нь бямба гарагт, 27 буюу 13.1 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 52 буюу 26.1 хувь нь 06:00-14:00 цагт, 33 буюу 16.6 хувь нь 14:00-19:00 цагт, 46 буюу 23.1 хувь нь 19:00-22:00 цагт, 68 буюу 34.2 хувь нь 22:00-06:00 цагт тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 116 буюу 58.3 хувь нь гэр, орон сууцанд, 31 буюу 15.6 хувь нь гудамж талбайд, 10 буюу 5.0 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.5 хувь нь төрийн байгууллагад, 8 буюу 4.0 хувь нь аж ахуйн нэгжид, 33 буюу 16.6 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 140 буюу 70.4 хувь нь согтуугаар, 29 буюу 14.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 8 буюу 4.0 хувь нь бүлэглэн, 22 буюу 11.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 118 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 24 хэрэг буюу 25.5 хувиар, үүнээс 117 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 26 хэрэг буюу 26.6 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 99.2 хувь байгаа нь өмнөх оноос 2.3 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 97.1 хувь байгаа нь 4.3 нэгжээр тус тус өсч, нийслэлийн хэмжээнд 100.0 хувь байгаа нь өмнөх онтой ижил түвшинд байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.



2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 215 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 5 буюу 2.4 хувиар өссөн.

Холбогдогчдын 29 буюу 13.5 хувь нь эмэгтэй, 186 буюу 86.5 хувь нь эрэгтэй, 3 буюу 1.4 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 4 буюу 2.1 хувиар хувиар, хүүхэд 9 буюу 75.0 хувиар буурч, эмэгтэй хүн 9 буюу 45.0 хувиар өссөн байна.




2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 202 иргэн хохирч, үүнээс 172 хүн нас барж, 33 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 1 буюу 0.5 хувиар, гэмтсэн хүн 12 буюу 57.1 хувиар тус тус өсч, нас барсан хүн 11 буюу 6.0 хувиар буурсан.



3.2. Учирсан хохирол.



Иргэдэд учирсан 1725.5 сая төгрөгийн хохирлын 1725.5 сая төгрөг буюу 100.0 хувийг нөхөн төлүүлж, 100.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 2279.9 сая төгрөг буюу 56.9 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 2099.1 сая төгрөг буюу 54.3 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 15.3 сая төгрөг буюу 15.3 хувиар тус тус буурсан байна.

---oooOooo---



4.2 ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Цагдаагийн байгууллагын хэмжээнд энэ бүлгийн гэмт хэрэг 2023 онд 8531 бүртгэгдсэн нь өмнөх оноос 794 гэмт хэргээр буюу 8.5 хувиар, нийслэлийн хэмжээнд 5207 бүртгэгдсэн нь 580 гэмт хэргээр буюу 10.0 хувиар, орон нутгийн хэмжээнд 3321 бүртгэгдсэн нь 213 хэргээр буюу 6.0 хувиар тус тус буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	9325	8531	8.5	26.4	24.0
Нийслэлд	5787	5207	10.0	23.8	20.8
Орон нутагт	3534	3321	6.0	32.1	31.4
Бусад	4	3	-25.0	36.4	15.0

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/.






1.4. Гэмт хэргийн төрөл /Эрүүгийн хуулийн зүйл ангиар/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	2022 он	2023 он	Өсөлт, бууралт		Тухайн хэрэгт эзлэх хувь
				Тоо	Хувь	
1	11.1 дүгээр зүйл.Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	411	359	-52	-12.7	4.2
2	11.2 дугаар зүйл.Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах	1	1			
3	11.3 дугаар зүйл.Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	58	74	16	27.6	0.9
4	11.4 дүгээр зүйл.Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	760	694	-66	-8.7	8.1
5	11.5 дугаар зүйл.Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	74	70	-4	-5.4	0.8
6	11.6 дугаар зүйл.Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	7923	7207	-716	-9.0	84.5
7	11.7 дугаар зүйл.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	98	126	28	28.6	1.5

1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 1213 буюу 14.2 хувь нь даваа гарагт, 1238 буюу 14.5 хувь нь мягмар гарагт, 1137 буюу 13.3 хувь нь лхагва гарагт, 1158 буюу 13.6 хувь нь пүрэв гарагт, 1288 буюу 15.1 хувь нь баасан гарагт, 1286 буюу 15.1 хувь нь бямба гарагт, 1211 буюу 14.2 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 1813 буюу 21.3 хувь нь 06:00-14:00 цагт, 1857 буюу 21.8 хувь нь 14:00-19:00 цагт, 1515 буюу 17.8 хувь нь 19:00-22:00 цагт, 3346 буюу 39.2 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 3290 буюу 38.6 хувь нь гэр орон сууцанд, 2324 буюу 27.2 хувь нь гудамж, талбайд, 1169 буюу 13.7 хувь нь олон нийтийн газарт, 17 буюу 0.2 хувь нь нийтийн тээвэрт, 48 буюу 0.6 хувь төрийн байгууллагад, 35 буюу 0.4 хувь нь төрийн бус байгууллагад, 524 буюу 6.1 хувь нь аж ахуй нэгжид, 19 буюу 0.2 хувь нь авто замд, 1105 буюу 13.0 хувь нь бусад газарт үйлдэгджээ.





1.6. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 3661 буюу 42.9 хувь нь согтуугаар, 383 буюу 4.5 хувь нь хүүхэд оролцож, 832 буюу 9.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 265 буюу 3.1 хувь нь бүлэглэн, 1255 буюу 14.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 7224 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 744 буюу 9.3 хувиар буурсан.

Холбогдогчдын 747 буюу 10.3 хувь нь эмэгтэй, 6477 буюу 89.7 хувь нь эрэгтэй, 436 буюу 6.0 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эмэгтэй хүн 160 буюу 17.6 хувиар, эрэгтэй хүн 584 буюу 8.3 хувиар тус тус буурч, хүүхэд 73 буюу 20.1 хувиар өссөн байна.

2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


3.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 8923 иргэн хохирч, үүнээс 6 хүн нас барж, 8361 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 813 буюу 8.4 хувиар, гэмтсэн хүн 697 буюу 7.7 хувиар, нас барсан хүн 17 буюу 73.9 хувиар тус тус буурсан байна.

Гэмтсэн иргэдийн гэмтлийн зэргээр нь авч үзвэл 7221 буюу 86.4 хувь нь хөнгөн, 723 буюу 8.6 хувь нь хүндэвтэр, 417 буюу 5.0 хувь нь хүнд зэргийн гэмтэл учирсан байна.



3.2. Учирсан хохирол.



Хэргийн улмаас иргэдэд учирсан 11928.8 сая төгрөгийн хохирлын 79.6 хувийг нөхөн төлүүлж, 489.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос битүүмжилсэн хөрөнгө 42.4 сая төгрөг буюу 9.5 хувиар өсч, учирсан хохирол 482.1 сая төгрөг буюу 3.9 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 333.6 сая төгрөг буюу 3.4 хувиар тус тус буурсан байна.

---oooOooo---



4.3. ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГ.

Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 564 бүртгэгдсэн нь өмнөх оноос 14 буюу 2.5 хувиар, нийслэлийн хэмжээнд 287 бүртгэгдсэн нь 2 буюу 0.7 хувиар, орон нутгийн хэмжээнд 275 бүртгэгдсэн нь 11 буюу 4.2 хувиар, бусад газарт 2 бүртгэгдсэн нь 1 буюу 2.0 дахин тус тус өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	550	564	2.5	1.6	1.6
Нийслэлд	285	287	0.7	1.2	1.1
Орон нутагт	264	275	4.2	2.4	2.6
Бусад	1	2	2.0 дах	9.1	10.0

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.




1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/.




1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 86 буюу 15.2 хувь нь даваа гарагт, 92 буюу 16.3 хувь нь мягмар гарагт, 75 буюу 13.3 хувь нь лхагва гарагт, 79 буюу 14.0 хувь нь пүрэв гарагт, 77 буюу 13.7 хувь нь баасан гарагт, 79 буюу 14.0 хувь нь бямба гарагт, 76 буюу 13.5 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 124 буюу 22.0 хувь нь 06:00-14:00 цагт, 141 буюу 25.0 хувь нь 14:00-19:00 цагт, 68 буюу 12.1 хувь нь 19:00-22:00 цагт, 231 буюу 41.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 385 буюу 68.3 хувь нь гэр, орон сууцанд, 45 буюу 8.0 хувь нь гудамж талбайд, 40 буюу 7.1 хувь нь олон нийтийн газарт, нийтийн тээвэр 2 буюу 0.4 хувь, төрийн байгууллагад 1 буюу 0.2 хувь, 12 буюу 2.1 хувь нь аж ахуйн нэгжид, 1 буюу 0.2 хувь нь төрийн бус байгууллагад, 3 буюу 0.5 хувь нь нийтийн тээвэрт, 78 буюу 13.8 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 133 буюу 23.6 хувь нь согтуугаар, 38 буюу 6.7 хувь нь хүүхэд оролцож, 103 буюу 18.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 28 буюу 5.0 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.



Хэрэг бүртгэлтийн 467 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 24 хэрэг буюу 5.4 хувиар өсч, үүнээс 218 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 18 буюу 7.6 хувиар буурсан.


Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 46.7 хувь байгаа нь өмнөх оноос 6.6 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 55.6 хувь байгаа нь 2.9 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 39.6 хувь байгаа нь 9.4 нэгжээр тус тус буурсан байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 360 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 11 буюу 3.0 хувиар, 52 буюу 14.4 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь 16 буюу 44.4 хувиар тус тус өссөн байна

2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 565 иргэн хохирч, 45 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 13 буюу 2.4 хувиар өсч, гэмтсэн хүн 14 буюу 23.7 хувиар буурсан.

Хохирсон иргэдийн 395 буюу 69.9 хувь нь 17 хүртэлх насны хүүхэд байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт хохирогч болсон 10 хүний 7 нь насанд хүрээгүй хүн байна.

Хохирсон хүүхдийг насаар нь авч үзвэл 20 буюу 5.1 хувь нь 7 хүртэлх, 150 буюу 38.0 хувь нь 8-13 насны, 225 буюу 57.0 хувь нь 14-17 насны хүүхэд байна.



---oooOooo---



4.4. ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Цагдаагийн байгууллагын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг 2023 онд 5401 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 676 буюу 11.1 хувиар, нийслэлийн хэмжээнд 3618 бүртгэгдсэн нь 561 буюу 13.4 хувиар, орон нутгийн хэмжээнд 1783 бүртгэгдсэн нь 115 буюу 6.1 хувиар тус тус буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	6077	5401	-11.1	17.2	15.2
Нийслэлд	4179	3618	-13.4	17.2	14.5
Орон нутагт	1898	1783	-6.1	17.2	16.9

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.




1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/.



1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 808 буюу 15.0 хувь нь даваа гарагт, 806 буюу 14.9 хувь нь мягмар гарагт, 810 буюу 15.0 хувь нь лхагва гарагт, 727 буюу 13.5 хувь нь пүрэв гарагт, 831 буюу 15.4 хувь нь баасан гарагт, 702 буюу 13.0 хувь нь бямба гарагт, цагаар нь авч үзвэл 1632 буюу 30.2 хувь нь 06:00-14:00 цагт, 1464 буюу 27.1 хувь нь 14:00-19:00 цагт, 624 буюу 11.6 хувь нь 19:00-22:00 цагт, 1681 буюу 31.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 1882 буюу 34.8 хувь нь гэр, орон сууцанд, 1119 буюу 20.7 хувь нь гудамж талбайд, 933 буюу 17.3 хувь нь олон нийтийн газарт, 55 буюу 1.0 хувь нь нийтийн тээвэрт, 29 буюу 0.5 хувь нь төрийн байгууллагад, 31 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 587 буюу 10.9 хувь нь аж ахуйн нэгжид, 765 буюу 14.1 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



Гэр, орон сууц
34.8%

Гудамж, талбай
20.7%

Олон нийтийн
газар 17.3%

Аж ахуйн нэгж
10.9%

Нийтийн тээвэрт
1.0%

Бусад газар 15.3%

1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 400 буюу 7.4 хувь нь согтуугаар, 273 буюу 7.0 хувь нь хүүхэд оролцож, 424 буюу 7.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 472 буюу 8.7 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 5159 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 564 хэрэг буюу 9.9 хувиар буурч, үүнээс 2307 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 155 буюу 7.2 хувиар өссөн.



Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 44.7 хувь байгаа нь өмнөх оноос 7.1 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 51.9 хувь байгаа нь 2.1 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 41.4 хувь байгаа нь 8.9 нэгжээр тус тус өссөн байна.


Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 3221 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 185 буюу 6.1 хувиар өссөн.

Холбогдогчдын 341 буюу 10.6 хувь нь эмэгтэй, 2880 буюу 89.4 хувь нь эрэгтэй, 541 буюу 16.8 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 132 буюу 4.8 хувиар, эмэгтэй хүн 53 буюу 18.4 хувиар, хүүхэд 120 буюу 28.5 хувиар тус тус өссөн байна.


2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 5475 иргэн, 22 хуулийн этгээд хохирсон нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 619 буюу 10.2 хувиар буурч, хуулийн этгээд 7 буюу 46.7 хувиар өссөн.



3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 37348.3 сая төгрөгийн хохирлын 24246.9 сая төгрөг буюу 64.9 хувийг нөхөн төлүүлж, 206.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос нийт учирсан хохирол 16855.3 сая төгрөг буюу 82.2 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 18184.5 сая төгрөг буюу 4.0 дахин тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 34.2 сая төгрөг буюу 14.2 хувиар буурсан байна.



---0000000---

4.5. ХУВИЙН ӨМЧИЙГ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 4717 бүртгэгдсэн нь өмнөх оноос 542 буюу 10.3 хувиар, орон нутгийн хэмжээнд 1560 бүртгэгдсэн нь 128 буюу 7.6 хувиар, нийслэлийн хэмжээнд 3157 бүртгэгдсэн нь 414 буюу 11.6 хувиар тус тус буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	5259	4717	-10.3	14.9	13.3
Нийслэлд	3571	3157	-11.6	14.7	12.6
Орон нутагт	1688	1560	-7.6	15.3	14.8

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.




1.3. Гэмт хэргийн түвшин /2005-2023 он/.




1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 698 буюу 14.8 хувь нь даваа гарагт, 695 буюу 14.7 хувь нь мягмар гарагт, 706 буюу 15.0 хувь нь лхагва гарагт, 631 буюу 13.4 хувь нь пүрэв гарагт, 727 буюу 15.4 хувь нь баасан гарагт, 614 буюу 13.0 хувь нь бямба гарагт, 646 буюу 13.7 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 1415 буюу 30.0 хувь нь 06:00-14:00 цагт, 1270 буюу 26.9 хувь нь 14:00-19:00 цагт, 547 буюу 11.6 хувь нь 19:00-22:00 цагт, 1485 буюу 31.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 1852 буюу 39.3 хувь нь гэр, орон сууцанд, 819 буюу 17.4 хувь нь гудамж талбайд, 848 буюу 18.0 хувь нь олон нийтийн газарт, 483 буюу 10.2 хувь нь аж ахуйн нэгжид, 25 буюу 0.5 хувь нь нийтийн тээвэрт, 18 буюу 0.4 хувь нь төрийн байгууллагад, 23 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 649 буюу 13.8 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 362 буюу 7.7 хувь нь согтуугаар, 340 буюу 7.2 хувь нь хүүхэд оролцож, 352 буюу 7.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 407 буюу 8.6 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.



Хэрэг бүртгэлтийн 4519 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 450 хэрэг буюу 9.1 хувиар буурч, үүнээс 1994 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 137 буюу 7.4 хувиар өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 44.1 хувь байгаа нь өмнөх оноос 6.8 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 40.8 хувь байгаа нь 8.8 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 51.4 хувь байгаа нь 1.7 нэгжээр тус тус өссөн байна.


Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 2756 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 145 буюу 5.6 хувиар өссөн.

Холбогдогчдын 284 буюу 10.3 хувь нь эмэгтэй, 2472 буюу 89.7 хувь нь эрэгтэй, 475 буюу 17.2 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 108 буюу 4.6 хувиар, эмэгтэй хүн 37 буюу 15.0 хувиар, хүүхэд 109 буюу 29.8 хувиар тус тус өссөн байна.


2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 4809 иргэн, 7 хуулийн этгээд, 2107 эмэгтэй хүн, 217 хүүхэд хохирсон нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 483 буюу 9.1 хувиар, эмэгтэй хүн 278 буюу 11.7 хувиар тус тус буурч, хүүхэд 59 буюу 37.3 хувиар, хуулийн этгээд 3 буюу 75.0 хувиар тус тус өссөн.





3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 15257.1 сая төгрөгийн хохирлын 4159.8 сая төгрөг буюу 27.3 хувийг нөхөн төлүүлж, 181.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 1622.4 сая төгрөг буюу 9.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 625.0 сая төгрөг буюу 13.1 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 19.7 сая төгрөгөөр буюу 9.8 хувиар тус тус буурсан байна.

---oooOooo---

4.6. ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ.

Нэг. Бүртгэгдсэн хэрэг.


1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 316 бүртгэгдсэн нь өмнөх оноос 141 буюу 30.9 хувиар, нийслэлийн хэмжээнд 302 бүртгэгдсэн нь 144 хэргээр буюу 32.3 хувиар тус тус буурч, орон нутгийн хэмжээнд 14 бүртгэгдсэн нь 3 буюу 27.3 хувиар өссөн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	457	316	-30.9	1.3	0.9
Нийслэлд	446	302	-32.3	1.8	1.2
Орон нутагт	11	14	27.3	0.1	0.1


1.3. Гэмт хэргийн түвшин /2011-2023 он/.




1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.



Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 48 буюу 15.2 хувь нь даваа гарагт, 43 буюу 13.6 хувь нь мягмар гарагт, 54 буюу 17.1 хувь нь лхагва гарагт, 51 буюу 16.1 хувь нь пүрэв гарагт, 48 буюу 15.2 хувь нь баасан гарагт, 46 буюу 14.6 хувь нь бямба гарагт, 26 буюу 13.3 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 126 буюу 39.9 хувь нь 06:00-14:00 цагт, 119 буюу 37.7 хувь нь 14:00-19:00 цагт, 39 буюу 12.3 хувь нь 19:00-22:00 цагт, 32 буюу 10.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 3 буюу 0.9 хувь нь гэр, орон сууцанд, 170 буюу 53.8 хувь нь гудамж талбайд, 60 буюу 19.0 хувь нь олон нийтийн газарт, 29 буюу 9.2 хувь нь нийтийн тээвэрт, 28 буюу 8.9 хувь нь аж ахуйн нэгжид, 26 буюу 7.9 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 11 буюу 3.5 хувь нь согтуугаар, 3 буюу 0.9 хувь нь хүүхэд оролцож, 59 буюу 18.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 14 буюу 4.4 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 294 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 144 хэрэг буюу 32.9 хувиар, үүнээс 138 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 8 буюу 5.5 хувиар тус тус буурсан.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 46.9 хувь байгаа нь өмнөх оноос 13.6 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 45.9 хувь байгаа нь 13.3 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 69.2 хувь байгаа нь 2.6 нэгжээр тус тус өссөн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.


2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 180 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 8 буюу 4.7 хувиар өссөн.



Холбогдогчдын 44 буюу 24.4 хувь нь эмэгтэй, 136 буюу 75.5 хувь нь эрэгтэй, 3 буюу 1.7 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 1 буюу 0.7 хувиар буурсан, эмэгтэй хүн 9 буюу 25.7 хувиар өсч, хүүхэд өмнөх оны түвшинд байна.


2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 312 иргэн хохирсон нь өмнөх онтой харьцуулбал 139 буюу 30.8 хувиар буурсан байна. Хохирогчдын 245 буюу 78.5 хувь нь эмэгтэй, 90 буюу 28.8 хувь нь хүүхэд байгаа нь өмнөх оноос хохирсон хүн 139 буюу 30.8 хувиар, эмэгтэй хүн 110 буюу 31.0 хувиар, хүүхэд 26 буюу 22.4 хувиар тус тус буурсан байна.



3.2. Учирсан хохирол.



Хэргийн улмаас иргэдэд учирсан 600.6 сая төгрөгийн хохирлын 162.4 сая төгрөг буюу 27.0 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос учирсан хохирол 62.6 сая төгрөг буюу 9.4 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирол 4.7 сая төгрөг буюу 3.0 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 0.7 сая төгрөг буюу 55.0 хувиар тус тус өссөн байна.

---oooOooo---



4.7. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 643 бүртгэгдсэн нь өмнөх оноос 135 буюу 17.4 хувиар, орон нутгийн хэмжээнд 605 бүртгэгдсэн нь 137 буюу 18.5 хувиар тус тус буурч, нийслэлийн хэмжээнд 38 бүртгэгдсэн нь 2 буюу 5.5 хувиар өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	778	643	-17.4	2.2	1.8
Нийслэлд	36	38	5.6	0.1	0.2
Орон нутагт	742	605	-18.5	6.7	5.7

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.




1.3. Гэмт хэргийн түвшин /2006-2023 он/.



1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.



Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 81 буюу 12.6 хувь нь даваа гарагт, 99 буюу 15.4 хувь нь мягмар гарагт, 101 буюу 15.7 хувь нь лхагва гарагт, 100 буюу 15.6 хувь нь пүрэв гарагт, 78 буюу 12.1 хувь нь баасан гарагт, 88 буюу 13.7 хувь нь бямба гарагт, 96 буюу 14.9 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 126 буюу 19.6 хувь нь 06:00-14:00 цагт, 117 буюу 18.2 хувь нь 14:00-19:00 цагт, 108 буюу 16.8 хувь нь 19:00-22:00 цагт, 292 буюу 45.4 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 14 буюу 2.2 хувь нь согтуугаар, 7 буюу 1.1 хувь нь хүүхэд оролцож, 26 буюу 4.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 122 буюу 19.0 хувь нь бүлэглэн, 399 буюу 62.0 хувь нь тээврийн хэрэгсэл ашиглаж тус тус үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 623 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 64 хэрэг буюу 9.3 хувиар, үүнээс 351 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 63 буюу 15.2 хувиар тус тус буурсан.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 56.3 хувь байгаа нь өмнөх оноос 3.9 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 57.3 хувь байгаа нь 6.2 нэгжээр тус тус буурсан байна.



Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 532 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 221 буюу 29.3 хувиар буурсан.

Холбогдогчдын 9 буюу 1.7 хувь нь эмэгтэй, 523 буюу 98.3 хувь нь эрэгтэй, 9 буюу 1.7 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 216 буюу 29.2 хувиар, эмэгтэй хүн 5 буюу 35.7 хувиар, хүүхэд 17 буюу 65.4 хувиар тус тус буурсан байна.

2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 664 иргэн хохирсон нь өмнөх онтой харьцуулбал 134 буюу 16.8 хувиар буурсан.



3.2. Учирсан хохирол.



Хэргийн улмаас иргэдэд учирсан 3297.8 сая төгрөгийн хохирлын 1200.3 сая төгрөг буюу 36.4 хувийг нөхөн төлүүлж, 184.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 55.3 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 494.3 сая төгрөг буюу 29.2 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 105.0 сая төгрөг буюу 36.3 хувиар тус тус буурсан байна.

3.3. Хулгайлагдсан малын тоо.



1171



1139



64



771



3270

---oooOooo---



4.8. ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРЭГ.

Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг 2023 онд 392 бүртгэгдсэн нь өмнөх оноос 93 гэмт хэргээр буюу 19.2 хувиар, нийслэлийн хэмжээнд 310 бүртгэгдсэн нь 86 буюу 21.7 хувиар, орон нутгийн хэмжээнд 82 бүртгэгдсэн нь 7 буюу 7.9 хувиар тус тус буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	485	392	-19.2	1.4	1.1
Нийслэлд	396	310	-21.7	1.6	1.2
Орон нутагт	89	82	-7.9	0.8	0.8

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/.







1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 53 буюу 13.5 хувь нь даваа гарагт, 53 буюу 13.5 хувь нь мягмар гарагт, 56 буюу 14.3 хувь нь лхагва гарагт, 54 буюу 13.8 хувь нь пүрэв гарагт, 53 буюу 13.5 хувь нь баасан гарагт, 54 буюу 13.8 хувь нь бямба гарагт, 69 буюу 17.6 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 94 буюу 24.0 хувь нь 06:00-14:00 цагт, 77 буюу 19.6 хувь нь 14:00-19:00 цагт, 66 буюу 16.8 хувь нь 19:00-22:00 цагт, 155 буюу 39.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 253 буюу 64.5 хувь нь гудамж, талбайд, 51 буюу 13.0 хувь нь гэр орон сууцанд, 38 буюу 9.7 хувь нь олон нийтийн газарт, 14 буюу 3.6 хувь нь аж ахуй нэгжид, 1 буюу 0.3 хувь нь нийтийн тээвэрт, 35 буюу 8.9 хувь нь бусад газарт үйлдэгджээ.



Гудамж талбай
13.0%

Гэр, орон сууц
64.5%

Олон нийтийн
газар 9.7%

Аж ахуйн нэгж
3.6%

Нийтийн тээвэрт
0.3%

Бусад газар 8.9%

1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 88 буюу 22.4 хувь нь бүлэглэн, 61 буюу 15.6 хувь нь согтуугаар, 1 буюу 0.2 хувь нь галт зэвсгээр, 52 буюу 13.3 хувь нь хүүхэд оролцож, 9 буюу 2.3 хувь нь эмэгтэй хүн оролцсон байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 359 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 63 буюу 14.9 хувиар буурсан.

Холбогдогчдын 6 буюу 1.7 хувь нь эмэгтэй, 353 буюу 98.3 хувь нь эрэгтэй, 86 буюу 13.6 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 47 буюу 11.8 хувиар, эмэгтэй хүн 16 буюу 72.7 хувиар, хүүхэд 13 буюу 13.1 хувиар тус тус буурсан байна.




2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 400 иргэн хохирч, үүнээс 36 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 95 буюу 19.2 хувиар, гэмтсэн хүн 9 буюу 20.0 хувиар тус тус буурсан байна.



3.2. Учирсан хохирол.



/Сая төгрөгөөр/

■ 2022 он ■ 2023 он

Хэргийн улмаас иргэнд учирсан 1053.7 сая төгрөгийн хохирлын 348.8 сая төгрөг буюу 36.5 хувийг нөхөн төлүүлж, 3.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 8374.7 сая төгрөг буюу 88.8 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 1151.5 сая төгрөг буюу 75.0 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 63.6 сая төгрөг буюу 94.8 хувиар тус тус буурсан байна.

---oooOooo---



4.9. ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг 2023 онд 12985 бүртгэгдсэн нь өмнөх оноос 1146 буюу 9.7 хувиар, нийслэлийн хэмжээнд 11220 бүртгэгдсэн нь 1410 буюу 14.4 хувиар, бусад газар /хилийн чанадад/-т 10 бүртгэгдсэн нь 7 буюу 3.3 дахин тус тус өсч, орон нутгийн хэмжээнд 1755 бүртгэгдсэн нь 271 буюу 13.4 хувиар буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	11839	12985	9.7	33.5	36.5
Нийслэлд	9810	11220	14.4	40.4	44.9
Орон нутагт	2026	1755	-13.4	18.4	16.6
Бусад	3	10	3.3 дах	27.3	50.0

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.




1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/.





1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 2139 буюу 16.5 хувь нь даваа гарагт, 2081 буюу 16.0 хувь нь мягмар гарагт, 2035 буюу 15.7 хувь нь лхагва гарагт, 1928 буюу 14.8 хувь нь пүрэв гарагт, 2016 буюу 15.5 хувь нь баасан гарагт, 1410 буюу 10.9 хувь нь бямба гарагт, 1376 буюу 10.6 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 5345 буюу 41.2 хувь нь 06:00-14:00 цагт, 5532 буюу 42.6 хувь нь 14:00-19:00 цагт, 1269 буюу 9.8 хувь нь 19:00-22:00 цагт, 839 буюу 6.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 4246 буюу 32.7 хувь нь гэр, орон сууцанд, 1796 буюу 13.8 хувь нь гудамж талбайд, 672 буюу 5.2 хувь нь олон нийтийн газарт, 38 буюу 0.3 хувь нь нийтийн тээвэрт, 71 буюу 0.5 хувь нь төрийн байгууллагад, 50 буюу 0.4 хувь нь төрийн бүс байгууллагад, 1700 буюу 13.1 хувь нь аж ахуйн нэгжид, 3 буюу 0.02 хувь нь авто замд, 4409 буюу 34.0 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 25 буюу 0.2 хувь нь согтуугаар, 296 буюу 2.3 хувь нь хүүхэд оролцож, 3619 буюу 27.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 227 буюу 1.7 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 12491 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 1477 хэрэг буюу 13.4 хувиар, үүнээс 7589 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 1407 буюу 22.8 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 60.8 хувь байгаа нь өмнөх оноос 4.6 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 62.1 хувь байгаа нь 4.4 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 51.6 хувь байгаа нь 8.2 нэгжээр тус тус өссөн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 8392 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 1006 буюу 13.6 хувиар өссөн.

Холбогдогчдын 3186 буюу 38.0 хувь нь эмэгтэй, 5206 буюу 62.0 хувь нь эрэгтэй, 307 буюу 3.7 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 322 буюу 6.6 хувиар, эмэгтэй хүн 684 буюу 27.3 хувиар тус тус өсч, хүүхэд 99 буюу 24.4 хувиар буурсан байна.




2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 13094 иргэн, 18 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оноос хохирсон хүн 1308 буюу 11.1 хувиар өсч, хуулийн этгээд 1 буюу 5.3 хувиар буурсан.



3.2. Учирсан хохирол.



/Сая төгрөгөөр/

■ 2022 он ■ 2023 он

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 306.2 тэрбум төгрөгийн хохирлын 127.8 тэрбум төгрөг буюу 41.7 хувийг нөхөн төлүүлж, 76.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 77.0 тэрбум төгрөг буюу 33.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 11.6 тэрбум төгрөг буюу 10.0 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 1800.3 сая төгрөг буюу 95.9 хувиар буурсан байна.

---oooOooo---



4.10. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ГЭМТ ХЭРЭГ.

Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг 2023 онд 238 бүртгэгдсэн нь өмнөх оноос 9 буюу 3.9 хувиар, орон нутгийн хэмжээнд 34 бүртгэгдсэн нь 9 буюу 36.0 хувиар тус тус өсч, нийслэлийн хэмжээнд 204 бүртгэгдсэн нь өмнөх оны түвшинд байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.

	Хэргийн тоо		Өсөлт, бүүралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	229	238	3.9	0.6	0.7
Нийслэлд	204	204	0.0	0.8	0.8
Орон нутагт	25	34	36.0	0.2	0.3


1.3. Гэмт хэргийн түвшин /2009-2023 он/.



1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 37 буюу 15.5 хувь нь даваа гарагт, 41 буюу 17.2 хувь нь мягмар гарагт, 40 буюу 16.8 хувь нь лхагва гарагт, 42 буюу 17.6 хувь нь пүрэв гарагт, 38 буюу 16.0 хувь нь баасан гарагт, 18 буюу 7.6 хувь нь бямба гарагт, 22 буюу 9.2 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 40 буюу 16.8 хувь нь 06:00-14:00 цагт, 69 буюу 29.0 хувь нь 14:00-19:00 цагт, 47 буюу 19.7 хувь нь 19:00-22:00 цагт, 82 буюу 34.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 81 буюу 34.0 хувь нь гэр, орон сууцанд, 82 буюу 34.5 хувь нь гудамж талбайд, 37 буюу 15.5 хувь нь олон нийтийн газарт, 2 буюу 0.8 хувь нь нийтийн тээвэрт, 7 буюу 2.9 хувь нь аж ахуйн нэгжид, 29 буюу 12.2 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.





1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 3 буюу 1.3 хувь нь согтуугаар, 5 буюу 2.1 хувь нь хүүхэд оролцож, 35 буюу 14.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 33 буюу 13.9 хувь нь бүлэглэн, 2 буюу 0.8 цахим орчинд үйлдсэн, 200 буюу 84.0 хувь нь мансуурсан үедээ тус тус үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 213 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 38 хэрэг буюу 21.7 хувиар, үүнээс 136 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 29 буюу 27.1 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 63.8 хувь байгаа нь өмнөх оноос 2.7 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 63.3 хувь байгаа нь 1.4 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 53.3 хувь байгаа нь 30.0 нэгжээр тус тус өссөн байна.


Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 220 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 18 буюу 7.6 хувиар буурсан.

Холбогдогчдын 28 буюу 12.7 хувь нь эмэгтэй, 192 буюу 87.3 хувь нь эрэгтэй, 6 буюу 2.7 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 21 буюу 9.9 хувиар буурч, эмэгтэй хүн 3 буюу 12.0 хувиар өсч, хүүхэд өмнөх оны түвшинд байна.

2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



---oooOooo---



4.11. ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ.

Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Цагдаагийн байгууллагын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг 2023 онд 472 бүртгэгдсэн нь өмнөх оноос 87 буюу 15.6 хувиар, орон нутгийн хэмжээнд 395 бүртгэгдсэн нь 119 буюу 23.2 хувиар тус тус буурч, нийслэлийн хэмжээнд 77 бүртгэгдсэн нь 32 буюу 71.1 хувиар өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	559	472	-15.6	1.6	1.3
Нийслэлд	45	77	71.1	0.2	0.3
Орон нутагт	514	395	-23.2	4.7	3.7

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/.







1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 81 буюу 17.2 хувь нь даваа гарагт, 73 буюу 15.5 хувь нь мягмар гарагт, 91 буюу 19.3 хувь нь лхагва гарагт, 83 буюу 17.6 хувь нь пүрэв гарагт, 55 буюу 11.7 хувь нь баасан гарагт, 44 буюу 9.3 хувь нь бямба гарагт, 45 буюу 9.5 хувь нь ням гарагт, 150 буюу 31.8 хувь нь 06:00-14:00 цагт, 205 буюу 43.4 хувь нь 14:00-19:00 цагт, 53 буюу 11.2 хувь нь 19:00-22:00 цагт, 64 буюу 13.6 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 116 буюу 24.6 хувь нь ойн сав бүхий газар, 30 буюу 6.4 хувь нь хууль бусаар алт олборлож байгаа газар, 102 буюу 21.6 хувь нь хөдөө хээр, 27 буюу 5.7 хувь нь гол, усны ай сав газар, 15 буюу 3.2 хувь нь аж ахуйн нэгжид, 4 буюу 0.8 хувь нь ашиглаж байгаа уурхайд, 4 буюу 0.8 хувь нь ашигт малтмалын орд газарт, 7 буюу 1.5 хувь нь бэлчээрт, 167 буюу 35.4 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 4 буюу 0.8 хувь нь согтуугаар, 31 буюу 6.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 1 буюу 0.2 хувь нь хүүхэд оролцсон, 86 буюу 18.2 хувь нь бүлэглэн, 17 буюу 3.6 хувь нь галт зэвсгээр, 3 буюу 0.6 хувь нь гадаадын иргэн оролцож, 8 буюу 1.7 хувь нь цахим орчинд тус тус үйлдсэн байна.

1.6. Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 306 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 117 хэрэг буюу 27.7 хувиар, үүнээс 217 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 3 буюу 1.4 хувиар тус тус буурсан.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 70.9 хувь байгаа нь өмнөх оноос 18.9 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 70.7 хувь байгаа нь 18.3 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 71.6 хувь байгаа нь 22.7 нэгжээр тус тус өссөн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 557 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 109 буюу 24.3 хувиар өссөн.

Холбогдогчдын 32 буюу 5.7 хувь нь эмэгтэй, 525 буюу 94.3 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 92 буюу 21.2 хувиар, эмэгтэй хүн 17 буюу 2.1 дахин тус тус өссөн байна.




2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 382 иргэн, 14 хуулийн этгээд хохирсон нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 103 буюу 21.2 хувиар бүүрч, хуулийн этгээд 5 буюу 55.6 хувиар өссөн.



3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 6486.2 сая төгрөгийн хохирлын 4605.8 сая төгрөг буюу 71.0 хувийг нөхөн төлүүлж, 1026.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 1614.2 сая төгрөг буюу 33.1 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 208.3 сая төгрөг буюу 25.4 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 1194.0 сая төгрөг буюу 35.0 хувиар тус тус өссөн байна.

---oooOooo---



4.12. АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АШИГЛАЛТЫН ЖУРАМ ЗӨРЧИХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Цагдаагийн байгууллагын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг 2023 онд 1279 бүртгэгдсэн нь өмнөх оноос 65 буюу 5.4 хувиар, орон нутгийн хэмжээнд 698 бүртгэгдсэн нь 77 буюу 12.4 хувиар тус тус өсч, нийслэлийн хэмжээнд 581 бүртгэгдсэн нь 12 буюу 2.0 хувиар буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	1214	1279	5.4	3.4	3.6
Нийслэлд	593	581	-2.0	2.4	2.3
Орон нутагт	621	698	12.4	5.6	6.6

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/.






1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 192 буюу 15.0 хувь нь даваа гарагт, 191 буюу 14.9 хувь нь мягмар гарагт, 181 буюу 14.2 хувь нь лхагва гарагт, 193 буюу 15.1 хувь нь пүрэв гарагт, 178 буюу 13.9 хувь нь баасан гарагт, 172 буюу 13.4 хувь нь бямба гарагт, 172 буюу 13.4 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 349 буюу 27.3 хувь нь 06:00-14:00 цагт, 377 буюу 29.5 хувь нь 14:00-19:00 цагт, 221 буюу 17.3 хувь нь 19:00-22:00 цагт, 332 буюу 26.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 532 буюу 44.4 хувь нь орон нутгийн замд, 599 буюу 50.0 хувь нь хотын замд, 16 буюу 1.3 хувь нь аж ахуйн нэгжийн замд, 132 буюу 4.3 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 166 буюу 13.0 хувь нь согтуугаар, 220 буюу 17.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 14 буюу 1.1 хувь нь хүүхэд оролцож, 3 буюу 0.2 хувь нь гадаадын иргэн үйлдсэн байна.


Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 1015 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 36 буюу 3.4 хувиар буурсан.

Холбогдогчдын 186 буюу 18.3 хувь нь эмэгтэй, 829 буюу 81.7 хувь нь эрэгтэй, 14 буюу 1.4 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 14 буюу 1.7 хувиар, эмэгтэй хүн 22 буюу 10.6 хувиар, хүүхэд 1 буюу 6.7 хувиар тус тус буурсан байна.

2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.






Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 1433 иргэн хохирч, үүнээс 311 хүн нас барж, 1096 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 76 буюу 5.6 хувиар, нас барсан хүн 32 буюу 11.5 хувиар, гэмтсэн хүн 57 буюу 5.5 хувиар тус тус өссөн.



3.2. Учирсан хохирол.



Иргэдэд гэмт хэргийн улмаас учирсан 8769.7 сая төгрөгийн хохирлын 7494.4 сая төгрөг буюу 85.5 хувийг нөхөн төлүүлж, 315.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 1336.9 сая төгрөгөөр буюу 18.0 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 968.0 сая төгрөг буюу 14.8 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 388.1 сая төгрөг буюу 55.2 хувиар буурсан байна.

---oooOooo---



4.13. ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ.

Нэг. Бүртгэгдсэн хэрэг.


1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг 2023 онд нийт 9270 бүртгэгдсэний 7823 буюу 84.4 хувь нь Улаанбаатар хотод, 1444 буюу 15.6 хувь нь орон нутагт, 3 буюу 0.03 хувь нь бусад газар /хилийн чанадад үйлдэгдсэн/ бүртгэгдсэн байна.

Өмнөх оноос нийт гэмт хэрэг 707 буюу 8.3 хувиар, нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг 958 буюу 14.0 хувиар, орон нутгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг 251 буюу 14.8 хувиар тус тус өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	8563	9270	8.3	24.2	26.1
Нийслэлд	6865	7823	14.0	28.2	31.3
Орон нутагт	1695	1444	-14.8	15.4	13.7
Бусад газар	3	3	0.0	27.3	15.0

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн төрөл.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	5	3	-40.0	0.03
2	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	11	13	18.2	0.1
3	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	169	252	49.1	2.7
4	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	-	1	-	0.0
5	Эрүүл мэндийн эсрэг	-	1	-	0.0
6	Хүүхдийн эсрэг	43	45	4.7	0.5




7	Өмчлөх эрхийн эсрэг	7972	8132	2.0	87.7
8	Эдийн засгийн гэмт хэрэг	22	34	54.5	0.4
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	74	380	5.1 дах	4.1
10	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	256	388	51.6	4.2
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	5	3	-40.0	0.03
12	Нийтийн ашиг сонирхлын эсрэг	3	10	3.3 дах	0.1
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг	3	8	2.7 дах	0.1

1.4. Гэмт хэргийн түвшин /2015-2023 он/.



1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.

Хэргийг гарагаар нь авч үзвэл 1501 буюу 16.2 хувь нь даваа гарагт, 1510 буюу 16.3 хувь нь мягмар гарагт, 1443 буюу 15.6 хувь нь лхагва гарагт, 1295 буюу 14.0 хувь нь пүрэв гарагт, 1431 буюу 15.4 хувь нь баасан гарагт, 1026 буюу 11.1 хувь нь бямба гарагт, 1064 буюу 11.5 хувь нь ням гарагт үйлдэгджээ. Хэргийг цагаар нь авч үзвэл 3689 буюу 39.8 хувь нь 06-14 цагийн хооронд, 3814 буюу 41.1 хувь нь 14-19 цагийн хооронд, 1072 буюу 11.6 хувь нь 19-22 цагийн хооронд, 695 буюу 7.5 хувь нь 22-06 цагийн хооронд үйлдэгдэж байна.



Энэ төрлийн гэмт хэргийн 3571 буюу 38.5 хувь нь гэр орон сууцанд, 1235 буюу 13.3 хувь нь гудамж талбайд, 462 буюу 5.0 хувь нь аж ахуйн нэгжид, 372 буюу 4.0 хувь нь олон нийтийн газарт, 29 буюу 0.3 хувь нь төрийн байгууллагад, 36 буюу 0.4 хувь нь нийтийн тээвэрт, 30 буюу 0.3 нь төрийн бүс байгууллагад, 3 буюу 0.03 хувь нь авто замд, 3532 буюу 38.1 хувь нь бусад газарт тус тус бүртгэгдсэн байна.

1.6. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 6 буюу 0.1 хувь нь согтуугаар, 285 буюу 3.1 хувь нь хүүхэд оролцож, 2538 буюу 27.4 хувь нь эмэгтэй хүн оролцож үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.


2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 9270 цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэгт 6096 хүн холбогдон шалгагдаж, тэдний 3693 буюу 60.6 хувь нь эрэгтэй, 2403 буюу 39.4 хувь нь эмэгтэй, 292 буюу 4.8 хувь нь 14-17 насны хүүхэд байна.

Өмнөх оноос холбогдон шалгагдсан хүн 432 буюу 7.6 хувиар, эмэгтэй хүн 537 буюу 28.8 хувиар тус тус өсч, эрэгтэй хүн 105 буюу 2.8 хувиар, хүүхэд 110 буюу 27.4 хувиар тус тус буурсан.



2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


3.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 8965 хүн хохирсны 3584 буюу 40.0 хувь нь эрэгтэй, 5381 буюу 60.0 хувь нь эмэгтэй, 119 буюу 1.3 хувь нь 11-17 насны хүүхэд байна.

Өмнөх онтой харьцуулбал нийт хохирогч 527 буюу 6.2 хувиар, эрэгтэй хүн 360 буюу 11.2 хувиар, эмэгтэй хүн 167 буюу 3.2 хувиар, хүүхэд 36 буюу 43.4 хувиар тус тус өссөн байна.

3.2. Гэмт хэргийн улмаас хохирсон хүний нас, хүйс, нийгмийн байдал.





Иргэдэд учирсан 87.5 тэрбум төгрөгийн хохирлын 38.5 тэрбум төгрөг буюу 44.0 хувийг нөхөн төлүүлж, 165.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 54.9 тэрбум төгрөг буюу 2.7 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 28.1 тэрбум төгрөг буюу 3.7 дахин тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 110.2 сая төгрөг буюу 40.0 хувиар буурсан байна.

---oooOooo---



4.14. АЛДААТАЙ ГҮЙЛГЭЭ, АНДУУРАГДСАН ИЛГЭЭМЖ, ГЭЭГДЭЛ ЭД ХӨРӨНГӨ, АЛДУУЛ МАЛ ЗАВШИХ ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 796 бүртгэгдсэн нь өмнөх оноос 70 буюу 8.1 хувиар, нийслэлийн хэмжээнд 529 бүртгэгдсэн нь 106 буюу 16.7 хувиар тус тус буурч, орон нутгийн хэмжээнд 267 бүртгэгдсэн нь 36 буюу 15.6 хувиар өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	866	796	-8.1	2.5	2.2
Нийслэлд	635	529	-16.7	2.6	2.1
Орон нутагт	231	267	15.6	2.1	2.5

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/.






1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 105 буюу 13.2 хувь нь даваа гарагт, 128 буюу 16.1 хувь нь мягмар гарагт, 131 буюу 16.5 хувь нь лхагва гарагт, 118 буюу 14.8 хувь нь пүрэв гарагт, 128 буюу 16.1 хувь нь баасан гарагт, 109 буюу 13.7 хувь нь бямба гарагт, 77 буюу 9.7 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 275 буюу 34.5 хувь нь 06:00-14:00 цагт, 276 буюу 34.7 хувь нь 14:00-19:00 цагт, 94 буюу 11.8 хувь нь 19:00-22:00 цагт, 151 буюу 19.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 246 буюу 30.9 хувь нь гудамж талбайд, 140 буюу 17.6 хувь нь олон нийтийн газарт, 97 буюу 12.2 хувь нь аж ахуйн нэгжид, 77 буюу 9.7 хувь нь гэр, орон сууцанд, 23 буюу 2.9 хувь нь нийтийн тээвэрт, 212 буюу 26.7 хувь нь бусад газарт үйлдэгджээ.



1.5. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 12 буюу 1.4 хувь нь согтуугаар, 14 буюу 1.6 хувь нь хүүхэд оролцож, 116 буюу 13.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 13 буюу 1.5 хувь нь бүлэглэн, 53 буюу 6.7 хувь нь цахим орчинд тус тус үйлдсэн байна.


Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 348 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 37 буюу 11.9 хувиар өссөн.

Холбогдогчдын 110 буюу 31.6 хувь нь эмэгтэй, 238 буюу 68.4 хувь нь эрэгтэй, 24 буюу 6.9 хувь нь насанд хүрээгүй хүн байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 35 буюу 17.2 хувиар, насанд хүрээгүй хүн 9 буюу 60.0 хувиар, эмэгтэй хүн 2 буюу 1.8 хувиар тус тус өссөн байна.

2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 794 иргэн хохирсон нь өмнөх онтой харьцуулбал 67 буюу 7.8 хувиар буурсан байна.



3.2. Учирсан хохирол.



Хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан 2406.2 сая төгрөгийн хохирлын 498.2 сая төгрөг буюу 20.7 хувийг нөхөн төлүүлж, 23.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны оноос учирсан хохирол 3482.6 сая төгрөг буюу 59.1 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 232.5 сая төгрөг буюу 31.8 хувиар тус тус буурч, битүүмжилсэн хөрөнгө 14.7 сая төгрөг буюу 2.6 дахин өссөн байна.

---oooOooo---



ТАВ. ГЭМТ ХЭРГИЙН ОНЦЛОГ, НӨХЦӨЛ БАЙДАЛ.

5.1. СОГТУУГААР ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг 2023 онд 4979 бүртгэгдсэн нь өмнөх оноос 842 хэргээр буюу 14.5 хувиар, нийслэлийн хэмжээнд 2165 бүртгэгдсэн нь 510 гэмт хэргээр буюу 19.1 хувиар, орон нутгийн хэмжээнд 2814 бүртгэгдсэн нь 332 гэмт хэргээр буюу 10.6 хувиар тус тус буурсан.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	5821	4979	-14.5	16.5	14.0
Нийслэлд	2675	2165	-19.1	11.0	8.7
Орон нутагт	3146	2814	-10.6	28.6	26.6

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/







1.4. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Тухайн гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	182	147	-19.2	3.0
	Үүнээс: Хүнийг алах	168	140	-16.7	2.8
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4383	3661	-16.5	73.5
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	52	63	21.2	1.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	147	153	4.1	3.1
	Үүнээс: Хүчиндэх	135	133	-1.5	2.7
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	5	9	80.0	0.2
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	3	3.0 дах	0.1
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	-	2	-	0.0
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	774	705	-8.9	14.2
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	6	5	-16.7	0.1
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг		2		0.0
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	103	122	18.4	2.5
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	1	4	4.0 дах	0.1
12	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2			0.0
13	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	217	166	-23.5	3.3
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	217	166	-23.5	3.3

1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 692 буюу 13.9 хувь нь даваа гарагт, 745 буюу 15.0 хувь нь мягмар гарагт, 657 буюу 13.2 хувь нь лхагва гарагт, 699 буюу 14.0 хувь нь пүрэв гарагт, 709 буюу 14.2 хувь нь баасан гарагт, 737 буюу 14.8 хувь нь бямба гарагт, 740 буюу 14.9 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 852 буюу 16.2 хувь нь 06:00-14:00 цагт, 959 буюу 19.8 хувь нь 14:00-19:00 цагт, 899 буюу 17.9 хувь нь 19:00-22:00 цагт, 2269 буюу 46.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 2244 буюу 45.1 хувь нь гэр орон сууцанд, 1107 буюу 22.2 хувь нь гудамж талбайд, 696 буюу 14.0 хувь нь олон нийтийн газарт, 9 буюу 0.2 хувь нь нийтийн тээвэрт, 39 буюу 0.8 хувь нь төрийн байгууллагад, 7 буюу 0.1 хувь нь төрийн бус байгууллагад, 215 буюу 4.3 хувь нь аж ахуйн нэгжид, 150 буюу 3.0 хувь нь авто замд, 512 буюу 10.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ.






Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 5547 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 880 буюу 13.7 хувиар буурсан.

Холбогдогчдын 403 буюу 7.3 хувь нь эмэгтэй, 5144 буюу 92.7 хувь нь эрэгтэй, 60 буюу 1.1 хувь нь 14-17 насны хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оноос эмэгтэй хүн 113 буюу 21.9 хувиар, хүүхэд 25 буюу 29.4 хувиар, эрэгтэй хүн 767 буюу 13.0 хувиар тус тус буурсан.


2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Согтуугаар үйлдсэн гэмт хэргийн улмаас 6833 хүн, 4 хуулийн этгээд хохирч, үүнээс 285 хүн нас барж, 4876 хүн гэмтсэн нь өмнөх оноос нийт хохирогч 692 буюу 9.2 хувиар, нас барсан хүн 12 буюу 4.0 хувиар, гэмтсэн хүн 631 буюу 11.5 хувиар тус тус буурсан байна.



3.2. Учирсан хохирол.



Гэмт хэргийн улмаас иргэдэд учирсан 12794.5 сая төгрөгийн хохирлын 10067.3 сая төгрөг буюу 78.7 хувийг нөхөн төлүүлж, 576.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 3457.2 сая төгрөг буюу 21.3 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 3078.6 сая төгрөг буюу 23.4 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 240.6 сая төгрөг буюу 29.4 хувиар тус тус буурсан байна.

---oooOooo---



5.2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг 2023 онд нийт 1415 бүртгэгдсэн нь өмнөх оноос 314 буюу 18.2 хувиар, нийслэлийн хэмжээнд 738 бүртгэгдсэн 144 буюу 16.3 хувиар, орон нутгийн хэмжээнд 677 бүртгэгдсэн нь 170 буюу 20.1 хувиар тус тус буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	1729	1415	-18.2	4.9	4.0
Нийслэлд	882	738	-16.3	3.6	3.0
Орон нутагт	847	677	-20.1	7.7	6.4

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2009-2023 он/.







1.4. Гэмт хэргийн төрөл.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	ГБХ-ийн хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг	32	25	-21.9	1.8
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	1551	1255	-19.1	88.7
3	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	98	126	28.6	8.9
4	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	119	110	-7.6	7.8
5	Үүнээс: Хүчиндэх	110	103	-6.4	7.3
6	Үүнээс: Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	5	4	-20.0	0.3
7	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	2	5	2.5 дах	0.4
8	Хүүхдийн эсрэг	7	8	14.3	0.6
9	Бусад	18	12	-33.3	0.7


1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 195 буюу 13.8 хувь нь даваа гарагт, 243 буюу 17.2 хувь нь мягмар гарагт, 198 буюу 14.0 хувь нь лхагва гарагт, 193 буюу 13.6 хувь нь пүрэв гарагт, 211 буюу 14.9 хувь нь баасан гарагт, 175 буюу 12.4 хувь нь бямба гарагт, 200 буюу 14.1 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 310 буюу 21.9 хувь нь 06:00-14:00 цагт, 297 буюу 21.0 хувь нь 14:00-19:00 цагт, 283 буюу 20.0 хувь нь 19:00-22:00 цагт, 525 буюу 37.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.


Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 1203 буюу 85.0 хувь нь гэр, орон сууцанд, 77 буюу 5.4 хувь нь гудамж талбайд, 30 буюу 2.2 хувь нь олон нийтийн газарт, 3 буюу 0.1 хувь нь төрийн байгууллагад, 2 буюу 0.1 хувь нь төрийн бус байгууллагад, 14 буюу 1.0 хувь нь аж ахуйн нэгжид, 86 буюу 6.1 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.




Гэр, орон сууц
85.0%



Гудамж, талбай
5.4%




Олон нийтийн
газар 2.2%



Аж ахуйн нэгж
1.0%



Төрийн
байгууллагад 0.1%



Бусад газар 6.3%

1.6. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 757 буюу 53.5 хувь нь согтуугаар, 7 буюу 0.5 хувь нь хүүхэд оролцож, 97 буюу 6.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 9 буюу 0.6 хувь бүлэглэн үйлдсэн байна.




Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 1334 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 215 буюу 13.9 хувиар буурсан.

Холбогдогчдын 1237 буюу 92.7 хувь нь эрэгтэй, 97 буюу 7.3 хувь нь эмэгтэй, 7 буюу 0.5 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 189 буюу 13.3 хувиар, эмэгтэй хүн 26 буюу 21.1 хувиар, хүүхэд 1 буюу 12.5 хувиар тус тус буурсан байна.

2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 1459 иргэн хохирч, үүнээс 1282 буюу 87.9 хувь нь эмэгтэй, 170 буюу 11.7 хувь нь хүүхэд хохирч, 1238 хүн гэмтэж, 21 хүн нас барсан нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 205 буюу 12.3 хувиар, гэмтсэн хүн 194 буюу 13.5 хувиар, нас барсан хүн 7 буюу 25.0 хувиар тус тус буурсан байна.

Энэ гэмт хэргийн улмаас 1717.0 сая төгрөгний хохирол учирсан байна.



3.1. Хохирогчдын хамаарал.





Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 684, хамтран амьдрагч 323, нөхөр 81, өвөг эцэг, эмэг эх 1, төрсөн хүүхэд 73, үрчилж авсан хүүхэд 1, дагавар хүүхэд 50, төрсөн эцэг, эх 48, төрсөн ах, эгч 15, төрсөн дүү 5, хадам эцэг, эх 10, бусад 168 хүн байна.

Дөрөв. Зөрчлийн шийдвэрлэлт.

Цагдаагийн байгууллагад 2023 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 10319 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 225 буюу 2.2 хувиар өсч, 8366 зөрчлийг шийдвэрлэсэн нь 227 буюу 2.6 хувиар бүүрсан байна.

Зөрчил гаргасан 410 иргэнийг 55.8 сая төгрөгөөр торгож, 7956 хүнийг баривчлуулах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 12 буюу 3.0 хувиар өсч, баривчилуулсан шийтгэл 239 буюу 2.9 хувиар тус тус өссөн байна.

5.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн заалт	Зөрчлийн тоо		Өсөлт, бууралт		Нийт ГБХ-ийн зөрчилд эзлэх хувь
	2022 он	2023 он	Тоо	Хувь	
5.4.1.	46	88	42	91.3	0.9
5.4.4.	10048	10231	183	1.8	99.1
5.4.4.1	7940	8063	123	1.5	78.1
5.4.4.2	1681	1745	64	3.8	16.9
5.4.4.3	41	42	1	2.4	0.4
5.4.4.4	386	381	-5	-1.3	3.7

---oooOooo---



5.3. ГЭР, ОРОН СУУЦАНД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Гэр орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 11127 бүртгэгдсэн нь өмнөх оноос 1322 буюу 10.6 хувиар, нийслэлийн хэмжээнд 7638 бүртгэгдсэн нь 763 буюу 9.1 хувиар, орон нутгийн хэмжээнд 3487 бүртгэгдсэн нь 560 буюу 13.8 хувиар тус тус буурч, бусад газарт 2 бүртгэгдсэн нь 1 буюу 2.0 дахин өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	12449	11127	-10.6	35.2	31.3
Нийслэлд	8401	7638	-9.1	34.6	30.6
Орон нутагт	4047	3487	-13.8	36.7	33.0
Бусад	1	2	2.0 дах	9.1	10.0

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/.






1.4. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Тухайн гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	270	283	4.8	2.5
	Үүнээс: Хүнийг алах	124	116	-6.5	1.0
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	3872	3290	-15.0	29.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	86	120	39.5	1.1
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	450	496	10.2	4.5
	Үүнээс: Хүчиндэх	364	385	5.8	3.5
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	75	116	54.7	1.0
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.0
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	29	27	-6.9	0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	7438	6453	-13.2	58.0
7	Хулгайлах	2402	1882	-21.6	16.9
	Залилах	4650	4246	-8.7	38.2
	Дээрэмдэх	65	51	-21.5	0.5
	Мал хулгайлах	8	2	-75.0	0.0
8	Эдийн засгийн гэмт хэрэг	6	10	66.7	0.1
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	152	243	59.9	2.2
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	12	11	-8.3	0.1
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	30	27	-10.0	0.2
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	10	8	-20.0	0.1
14	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	102	159	55.9	1.4
15	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	2	2	0.0	0.0

1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 1756 буюу 15.8 хувь нь даваа гарагт, 1766 буюу 15.9 хувь нь мягмар гарагт, 1600 буюу 14.4 хувь нь лхагва гарагт, 1571 буюу 14.1 хувь нь пүрэв гарагт, 1563 буюу 14.0 хувь нь баасан гарагт, 1381 буюу 12.4 хувь нь бямба гарагт, 1490 буюу 13.4 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 3515 буюу 31.6 хувь нь 06:00-14:00 цагт, 3375 буюу 30.3 хувь нь 14:00-19:00 цагт, 1755 буюу 15.8 хувь нь 19:00-22:00 цагт, 2482 буюу 22.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 3656 буюу 32.9 гэр, 3960 буюу 35.6 орон сууц, 2057 буюу 18.5 хувийн байшин, 361 буюу 3.2 нийтийн байр, 392 буюу 3.5 бусад, 240 буюу 2.2 хувь нь зуслангийн байшин, 178 буюу 1.6 хувь нь орц, 125 буюу 1.1 хувь нь гарааж, 49 буюу 0.4 хувь нь амбаар, 47 буюу 0.4 хувь нь подваль, 33 буюу 0.3 хувь нь агуулах, 29 буюу 0.3 хувь нь хаусд тус тус үйлдэгдсэн байна.





1.6. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 2245 буюу 20.2 хувь нь согтуугаар, 335 буюу 3.0 хувь нь хүүхэд оролцож, 2027 буюу 18.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 1203 буюу 10.8 хувь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 295 буюу 2.7 хувь нь бүлэглэн үйлдсэн, 4 буюу 0.04 хувь нь галт зэвсгээр үйлдсэн байна.


Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 7638 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 813 буюу 9.6 хувиар буурсан.

Холбогдогчдын 1830 буюу 24.0 хувь нь эмэгтэй, 5808 буюу 76.0 хувь нь эрэгтэй, 422 буюу 5.5 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 1064 буюу 15.5 хувиар, хүүхэд 64 буюу 13.2 хувиар тус тус буурч, эмэгтэй хүн 251 буюу 15.9 хувиар өссөн байна.


2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 11100 иргэн, 5 хуулийн этгээд хохирч үүнээс 257 хүн нас барж, 3302 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 1353 буюу 10.9 хувиар, гэмтсэн хүн 560 буюу 14.5 хувиар тус тус буурч, нас барсан хүн 20 буюу 8.4 хувиар өссөн байна.





3.2. Учирсан хохирол.



Хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан 61.6 тэрбум төгрөгийн хохирлын 25.6 тэрбум төгрөг буюу 41.7 хувийг нөхөн төлүүлж, 529.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 31.0 тэрбум төгрөг буюу 33.5 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 34.0 тэрбум төгрөг буюу 57.0 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 133.3 сая төгрөг буюу 20.1 хувиар тус тус буурсан байна.

---oooOooo---



5.4. ОЛОН НИЙТИЙН ГАЗАРТ ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ.

Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэг 2023 онд 3333 бүртгэгдсэн нь өмнөх оноос 301 буюу 8.3 хувиар, нийслэлийн хэмжээнд 2577 бүртгэгдсэн нь 336 буюу 11.5 хувиар тус тус буурч, орон нутгийн хэмжээнд 754 бүртгэгдсэн нь 35 буюу 4.9 хувиар өсч, бусад газарт бүртгэгдсэн нь өмнөх оны түвшинд байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	3634	3333	-8.3	10.3	9.4
Нийслэлд	2913	2577	-11.5	12.0	10.3
Орон нутагт	719	754	4.9	6.5	7.1
Бусад	2	2	0.0	18.2	10.0

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2010-2022 он/.






1.4. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Тухайн гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	23	24	4.3	0.7
	Үүнээс: Хүнийг алах	7	10	42.9	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1197	1169	-2.3	35.1
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	1	-50.0	0.03
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	52	54	3.8	1.6
	Үүнээс: Хүчиндэх	40	40	0.0	1.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	20	26	30.0	0.8
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	-	4	-	0.1
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2270	1928	-15.1	57.8
6	Үүнээс: Хулгайлах	986	933	-5.4	28.0
	Залилах	878	672	-23.5	20.2
	Дээрэмдэх	45	38	-15.6	1.1
	Мал хулгайлах	1	-	-	-
7	Эдийн засгийн гэмт хэрэг	10	10	0.0	0.3
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	30	59	96.7	1.8
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	3	4	33.3	0.1
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	17	25	47.1	0.8
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	5	21	4.2 дах	0.6
12	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг		2		0.1
13	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4	7	75.0	0.2
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	2	-	-	-
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1	-	-	-

1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.


Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 464 буюу 13.9 хувь нь даваа гарагт, 432 буюу 13.0 хувь нь мягмар гарагт, 488 буюу 14.6 хувь нь лхагва гарагт, 456 буюу 13.7 хувь нь пүрэв гарагт, 512 буюу 15.4 хувь нь баасан гарагт, 540 буюу 16.2 хувь нь бямба гарагт, 441 буюу 13.2 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 872 буюу 26.2 хувь нь 06:00-14:00 цагт, 907 буюу 27.2 хувь нь 14:00-19:00 цагт, 345 буюу 10.4 хувь нь 19:00-22:00 цагт, 1209 буюу 36.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 489 буюу 14.7 хувь нь дэлгүүр, 444 буюу 13.3 хувь нь зочид буудалд, 732 буюу 22.0 хувь нь баар, 156 буюу 4.7 хувь нь нийтийн зах, 259 буюу 7.8 хувь нь бөөний худалдааны төв, 154 буюу 4.6 хувь нь зоогийн газар, 87 буюу 2.6 хувь нь амралтын газар, 73 буюу 2.2 хувь нь цайны газар, 22 буюу 0.7 хувь нь түц, 18 буюу 0.5 хувь нь барьцаалан зээлдүүлэх газар, 27 буюу 0.8 хувь нь авто вокзал, 37 буюу 1.1 хувь нь үзвэрийн газар, 8 буюу 0.2 хувь нь саун, 8 буюу 0.2 хувь нь жуулчны бааз, 6 буюу 0.2 хувь нь сувиллын газар, 7 буюу 0.2 хувь нь төмөр замын вокзал, 27 буюу 0.8 хувь нь РС тоглоомын газар, 10 буюу 0.3 хувь нь нисэх онгоцны буудал,



6 буюу 0.2 хувь нь автомат тоглоомын газар, 1 буюу 0.03 хувь нь илгээмжийн үйлчилгээний газар, 762 буюу 22.9 хувь нь бусад газарт тус тус бүртгэгдсэн байна.



1.6. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 696 буюу 20.9 хувь нь согтуугаар, 132 буюу 4.0 хувь нь хүүхэд оролцож, 587 буюу 17.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 30 буюу 0.9 хувь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 173 буюу 5.2 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.


Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 2267 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 125 буюу 5.2 хувиар буурсан.

Холбогдогчдын 459 буюу 20.2 хувь нь эмэгтэй, 1808 буюу 79.8 хувь нь эрэгтэй, 183 буюу 8.1 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 114 буюу 5.9, эмэгтэй хүн 11 буюу 2.3 хувиар, хүүхэд 2 буюу 1.1 хувиар тус тус буурсан байна.

2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 3341 иргэн, 5 хуулийн этгээд хохирч үүнээс 23 нас барж, 1184 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 315 буюу 8.6 хувиар, гэмтсэн хүн 23 буюу 1.9 хувиар тус тус буурч, нас барсан хүн өмнөх оны түвшинд байна.





3.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 19.2 тэрбум төгрөгийн хохирлын 5.1 тэрбум төгрөг буюу 26.8 хувийг нөхөн төлүүлж, 150.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн өмнөх оноос учирсан хохирол 214.9 сая төгрөг буюу 1.1 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 4162.3 сая төгрөг буюу 44.7 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 36.5 сая төгрөг буюу 19.6 хувиар тус тус буурсан байна.

---oooOooo---



5.5. ГУДАМЖ ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 2023 онд 6552 бүртгэгдсэн нь өмнөх оноос 397 буюу 5.7 хувиар, нийслэлийн хэмжээнд 5231 бүртгэгдсэн нь 487 буюу 8.5 хувиар тус тус буурч, орон нутгийн хэмжээнд 1320 бүртгэгдсэн нь 90 буюу 7.3 хувиар өссөн байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	6949	6552	-5.7	19.7	18.4
Нийслэлд	5718	5231	-8.5	23.5	20.9
Орон нутагт	1230	1320	7.3	11.2	12.5
Бусад	1	1		9.1	5.0

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/






1.4. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Тухайн гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	79	70	-11.4	1.1
	Үүнээс: Хүнийг алах	34	31	-8.8	0.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2509	2324	-7.4	35.5
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	3	3	0.0	0.05
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	67	57	-14.9	0.9
	Үүнээс: Хүчиндэх	59	45	-23.7	0.7
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	16	24	50.0	0.4
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	6	1	-83.3	0.02
6	Эрүүл мэндийн эсрэг	-	1	-	0.02
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	4051	3837	-5.3	58.6
	Хулгайлах	1273	1119	-12.1	17.1
	Залилах	1773	1796	1.3	27.4
	Дээрэмдэх	323	253	-21.7	3.9
	Мал хулгайлах	13	11	-15.4	0.2
8	Эдийн засгийн гэмт хэрэг	4	6	50.0	0.09
9	Үндэсний аюулгүй байдлын эсрэг		1		0.02
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	94	113	20.2	1.7
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	4	1	-75.0	0.02
12	Авлигын эсрэг гэмт хэрэг	2	-	-	-
13	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	72	68	-5.6	0.0
14	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	16	11	-31.3	1.0
15	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7	9	28.6	0.2
16	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	22	29	31.8	0.1
17	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	22	29	31.8	0.4

1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 911 буюу 13.9 хувь нь даваа гарагт, 958 буюу 14.6 хувь нь мягмар гарагт, 1016 буюу 15.5 хувь нь лхагва гарагт, 898 буюу 13.7 хувь нь пүрэв гарагт, 1023 буюу 15.6 хувь нь баасан гарагт, 891 буюу 13.6 хувь нь бямба гарагт, 855 буюу 13.0 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 1924 буюу 29.4 хувь нь 06:00-14:00 цагт, 1896 буюу 28.9 хувь нь 14:00-19:00 цагт, 878 буюу 13.4 хувь нь 19:00-22:00 цагт, 1854 буюу 28.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 1621 буюу 24.7 гэр хорооллын гудамж, 1794 буюу 27.4 орон сууцны хорооллын гудамж, 120 буюу 1.8 тоглоомын талбайд, 1085 буюу 16.6 ил зогсоолд, 36 буюу 0.5 цэцэрлэгт хүрээлэнд, 497 буюу 7.6 автобусны буудалд, 8 буюу 0.1 төмөр замд, 1391 буюу 21.2 бусад газарт тус тус бүртгэгдсэн байна.





1.6. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 1107 буюу 16.9 хувь нь согтуугаар, 490 буюу 7.5 хувь нь хүүхэд оролцож, 781 буюу 11.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 77 буюу 1.2 хувь гэр бүлийн хүчирхийллийн үлмаас, 436 буюу 6.7 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 4915 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 243 буюу 5.2 хувиар өссөн.

Холбогдогчдын 671 буюу 13.7 хувь нь эмэгтэй, 4244 буюу 86.3 хувь нь эрэгтэй, 593 буюу 12.1 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 281 буюу 7.1 хувиар, хүүхэд 137 буюу 30.0 хувиар тус тус өсч, эмэгтэй хүн 38 буюу 5.4 хувиар буурсан байна.

2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн үлмаас 6623 иргэн, 2 хуулийн этгээд хохирч үүнээс 65 нас барж, 2386 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 385 буюу 5.5 хувиар, нас барсан хүн 15 буюу 18.8 хувиар, гэмтсэн хүн 108 буюу 4.3 хувиар тус тус буурсан байна.



3.2. Учирсан хохирол.



Хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан 33.3 тэрбум төгрөгийн хохирлын 21.7 тэрбум төгрөг буюу 65.2 хувийг нөхөн төлүүлж, 286.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос учирсан хохирол 4.1 тэрбум төгрөг буюу 14.3 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 7.1 тэрбум төгрөг буюу 49.2 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 101.8 сая төгрөг буюу 26.2 хувиар буурсан байна.

---oooOooo---



ЗУРГАА. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮНИЙ ОНЦЛОГ.

6.1. ЭМЭГТЭЙ ХҮН ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2023 онд эмэгтэй хүнээс үйлдсэн 5990 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 741 буюу 14.1 хувиар, нийслэлийн хэмжээнд 4817 бүртгэгдсэн нь 769 буюу 19.0 хувиар тус тус өсч, орон нутгийн хэмжээнд 1173 бүртгэгдсэн нь 26 буюу 2.2 хувиар буурсан.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	5249	5990	14.1	14.9	16.8
Нийслэлд	4048	4817	19.0	16.7	19.3
Орон нутагт	1199	1173	-2.2	10.9	11.1
Бусад	2	-	-	18.2	0.0

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/.






1.4. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь		
		2022 он	2023 он				
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	44	55	25.0	0.9		
2	Үүнээс: Хүнийг алах	19	29	52.6	0.5		
3	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	999	832	-16.7	13.9		
4	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	30	13	-56.7	0.2		
5	Үүнээс: Хүчиндэх	6	1	-83.3	0.0		
6	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	80	84	5.0	1.4		
7	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	1	1	0.0	0.0		
8	Эрүүл мэндийн эсрэг	13	16	23.1	0.3		
9	Хүүхдийн эсрэг	8	11	37.5	0.2		
10	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	3668	4444	21.2	74.2		
11	Үүнээс Хулгайлах	339	424	25.1	7.1		
		Залилах	2901	3619	24.8	60.4	
			Дээрэмдэх	23	9	-60.9	0.2
			Мал хайлгайлах	14	26	85.7	0.4
12	Эдийн засгийн гэмт хэрэг	29	35	20.7	0.6		
13	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	33	68	2.1 дах	1.1		
14	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	20	28	40.0	0.5		
15	Авлигын эсрэг		4		0.1		
16	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	76	138	81.6	2.3		
17	Хүрээлэн байгаа орчны эсрэг	17	31	82.4	0.5		
18	Кибер аюулгүй байдлын эсрэг	10	10	0.0	0.2		
19	Соёлын өвийн эсрэг	1			0.0		
20	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	220	220	0.0	3.7		
21	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	220	220	0.0	3.7		

1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 971 буюу 16.2 хувь нь даваа гарагт, 944 буюу 15.8 хувь нь мягмар гарагт, 830 буюу 13.9 хувь нь лхагва гарагт, 899 буюу 15.0 хувь нь пүрэв гарагт, 861 буюу 14.4 хувь нь баасан гарагт, 715 буюу 11.9 хувь нь бямба гарагт, 770 буюу 12.9 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 2138 буюу 35.7 хувь нь 06:00-14:00 цагт, 2384 буюу 39.8 хувь нь 14:00-19:00 цагт, 697 буюу 11.6 хувь нь 19:00-22:00 цагт, 771 буюу 12.9 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 2027 буюу 33.8 хувь нь гэр орон сууцанд, 781 буюу 13.0 хувь нь гудамж талбайд, 587 буюу 9.8 хувь нь олон нийтийн газарт, 34 буюу 0.6 хувь нь нийтийн тээвэрт, 73 буюу 1.2 хувь нь төрийн байгууллагад, 78 буюу 1.3 хувь нь төрийн бус байгууллагад, 634 буюу 10.6 хувь нь аж ахуйн нэгжид, 208 буюу 3.5 хувь нь авто замд, 1568 буюу 26.2 хувь нь бусад газарт бүртгэгджээ.






Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 5021 эмэгтэй хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 551 буюу 12.3 хувиар өссөн байна. Үүнээс 291 буюу 5.8 хувь нь 14-17 насны хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оноос 85 буюу 22.6 хувиар буурчээ.

2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 16015 эмэгтэй хүн хохирч, үүнээс 230 хүн нас барж, 3403 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал нас барсан хүн 20 буюу 9.5 хувиар, хүүхэд 114 буюу 12.1 хувиар тус тус өсч, гэмтсэн хүн 301 буюу 8.1 хувиар, хохирсон хүн 84 буюу 0.5 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 148.0 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оноос 33.7 тэрбум төгрөг буюу 29.5 хувиар өссөн байна.



---оооОооо---



6.2. НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮМҮҮСЭЭС ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ.


Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2023 онд насанд хүрээгүй хүнээс үйлдсэн 1270 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 12 хэргээр буюу 1.0 хувиар, орон нутгийн хэмжээнд 479 бүртгэгдсэн нь 79 хэргээр буюу 19.8 хувиар тус тус өсч, нийслэлийн хэмжээнд 791 бүртгэгдсэн нь 67 хэргээр буюу 7.8 хувиар буурсан байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	1258	1270	1.0	3.6	3.6
Нийслэлд	858	791	-7.8	3.5	3.2
Орон нутагт	400	479	19.8	3.6	4.5

1.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



1.3. Гэмт хэргийн түвшин /2004-2023 он/.







1.4. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	10	-	-	-
	Үүнээс: Хүнийг алах	9	-	-	-
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	327	383	17.1	30.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	40	49	22.5	3.9
	Үүнээс: Хүчиндэх	30	38	26.7	3.0
4	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	24	10	-58.3	0.8
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	2	-	-	-
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	817	798	-2.3	62.8
7	Хулгайлах	273	381	39.6	30.0
	Залилах	398	295	-25.9	23.2
	Дээрэмдэх	56	52	-7.1	4.1
	Мал хулгайлах	16	7	-56.3	0.6
8	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	-	-	-
9	Эдийн засгийн гэмт хэрэг	-	2	-	0.2
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.1
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	10	10	0.0	0.6
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.1
13	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	10	2	-80.0	0.2
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	15	14	-6.7	1.1
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	15	14	-6.7	1.1

1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 205 буюу 16.1 хувь нь даваа гарагт, 208 буюу 16.4 хувь нь мягмар гарагт, 210 буюу 16.5 хувь нь лхагва гарагт, 169 буюу 13.3 хувь нь пүрэв гарагт, 170 буюу 13.4 хувь нь баасан гарагт, 140 буюу 11.0 хувь нь бямба гарагт, 168 буюу 13.2 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 354 буюу 27.9 хувь нь 06:00-14:00 цагт, 378 буюу 29.8 хувь нь 14:00-19:00 цагт, 198 буюу 15.6 хувь нь 19:00-22:00 цагт, 340 буюу 26.7 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 335 буюу 26.4 хувь нь гэр, орон сууцанд, 490 буюу 38.6 хувь нь гудамж талбайд, 132 буюу 10.4 хувь нь олон нийтийн газарт, 2 буюу 0.2 хувь нь нийтийн тээвэрт, 15 буюу 1.2 хувь нь төрийн байгууллагад, 13 буюу 1.0 хувь нь төрийн бус байгууллагад, 106 буюу 8.3 хувь нь аж ахуйн нэгжид, 15 буюу 1.2 хувь нь авто зам дээр, 162 буюу 12.8 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.





Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 1594 хүүхэд холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 54 буюу 3.5 хувиар өссөн байна.

Холбогдогчдын 291 буюу 18.3 хувь нь эмэгтэй, 1303 буюу 81.7 хувь нь эрэгтэй хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оноос эмэгтэй хүүхэд 85 буюу 22.6 хувиар буурч, эрэгтэй хүүхэд 139 буюу 11.9 хувиар өссөн байна.

2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, боловсролын түвшин.





Гурав. Гэмт хэргийн улмаас хохирсон насанд хүрээгүй хүүхэд.

3.1. Хохирсон хүүхэд.

Гэмт хэргийн улмаас 2215 хүүхэд хохирч, үүнээс 99 нас барж, 886 гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүүхэд 201 буюу 10.0 хувь, нас барсан хүүхэд 7 буюу 7.6 хувь, гэмтсэн хүүхэд хүн 34 буюу 4.0 хувиар тус тус өссөн байна.

3.2. Учирсан хохирол.



Гэмт хэргийн улмаас насанд хүрээгүй хүнд 4.6 тэрбум төгрөгийн хохирол учирчээ.

---oooOooo---



6.3. ГАДААДЫН ИРГЭНЭЭС ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ.

Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2023 онд гадаадын иргэнээс үйлдсэн 37 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 5 хэргээр буюу 11.9 хувиар, орон нутгийн хэмжээнд 14 бүртгэгдсэн нь 5 буюу 26.3 хувиар тус тус буурч, нийслэлийн хэмжээнд 23 бүртгэгдсэн нь 1 буюу 4.5 хувиар өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2022 он	2023 он		2022 он	2023 он
Улсын хэмжээнд	42	37	-11.9	0.1	0.1
Нийслэлд	22	23	4.5	0.1	0.1
Орон нутагт	19	14	-26.3	0.2	0.1
Бусад	1	-	-	9.1	0.0

1.3. Гэмт хэргийн түвшин /2014-2023 он/.



1.4. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2022 он	2023 он		
1	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	16	14	-12.5	37.8
2	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	-	4	-	10.8
3	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	8	11	37.5	29.7
4	Хулгайлах	-	5	-	13.5
	Залилах	6	6	0.0	16.2
5	Эдийн засгийн гэмт хэрэг	1	5	5.0 дах	13.5
6	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	-	-	0.0
7	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	2.7
8	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	8	2	-75.0	5.4
9	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	8	2	-75.0	5.4
10	Бусад	6	-	-	-



1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн хугацаа, гарагаар нь авч үзвэл 4 буюу 10.8 хувь нь даваа гарагт, 8 буюу 21.6 хувь нь мягмар гарагт, 9 буюу 24.3 хувь нь лхагва гарагт, 3 буюу 8.1 хувь нь пүрэв гарагт, 3 буюу 8.1 хувь нь баасан гарагт, 6 буюу 16.2 хувь нь бямба гарагт, 4 буюу 10.8 хувь нь ням гарагт, цагаар нь авч үзвэл 10 буюу 27.0 хувь нь 06:00-14:00 цагт, 14 буюу 37.8 хувь нь 14:00-19:00 цагт, 3 буюу 8.1 хувь нь 19:00-22:00 цагт, 10 буюу 27.0 хувь нь 22:00-06:00 цагт тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байршил, газрыг авч үзвэл 8 буюу 21.6 хувь нь гэр орон сууцанд, 3 буюу 8.1 хувь нь гудамж талбайд, 8 буюу 21.6 хувь нь олон нийтийн газарт, 2 буюу 5.4 хувь нь авто замд, 10 буюу 27.0 хувь нь аж ахуйн нэгжид, 6 буюу 16.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ.




Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид.

2.1. Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэн.

Нийт 41 гадаадын иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 12 буюу 22.6 хувиар буурсан байна.

2.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



2.3. Гадаадын иргэдийн харьяалал, Эрүүгийн хуулийн хууль анги.

- 11.6 дугаар зүйл (Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах)-д заасан гэмт хэрэгт БНХАУ-ын 7, ОХУ-ын 2, АНУ-ын 1, Вьетнам Улсын 2, Казкастан Улсын 1, Узбекистан Улсын 1;
- 13.1 дүгээр зүйл (Хүн хулгайлах)-д заасан гэмт хэрэгт БНХАУ-ын 1;
- 13.10 дугаар зүйл (Хувь хүний нууцад халдах)-д заасан гэмт хэрэгт Сингапур Улсын 3;
- 17.1 дүгээр зүйл (Хулгайлах)-д заасан гэмт хэрэгт БНХАУ-ын 2, ОХУ-ын 3;
- 17.3 дугаар зүйл (Залилах)-д заасан гэмт хэрэгт БНХАУ-ын 2, Азарбежан Улсын 2, Казахстан Улсын 1, Киргизстан Улсын 1, Болгар Улсын 1;
- 18.3 дугаар зүйл (Татвар төлөхөөс зайлсхийх)-д заасан гэмт хэрэгт БНХАУ-ын иргэн 1;
- 18.5 дугаар зүйл (Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх)-д заасан гэмт хэрэгт БНХАУ-ын иргэн 2;
- 18.7 дугаар зүйл (Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах)-д заасан гэмт хэрэгт Казкастан Улсын 2, Киргистан Улсын 1;
- 18.14 дүгээр зүйл (Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх)-д заасан гэмт хэрэгт БНХАУ-ын 2;
- 24.5 дугаар зүйл (Хууль бусаар ан агнах)-д заасан гэмт хэрэгт БНХАУ-ын иргэн 1;




-27.10 дугаар зүйл (Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих) БНХАУ-ын 1, ОХУ-ын 1, нийт 41 гадаадын иргэн холбогдон шалгагдсан.

Гэмт хэрэг үйлдсэн нутаг дэвсгэрээр авч үзвэл нийслэлийн Баянгол дүүрэгт 7, Хан-Уул дүүрэгт 3, Сонгинохайрхан дүүрэгт 2, Чингэлтэй дүүрэгт 7, Баянзүрх дүүрэгт 3, Багахангай дүүрэгт 1, Сүхбаатар дүүрэгт 4, орон нутагт Дорноговь аймагт 4, Сэлэнгэ аймагт 1, Дархан-Уул аймагт 1, Баян-Өлгий аймагт 4, Төв аймагт 2, Хэнтий аймагт 1, Өмнөговь аймагт 1 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.


Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

3.1. Хохирсон гадаадын иргэн.

Гэмт хэргийн улмаас 187 гадаадын иргэн хохирч, үүнээс 24 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 73 буюу 64.0 хувиар өссөн, гэмтсэн иргэн өмнөх онтой ижил байна.



3.2. Учирсан хохирол.



Гадаадын иргэдэд 33442.3 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оноос 5547.9 сая төгрөг буюу 19.9 хувиар өссөн байна.

Дөрөв. Зөрчилд холбогдон шалгагдсан болон өртсөн гадаадын иргэд.

Зөрчлийн улмаас гадаадын 74 иргэн хохирсны дотор БНХАУ-ын 39, ОХУ-ын 8, БНСУ-ын 10, Япон Улсын 3, Канад Улс, Беларусь Улс, Чех Улсын тус тус 2, АНУ, Казахстан, Тонга, БНАСАУ, Тувал, Австрали, Албани, Вьетнам Улсын иргэн тус тус 1 иргэн байна.

Зөрчилд гадаад улсын 998 иргэн холбогдон шалгагдсан бөгөөд 896 /89.8%/ иргэнийг торгож, 81/8.1%/ иргэнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 21/2.1%/ иргэнийг баривчлуулах шийтгэл тус тус оногдуулжээ.

Торгох шийтгэл оногдуулсан 694 иргэнийг ердийн зөрчилд, 202 иргэдэд зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж торгуулийн арга хэмжээ авсан байна. Нийт зөрчлийн 763 буюу 76.5 хувь нь Улаанбаатар хотод, 235 буюу 23.5 хувь нь орон нутагт үйлдэгдсэн гэж бүртгэгджээ.

---oooOooo---